

ДОТООД ХЭРГИЙН ИХ
СУРГУУЛЬ

МОНГОЛЫН
КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2019 №2 (68)
17 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ ЭРХЛЭГЧ

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун Бат-Эрдэнэ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Насанжаргал ГАНБАДРАЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ганбат ЭРДЭНЭБАТ
ДОКТОРАНТ

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН

Бэгзсүрэн Жамсран

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Гэмт хэргийн гаралтад нөлөөлөгч нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн шинжилгээ.....Э.Сугарбаяр, Ц.Батсүх	4
Fear of crime among Mongolians in the Ulaanbaatar metropolitan area: A test of an integrated model.....Chuluunbat Sh, Min-Sik Lee, James Bryan Pattison	14
Монгол Улсын болон БНХАУ дахь хар тамхины талаархи үзэл баримтлал, онцлог.....Б.Алтансүх	26
Сонгинохайрхан дүүрэгт үйлдэгдэж байгаа хулгайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам.....Ц.Мөнгөнзул	34
Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд гадаад худалдааны нөлөөлөх эрсдэл.....С.Урангоо	41
Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах асуудал.....М.Уугантуяа	48
Албан хаагчийн стресс - тогтвортой ажиллагааны талаар онолын зарим асуудал /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн жишээн дээр/.....О.Баяржаргал	57
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Өмчлөх эрхийг хамгаалах эрүүгийн эрх зүйн онолын зарим асуудал.....Ч.Нямсүрэн	61
Эрүүгийн хууль дахь баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээг бусад нөхцөл байдлуудаас ялгах нь.....Л.Бат-Очир	66
ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг.....Т.Мөнхдалай	75
Хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлын үнэлгээний онол, практикийн тулгамдсан зарим асуудал.....Ч.Отгонсүрэн	83
ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Цагдаагийн байгууллагаас олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх аргачлал, анхаарах зарим асуудал.....Ш.Чулуун	89
Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт.....Д.Энхбаяр	100
ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Imposing liability rationale of constitutional law, legal consequences..... Azjargal.T.	106

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТАД НӨЛӨӨЛӨГЧ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

Э.Сугарбаяр, Ц.Батсүх (Ph.D)
Санхүү, эдийн засгийн их сургууль

Товч агуулга: Дэлхийн улсуудын хувьд гэмт хэргийн эсрэг тэмцэх нь томоохон зорилгуудын нэг болоод байна. Монгол Улс гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор 2017 онд гэмт хэргийн цагаан номыг хэвлэн гаргасан билээ. Криминологийн онолд гэмт явдлын шалтгааныг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээр тайлбарлах нь элбэг байдаг. Энэхүү судалгаанд гэмт хэргийн түвшинд ажилгүйдэл, хүн амын нягтрал эергээр, боловсролын түвшин сөргөөр, дотоодын нийт бүтээгдэхүүний уналт эергээр нөлөөлнө гэж таамаглал дэвшүүлэв. Иймээс судалгааны зорилго нь Монгол Улсын аймгуудын гэмт хэргийн түвшинд нөлөөлөгч хүчин зүйлсийг олж тогтооход оршино. Мөн нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцох зорилго тавилаа. Судалгаанд криминологийн шинжлэх ухааны онолыг ашиглаж, Бекерийн загварыг голлон баримтлав. Арга зүйн хувьд хөлгөн өгөгдлийн тогтмол болон санамсаргүй нөлөөний загварыг ашиглахаас гадна хэсэгчлэн засварласан загварыг ашиглалаа. Шинжилгээний үр дүнд нуугдмал гэмт хэргийн түвшин 0.2 гарсан бөгөөд үйлдэгдсэн 10 гэмт хэрэг бүрийн 2 нь л бүртгэгддэггүй байна. Мөн боловсролын түвшин нэмэгдэх нь хүчирхийллийн гэмт хэрэг, өмчийн эсрэг гэмт хэргийг бууруулдаг нь тогтоогдов. Харин хүн амын нягтрал нэмэгдэх нь эдгээр гэмт хэргийг өсгөдөг ажээ.

Түлхүүр үгс: Гэм хэргийн статистик, Панель өгөгдлийн эконометрик, Хэсэгчлэн засварлах загвар, нуугдмал гэмт хэрэг.

Оршил

Дэлхийн банкны ангилснаар дундаас доогуур орлоготой¹ улс орнуудын хувьд 100'000 хүнд ногдох гэмт хэргийн түвшнээр жагсаан харахад Монгол улс Лаос, Киргиз, Пакистан улсуудтай ойролцоо байгаа боловч дунджаас дээгүүр байгаа нь гэмт хэргийн түвшин харьцангуй өндөр гэдэг нь харагдаж байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас өрсөлдөөнт зах зээлд шилжсэн үе болох 1992 оноос 2017 оны хооронд нийт бүртгэгдсэн гэмт хэрэг 32'259 болж 2,6 дахин өсжээ. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь ялган харвал хүний амь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг² 9'533 (29,5%), нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 573, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 18'176 (56,3%), гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 1'286 хэмээн тус тус бүртгэгджээ. Криминологийн шинжлэх ухаанд эдийн засгийн нөхцөл байдал нь гэмт хэргийн түвшинд хүчтэй нөлөөлдөг гэж үздэг бөгөөд Монгол улсын эдийн засаг 2002 онд өсөхөд гэмт хэргийн түвшин буурч, 2015 онд эдийн засаг буурахад гэмт хэргийн түвшин өсөж байгаа нь урвуу хамааралтайг илтгэж байна. Мөн 2005, 2011, 2016 онуудад гэмт хэргийн түвшин хамгийн бага түвшиндээ хүрч, эргэлтийн цэг болж байгаа нь манай улсын гэмт хэрэг 5 жилийн циклгүй илэрхийлж байна. Монгол улсын засаг захиргааны 22 нэгжийн хувьд 10'000 хүнд ногдох гэмт хэргийн тархалтыг 2000, 2017 онуудын хувьд зурж харахад 2000 онд нутгийн зүүн хэсэг болон төвийн хойд хэсгээр гэмт хэргийн түвшин өндөр байсан бол 2017 онд нийт нутгаар буурчээ. Гэвч 2017 оны байдлаар Дархан-Уул, Улаанбаатар, Дорноговь аймгуудад нийт гэмт хэргийн түвшин өндөр хэвээр байгаа нь тэдгээрийг дайран өнгөрөх хатуу хучилттай авто зам, Транс Сибирийн олон улсын төмөр замтай холбоотой байж болох юм. Монгол улсын 21 аймгийн хувьд 2010-2017 оны хоорондох аймгуудын гэмт хэргийн ялгаатай байдлыг сигма конвергенцийн тусламжтай тооцоход 2016 оноос хойш огцом нэмэгдсэн нь харагдав.

¹ Нэг хүнд ногдох ДНБ нь 996 ам.доллаароос 3985 ам.доллар бүхий улс орнууд

² Хүнийг санаатай алах, бусдыг болгоомжгүй алах, амиа хорлох, бусдын бие махбодод гэмтэл учруулах

Энэхүү судалгааны зорилго нь Монгол улсын 21 аймгийн гэмт хэргийн гаралтад нөлөөлөгч хүчин зүйлсийг олж тогтооход орших юм. Судалгаанд Монгол улсын 21 аймгийн 2010-2017 оны гэмт хэрэг, макро эдийн засгийн статистик үзүүлэлтүүдийг ашиглав. Тайлбарлагдагч хувьсагчаар **хүчирхийллийн гэмт хэрэг, өмчийн эсрэг гэмт хэрэг, малын хулгайн гэмт хэргийг** авсан бол тайлбарлагч хувьсагчаар **ажилгүйдэл, дотоодын нийт бүтээгдэхүүн, боловсролын түвшин, малын тоо** зэргийг сонгож авлаа. Энэхүү судалгааны ажлаар дамжуулан Монгол улсын гэмт хэргийн бүтэц, түүнд нөлөөлөгч нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг засаг захиргааны нэгж бүрд зөв тодорхойлсноор гэмт хэргийн түвшинг бууруулахад ач холбогдолтой.

1. Судлагдсан байдал

Монгол Улсын шүүх 2017 онд 3778 эрүүгийн хэргийг шүүж, 4130 хүнийг гэм буруутай гэж үзэн ял эдлүүлээд байгаа билээ. Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо 2016 онтой харьцуулахад 43 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ялаар шийтгүүлэгчдийн ихэнх буюу 1794 нь 18-29 насны залуучууд байна. Иймээс энэ насны онцлогт тохирсон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого явуулах нь оновчтой. Энэхүү гэмт хэргийн өсөлтийн шалтгаан нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн байдал, хямрал, ядуурал юм. Эдгээрээс хамгийн хүчтэй нөлөөлж буй гурван хүчин зүйл нь хүн амын нягтрал, эдийн засгийн хямрал, нийгмийн бусад хүчин зүйлс гэж шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал, доктор Ц.Мандах ярилцлагадаа дурджээ. (Ц.Мандах, 2017)

Левитт судалгаагаар орчин үеийн эконометрикийн техник болох хөлгөн өгөгдлийн тогтмол нөлөөний аргагүйг ашиглан өндөр орлого бүхий 48 улсын³ 1950-1990 оны хоорондох ажилгүйдэл, гэмт хэргийн түвшний хоорондын хамаарлыг тогтоохыг зорьжээ. Тайлбарлагдагч хувьсагчдаар 100'000 хүнд ногдох өмчлөлийн гэмт хэрэг, 100'000 хүнд ногдох хүчирхийллийн гэмт хэргүүдийг авсан байна. Харин тайлбарлагч хувьсагчдаар ажилгүйдлийн түвшин, 1000 хоригдолд ногдох тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээдийн тоо, нэг хүнд ногдох БДНБ, нийт хүн амд эзлэх хар арьстай хүмүүсийн эзлэх хувь, хотжилтын түвшин, нийт хүн амд эзлэх 0-24 насны хүн амын хувь, нийт хүн амд эзлэх 25-44 насны хүн амын хувийг авчээ. Үнэлгээний үр дүнд бүх хувьсагчид 99 хувийн итгэх түвшинд ач холбогдолтой гарсан бөгөөд бодит байдлыг 91 хувьтай тайлбарласан байна. Судалгааны үр дүнд ажилгүйдэл 1 хувиар өсөхөд өмчлөлийн гэмт хэрэг 1,4-2,7 хувиар, хүчирхийллийн гэмт хэрэг 0,5 хувиар өсдөг ажээ. Нэгж хугацааны өмнөх энэ төрлийн гэмт хэрэг хийсэн хэрэгтний тоо 1 хувиар өсөхөд өмчлөлийн гэмт хэрэг 5 хувиар, хүчирхийллийн гэмт хэрэг 2,5 хувиар тус, тус өсдөг байна. Мөн нэг хүнд ногдох ДНБ нь 1 хувиар өсөхөд өмчлөлийн гэмт хэрэг 2,1 хувиар, хүчирхийллийн гэмт хэрэг 4 хувиар өсдөг байна. (Levitt, 2001)

Маддах судалгаа нь Иран улсын мужуудын хувьд ажилгүйдэл, хулгайн гэмт хэргийн хоорондын хамаарлыг тогтоох зорилготой байна. Судалгаанд Иран улсын 15 мужийн 1997-2006 оны хоорондох хөлгөн өгөгдлийг ашиглан авторегрессив шугаман динамик хөлгөн өгөгдлийн загварыг GMM аргагүйгээр үнэлжээ. GMM-ийг логарифм болон логарифм бус хэлбэрээр ашигласан байна. Тайлбарлагдагч хувьсагчдаар 100'000 хүнд ногдох хулгайн гэмт хэргийг авсан бөгөөд үүнийг дотор нь машин, хэрэгслийн хулгай, малын хулгай, орон байрны хулгай, дэлгүүрийн хулгай гэж ангилжээ. Харин тайлбарлагч хувьсагчдаар ажилгүйдлийн түвшин, ядуурлын хувь, нийт хүн амд эзлэх 15-19 насны хүн ам, нийт хүн амд эзлэх 20-24 насны хүн ам, хүн амын нягтралыг тус тус авсан байна. Судалгааны үр дүнд ажилгүйдэл 1 хувиар өсөхөд машины хулгай 0,83 нэгжээр, малын хулгай 0,36 нэгжээр, орон байрны хулгай 0,42 нэгжээр тус, тус өсдөгийг тогтоожээ. Мөн ядуурлын хувь нь гэмт хэргийн төрөл бүрд эергээр нөлөөлдөг бөгөөд хамгийн их буюу дэлгүүрийн хулгайг 1,48 нэгжээр өсгөдөг байна. (Maddah, 2013)

Судлаач Краколиси нь 2008 онд Итали дахь гэмт хэргийн түвшнийг газарзүйн эдийн засгийн аргагүйгээр судалжээ. Өөрөөр хэлбэл Италийн газарзүйн зургийг ашиглан аль хэсэгт ямар төрлийн гэмт хэрэг их гараад байгааг тогтоосон бөгөөд 1999 болон 2003 оны өгөгдлүүдийг ашиглан харьцуулсан байна. Нийт гэмт хэргийг хүн амины гэмт хэрэг, хулгай, залилан, дээрэм, танхай гэсэн 4 төрлөөр авч үзжээ. Судалгааны үр дүнд Италийн зүүн мужуудад хүн амины гэмт хэрэг их гардаг бөгөөд 1999-2003 оны хооронд энэ зураглал өөрчлөгдөөгүй байна. Харин хулгайн гэмт хэрэг нутгийн баруун мужуудад их гардаг бөгөөд

³ Дэлхийн банкны ангилснаар

баруун мужуудад томоохон хот, жуулчдын хөдөлгөөн их байдаг байна. Италийн баруун мужуудаар 1999 онд залилангийн гэмт хэрэг их ба тэр тусмаа нэг хүнд ногдох орлогоороо тэргүүлдэг 4 мужид бүр илүүтэй байжээ. Харин 2003 онд нэг хүнд ногдох орлогоороо тэргүүлдэг эсэхээс үл хамааран энэхүү гэмт хэргийн гаралт Италийг бүхэлд нь хамарч газарзүйн хувьд зүүн мужуудад чиглэсэн байна. Танхайн гэмт хэргийн тархалт нь хүн амины гэмт хэргийн тархалттай яг ижилхэн бөгөөд танхайн хэрэг их газар, хүн амины хэрэг их гардаг байна. Эцэст нь газарзүйн байршил гэмт хэргийн гаралттай холбоотой эсэхийг тогтооходоо жинлэсэн матриц аргагүйг ашигласан бөгөөд корреляцийн утгыг харахад бүгд эерэг хамааралтай байжээ. (Francesca Cracolici, 2008)

2. Онол, арга зүй

Криминологийн шинжлэх ухааны хамгийн алдартай нь Бекерийн онол бөгөөд эдийн засагчид энэхүү онол дээр тулгуурлан криминологийн загварыг илүү хөгжүүлсээр байна. Энэхүү онолд нийгэм, эдийн засгийн янз бүрийн хүчин зүйлүүд гэмт хэргийн тоог тодорхойлдог гэж үздэг ба загварын тавил нь хөдөлмөрийн нийлүүлэлтийн загвартай төстэй юм.

Бекерийн онолоор гэмт хэрэгтэн хүлээгдэж буй ханамжаа хамгийн их байлгахын тулд гэмт хэрэг үйлддэг гэж үздэг бөгөөд ханамжийн функцийг дараах хэлбэрээр дүрсэлсэн байна. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг хийгээд баригдсан болон баригдаагүй үеийн ханамжийн зөрүүгээр шийдвэр гаргадаг.

$$E(U) = PU(Y - f) + (1 - P)U(Y)$$

Үүнд:

P - баригдах магадлал

Y - гэмт хэрэг хийснээр олох мөнгөн орлого

f - торгууль

Браун болон Рейнолдс нар дээрх загварыг цалингийн түвшин, гэмт хэрэг хийсэн тохиолдолд авах өгөөжөөр өргөтгөж доорх хэлбэртэй болгожээ. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтэн баригдсан тохиолдолд орлогоосоо шийтгэлийн мөнгийг хасах бол баригдаагүй тохиолдолд гэмт хэргээс олох өгөөжийг орлого дээр нэмж тооцдог байна.

$$E[U] = PU(w - f) + (1 - p)U(w + g)$$

Үүнд:

w - орлого

g - гэмт хэрэг хийсэн тохиолдолд авах өгөөж

Мөн гэмт хэргийн өгөөжийн хэмжээ өөрчлөгдөхөд гэмт хэргийн тоонд хэрхэн нөлөөлж буйг орлого болон орлуулалтын нөлөөгөөр тайлбарладаг байна. Орлуулалтын нөлөөгөөр гэмт хэргийн өгөөж нь гэмт хэрэг хийгээгүй үеийн өгөөжөөс өндөр бол гэмт хэргийн тоо өсдөг гэж үздэг. Харин гэмт хэргийн өгөөж өндөр байхын хэрээр баригдах магадлал өндөр байдаг. Иймээс гэмт хэрэгтэн баригдах магадлал өндөр учраас гэмт хэргийн тоо буурдаг гэж үздэг орлогын нөлөөгөөр тайлбарладаг байна. Гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гарах өртөг болон цэвэр өгөөжийг харьцуулж гэмт хэрэг үйлдэх эсэхээ шийддэг. Хувь хүний орлогын доод түвшин нь хууль бус үйл ажиллагаа эрхлэхэд гарах алдагдсан боломжийн өртөг юм. Өөрөөр хэлбэл бага орлоготой хүмүүсийн хувьд алдагдсан боломжийн зардал бага учраас илүүтэй гэмт хэрэг үйлддэг байна. Тиймээс гэмт хэрэгтнүүдийн ихэнх хувийг залуучууд, эрэгтэйчүүд, бага цалинтай ажилчид бүрдүүлдэг. Гэмт хэрэг үйлдсэн бүх хүмүүс сэтгэлзүйн хувьд үр ашигтай бөгөөд торгууль, шоронгийн хугацаа зэрэг шийтгэлүүд нь зардлын нэг хэсэг гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэнээс олох өгөөжөөс баригдах магадлалыг баригдсан тохиолдолд гарах зардлаар үржүүлсэн утгыг хасаж, тухайн утга 0-аас их бол гэмт хэрэг үйлдэхээр шийддэг. Учир нь гэмт хэрэг үйлдэх нь илүү үр ашигтайг илтгэж байна.

$$b - pc > 0$$

Гэмт хэрэг нь зах зээлийн нэг хэсэг бөгөөд үүнийг бүрэн арилгахад их хэмжээний зардал шаардагддаг. Гэмт хэрэг нь нэг хэсэг хүмүүст хохиролтой ч өөр хэсэг хүмүүст өгөөжтэй байдаг. Иймээс гэмт хэрэг үйлдэхэд гарах ахиу өгөөж, ахиу зардлын огтлолцлын

цэгээр тэнцвэрт цэг тогтдог байна. Өөрөөр хэлбэл гэмт хэргийг тодорхой түвшинд байх ёстой зүйл гэж үздэг.

3. Шинжилгээний хэсэг

3.1. Өгөгдлийн шинжилгээ

Судалгаанд ҮСХ-ны Монгол улсын 21 аймгийн өгөгдлийг ашигласан бөгөөд эдийн засгийн ямар үзүүлэлтүүд ямар төрлийн гэмт хэрэгт хэрхэн нөлөөлж байгааг харахын тулд нийт гэмт хэргийг **хүчирхийллийн, өмчлөх эрхийн эсрэг, малын хулгай** хэмээн 3 бүлэгт ангиллаа. Судлагдсан байдалд үндэслэн хүн амын ялгаатай байдлыг стандартчилж 10'000 хүнд ногдох гэмт хэргийн түвшнээр тайлбарлагдагч хувьсагчдыг авав.

Хүснэгт 1. Тайлбарлагдагч хувьсагчид

Хувьсагчид	Хугацаа	Эх сурвалж	Тайлбар
Хүний амь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	2010-2017	ҮСХ	Хүний амь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, хүнийг санаатай алах, бусдын бие махбодод гэмт учруулах гэсэн гэмт хэргүүдийг энэхүү төрөлд багтаасан.
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2010-2017	ҮСХ	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, эд хөрөнгийн хулгай, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, мэхлэх болон үрэгдүүлэх гэсэн гэмт хэргүүдийг багтаасан.
Малын хулгай	2010-2017	ҮСХ	Бусдын тэжээмэл мал амьтныг зөвшөөрөлгүй авах, зарах, үрэгдүүлэх

Хүснэгт 2. Тайлбарлагч хувьсагчид

Төрөл	Хувьсагчид	Эх сурвалж	Тайлбар
Эдийн засаг	Нэг хүнд ногдох ДНБ Ажилгүйдэл	ҮСХ ҮСХ	Тухайн бүс нутгийн нэг хүнд ногдох ДНБ Ажилгүйдлийн түвшин, 15 болон түүнээс дээш насныхны ажилгүйдлийн түвшин
Нийгэм	Боловсрол Салалт	ҮСХ ҮСХ	Нийт хүн амд эзлэх 18 болон түүнээс дээш насны ахлах сургуулийн сурагчдын тоо Нийт хүн амд эзлэх салалтын тоо
Хүрээлэн буй орчин	Малын тоо	ҮСХ	Үхрийн тоо
Дэд бүтэц	Байнгын ажиллагаатай хилийн боомттой эсэх	ҮСХ	Тухайн бүс нутаг хилийн боомттой эсэх (тийм-1, үгүй-0)
Хүн ам зүй	Нийт хүн амын тоо	ҮСХ	Тухайн бүс нутаг дахь хүн амын тоо

3.2. Хэсэгчлэн засварласан загварын шинжилгээ

Энэхүү загвараар Монгол улсын гэмт хэргийн потенциал утгыг тооцож, түүнээсээ бүртгэгдсэн гэмт хэргийг хасах замаар нуугдмал гэмт хэргийн түвшинг тогтоох юм. Криминологийн ихэнх судалгаануудад ажилгүйдэл нь гэмт хэргийн өсөлтөд нөлөөлөгч гол хүчин зүйл болдог тул тайлбарлагч хувьсагчаар ажилгүйдлийн түвшинг авав. Хэсэгчлэн засварласан загварын үнэлгээний үр дүн доорх хэлбэртэй гарсан бөгөөд 10 гэмт хэрэг тутмын 2 нь бүртгэгдээгүй нуугдмал хэлбэрээр хадгалагддаг ажээ.

$$\ln(\text{Crime}_t) = 0.88 + 0.008 * \text{unemp}_{t-1} + 0.8 * \ln(\text{crime}_{t-1}) + u_t$$

(0.77) (0.007) (0.15)

$R^2 = 0.66$ $F_{stat} = 13.6$ $P_{value} = 0.0005$ $DW = 1.44$

3.3. Хөлгөн өгөгдлийн шинжилгээ

Бидний сонгосон 5 тайлбарлагч хувьсагчид хүчирхийллийн гэмт хэргийг 80 хувьтай тайлбарлаж байгаа бөгөөд 99 хувийн итгэх түвшинд статистикийн хувьд ач холбогдолтой байна. Нийт хүн амд эзлэх ахлах сургууль төгссөн хүний тоо нэмэгдэх нь хүчирхийллийн гэмт хэргийг бууруулдаг байна. Харин тухайн нутаг дэвсгэрт хүн амын нягтрал өндөр байх нь хүчирхийллийн гэмт хэргийг өсгөдөг ажээ.

Мөн эдгээр 5 тайлбарлагч хувьсагчид нь өмчийн эсрэг гэмт хэргийг 74 хувьтай тайлбарлаж байгаа бөгөөд 99 хувийн итгэх түвшинд статистикийн хувьд ач холбогдолтой байна. Нийт хүн амд эзлэх ахлах сургуулийн боловсролтой хүний тоо нэмэгдэх нь өмчийн эсрэг гэмт хэрэгт сөргөөр нөлөөлдөг байна. Мөн дотоодын нийт бүтээгдэхүүн, хүн амын нягтрал өндөр байх нь өмчийн эсрэг гэмт хэргийг нэмэгдүүлдэг бөгөөд хүн амын нягтрал нь дотоодын нийт бүтээгдэхүүнээс илүү хүчтэй нөлөөлдөг нь харагдав.

Харин эдгээр 5 хувьсагч малын хулгайн гэмт хэргийг санамсаргүй нөлөөний загвараар илүү тайлбарлаж байсан бөгөөд бодит байдлыг 53 хувьтай тайлбарлаж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн өндөр аймгуудад малын хулгайн гэмт хэрэг илүү гардаг нь ажиглагдав. Яагаад гэвэл дотоодын нийт бүтээгдэхүүний ихэнх хувийг хөдөө аж ахуйн сектор бүрдүүлж байгаа бөгөөд хөдөө аж ахуйн секторын эзлэх хэмжээ том байна гэдэг нь малын тоо толгой их байгааг гэдгийг илэрхийлнэ.

Хүснэгт 3. Хөлгөн өгөгдлийн үнэлгээний үр дүн, мультиколлинеаргүй

	FE			RE		
	Log(Huchir)	Log(Omch)	Log(Mal)	Log(Huchir)	Log(Omch)	Log(Mal)
Unemp	-0.108 (0.092)	-0.152 (0.105)	0.079 (0.16)	-0.112 (0.094)	-0.176 (0.109)	0.056 (0.16)
Log(Pop)	-1.078*** (0.044)	-1.046*** (0.05)	-1.031*** (0.076)	-1.075*** (0.045)	-1.042*** (0.052)	-1.027*** (0.077)
Log(Educ)	-0.145** (0.066)	-0.231*** (0.075)	0.091 (0.114)	-0.081 (0.063)	-0.136* (0.072)	0.11 (0.109)
GDP	0.0001 (0.0001)	0.0025* (0.0017)	0.0046* (0.0025)	0.0001 (0.0001)	0.0025 (0.0017)	0.0044* (0.0026)
Nyutral	0.009* (0.006)	0.012* (0.007)	0.013 (0.01)	0.003** (0.001)	0.004*** (0.001)	-0.003 (0.003)
N	168	168	168	168	168	168
R ²	0.81	0.76	0.57	0.78	0.72	0.54
AR ²	0.78	0.72	0.49	0.77	0.71	0.52
F stat	124.8	91.19	38.39	155.88	83.6	38.31
P_value	0.00	0.00	0.00	0.000	0.00	0.00
Hausmen	0.000	0.00	0.36			
test P_value						

Дээрх үнэлгээний үр дүнг нэгтгэвэл боловсролын түвшин өсөх нь нь гэмт хэргийн гаралтыг бууруулдаг боловч өмчийн эсрэг гэмт хэрэгт илүү хүчтэй нөлөөлдөг байна. Өөрөөр хэлбэл хүн боловсрол эзэмшсэнээр хүчирхийлэл үйлдэхээс илүү хулгай дээрэм, залилан хийх нь илүү буруу зүйл гэдгийг ойлгож авдаг байна. Энэ нь гэмт хэргийн онцлогтой холбоотой байж магадгүй. Учир нь гэмт хэрэгтэн өөрийн хүсэл, сонирхлын хүрээнд хүчирхийллийн гэмт хэргийг үйлддэг бол ядуурал, мөнгөний дутагдал, ажилгүйдэл зэрэг гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр өмчийн эсрэг гэмт хэрэг үйлдэгддэг байна. Мөн хүн амын нягтрал өсөх нь гэмт хэргийн түвшинг нэмэгдүүлдэг гэдэг нь үнэлгээнээс гарч байна. Хүн ам их байх нь гэмт хэрэгтний баригдах магадлалыг бууруулдаг учраас гэмт хэрэгтний гэмт хэрэг үйлдэх сэдлийг өдөөдөг ажээ. Тэр тусмаа хулгай, дээрэм, залилангийн гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлдэг байна. Харин эдийн засаг өсөх нь хүчирхийллийн гэмт хэрэгт нөлөөгүй боловч, өмчийн эсрэг гэмт хэргийг өсгөдөг нь харагдав. Өөрөөр хэлбэл эдийн засаг өсөлттэй үед хүмүүсийн тансаг хэрэглээний бараа нэмэгдэж, гэмт хэрэгтний ахиу өгөөжийг нэмэгдүүлэх учраас хулгай, дээрмийн гэмт хэргийг өсгөдөг байна.

Дүгнэлт

Криминологийн шинжлэх ухааны судлаачид Бекерийн загвар дээр үндэслэн судалгаа хийдэг. Тус загварт хувь хүн ахиу орлого, ахиу зардлын харьцуулалтын үр дүнд гэмт хэрэг хийх эсэхээ шийддэг бөгөөд нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс шийдвэр гаргалтад нөлөөлдөг гэж үздэг. Иймээс гэмт хэрэгтэн рационал биш гэж үздэг. Энэ төрлийн судалгаануудад ахиу өгөөж, ахиу зардлын муруйг шилжүүлэгч, гэмт хэргийн гаралтад нөлөөлөгч хүчин зүйлсийг судалж, хөлгөн өгөгдлийн аргазүйг ашигладаг байна.

Монгол улс 100'000 хүнд ногдох гэмт хэргийн тоогоороо дундаас доогуур орлоготой улсуудын дунджаас өндөр байгаа бөгөөд сүүлийн 15 жилийн дотор нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2 дахин нэмэгдсэн байна. Үүний 60 орчим хувийг өмчийн эсрэг гэмт хэрэг дангаар эзэлдэг ажээ. Мөн аймгуудын гэмт хэргийн ялгаатай байдал 2011 оноос хойш огцом нэмэгдсэн төдийгүй гэмт хэргийн гүнзгийрэлтийн тархалт харьцангуй баруун бүс рүү шилжсэн байна.

Судалгааны үр дүнд Монгол улсын нуугдмал гэмт хэргийн түвшин 0.2 бөгөөд үйлдэгдсэн 10 гэмт хэрэг тутмын 2 нь бүртгэгддэггүй байна. Боловсролын түвшин өсөх нь хүчирхийллийн болон өмчийн эсрэг гэмт хэргийг хоёуланг нь бууруулдаг боловч өмчийн эсрэг гэмт хэргийг хүчирхийллийн гэмт хэргээс 1.6 дахин их хэмжээгээр бууруулдаг байна. Өөрөөр хэлбэл боловсролын систем нь хүнд хулгай, дээрмийг хийх нь буруу гэдгийг илүүтэй ойлгуулдаг ажээ. Энэ нь боловсролын түвшин гэмт хэргийн гаралтыг бууруулдаг хэмээх таамаглалыг дэмжиж байна.

Мөн хүн амын нягтрал нэмэгдэх нь дээрх 2 төрлийн гэмт хэргийг өсгөдөг бөгөөд хүн ам ихтэй газруудад гэмт хэргийн гаралт их байдаг гэсэн таамаглалыг дэмжиж байна. Эдийн засаг өсөлттэй үед хүчирхийллийн гэмт хэрэг нэмэгддэггүй ч, өмчийн эсрэг гэмт хэрэг нэмэгддэг байна. Учир нь эдийн засаг өсөлттэй үед хүмүүсийн хэрэглээ, тэр тусмаа чамин зүйлсийн хэрэглээ өсөж, хулгай хийх сэдлийг төрүүлдэг байх магадлалтай юм.


Эцэст нь дүгнэхэд гэмт хэргийн түвшинг буулгахын тулд эдийн засгийг дэмжихээс илүүтэй нийгмийн хүчин зүйлсийг сайжруулснаар гэмт хэргийн түвшинг илүү их хэмжээгээр бууруулах боломжтой юм. Өөрөөр хэлбэл Монгол улсын 21 аймаг дахь боловсролын түвшинг өсгөх, цаашлаад боловсролын чанарт анхаарал хандуулах хэрэгтэй. Энэхүү судалгааг цаашид дүүргүүдийн өгөгдлийг оруулж, динамик хөлгөн өгөгдлийн аргазүйг ашиглан илүү сайжруулах боломжтой.

Эх сурвалжийн жагсаалт

- Baharom, A. (2008). Crime and Income Inequality: The Case of Malaysia. MPRA, 16.
- Cracolici, M. F. (2008). Geographical Distribution of Crime in Italian Provinces: A Spatial Econometric Analysis. 30.
- Elghandour, N. (2016). Economics of Crime in the USA: Panel data analysis (1980-2014). 31.
- Gentry, B. (2016). Impact of Educational Attainment on Crime in the United States: A Cross Metropolitan Analysis. 38.
- Janko, Z. (2013). The Short-Run and Long-Run relationships between Mortality and the Business Cycle in Canada. 12.
- Khan, N. (2015). The Socio-Economic Determinants of Crime In Pakistan: New Evidence on an Old Debate. *ARAB ECONOMICS AND BUSINESS JOURNAL*, 9.
- Levitt, S. (2001). The impact of legalized abortion on crime. *The quarterly journal of economics*, 42.
- Mulok, D. (2016). The Relationship between Crime and Economic Growth in Malaysia. 26.
- Recher, V. (2016). Relationship between Unemployment and Crime in Croatia. 29.
- S.Becker, G. (1974). *Crime and Punishment: An Economic Approach*. Chicago: NBER.

Хавсралт


Хавсралт 1. 100'000 хүнд ногдох гэмт хэргийн түвшин




Эх сурвалж: Дэлхийн банкны цахим сайт 2018

Хавсралт 2. Эдийн засаг болон гэмт хэргийн хамаарал

Хавсралт 3. Нийт гэмт хэргийн түвшин




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хавсралт 4. 10'000 хүнд ногдох гэмт хэргийн түвшин, аймгаар




Эх сурвалж. Үндэсний Статистикийн хороо

Хавсралт 5. 10'000 хүнд ногдох гэмт хэргийн түвшин, төрлөөр 2017


Хүний амь, эрүүл мэндийн гэмт хэрэг




Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг



Тээврийн хэрэгслийн гэмт хэрэг



Малын хулгайн гэмт хэрэг



Эх сурвалж. Үндэсний Статистикийн Хороо

Хавсралт 6. PAM загварын үнэлгээ

Dependent Variable: LOG(CRIME1)				
Method: Least Squares				
Date: 12/23/18 Time: 00:04				
Sample (adjusted): 2001 2017				
Included observations: 17 after adjustments				
Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	0.888602	0.774215	1.147746	0.2703
UNEMP(-1)	0.008405	0.007487	1.122565	0.2805
LOG(CRIME1(-1))	0.807726	0.155042	5.209717	0.0001
R-squared	0.660677	Mean dependent var		4.899438
Adjusted R-squared	0.612202	S.D. dependent var		0.135670
S.E. of regression	0.084487	Akaike info criterion		-1.945662
Sum squared resid	0.099932	Schwarz criterion		-1.798625
Log likelihood	19.53813	Hannan-Quinn criter.		-1.931046
F-statistic	13.62932	Durbin-Watson stat		1.442437
Prob(F-statistic)	0.000518			

Хавсралт 7. Хүчирхийллийн гэмт хэрэг тогтмол нөлөөний загвар

Oneway (individual) effect Within Model
Call: plm(formula = y ~ x, data = pdata, model = "within")
Balanced Panel: n = 21, T = 8, N = 168
Residuals:

Min. 1st Qu. Median 3rd Qu. Max.
 -0.3171490 -0.0429989 0.0062053 0.0489086 0.2314078

Coefficients:

	Estimate	Std. Error	t-value	Pr(> t)
xUNEMP_ZALUU	-1.0754e-01	9.1596e-02	-1.1740	0.2423
xLOGHUNAM	-1.0784e+00	4.3722e-02	-24.6655	<2e-16 ***
xLOGEDUC	-1.4463e-01	6.5524e-02	-2.2073	0.0289 *
xGDP1	1.9536e-07	1.4590e-07	1.3390	0.1827
xNYGTRAL	9.3854e-03	5.8220e-03	1.6121	0.1092

Signif. codes: 0 '***' 0.001 '**' 0.01 '*' 0.05 '.' 0.1 ' ' 1

Total Sum of Squares: 7.2644

Residual Sum of Squares: 1.3468

R-Squared: 0.8146

Adj. R-Squared: 0.78195

F-statistic: 124.779 on 5 and 142 DF, p-value: < 2.22e-16

Хавсралт 8. Өмчийн эсрэг гэмт хэрэг тогтмол нөлөөний загвар

Oneway (individual) effect Within Model

Call:

plm(formula = y ~ x, data = pdata, model = "within")

Residuals:

Min. 1st Qu. Median 3rd Qu. Max.
 -0.2286650 -0.0769947 -0.0034128 0.0767364 0.2250586

Coefficients:

	Estimate	Std. Error	t-value	Pr(> t)
xUNEMP_ZALUU	-1.5193e-01	1.0488e-01	-1.4486	0.149661
xLOGHUNAM	-1.0456e+00	5.0065e-02	-20.8849	< 2.2e-16 ***
xLOGEDUC	-2.3095e-01	7.5029e-02	-3.0781	0.002501 **
xGDP1	2.5470e-07	1.6706e-07	1.5246	0.129585
xNYGTRAL	1.1557e-02	6.6665e-03	1.7335	0.085174 .

Signif. codes: 0 '***' 0.001 '**' 0.01 '*' 0.05 '.' 0.1 ' ' 1

Total Sum of Squares: 7.4363

Residual Sum of Squares: 1.7659

R-Squared: 0.76252

Adj. R-Squared: 0.72072

F-statistic: 91.1915 on 5 and 142 DF, p-value: < 2.22e-16

Хавсралт 9. Малын хулгайн гэмт хэрэг санамсаргүй нөлөөний загвар

Oneway (individual) effect Random Effect Model
 (Swamy-Arora's transformation)

Call:

plm(formula = y ~ x, data = pdata, model = "random")

Effects:

	var	std.dev	share
idiosyncratic	0.02892	0.17005	0.19
individual	0.12368	0.35168	0.81
theta:	0.8315		

Residuals:

Min. 1st Qu. Median 3rd Qu. Max.
 -0.52025033 -0.10215146 -0.00033942 0.10995873 0.38903211

Coefficients:

	Estimate	Std. Error	t-value	Pr(> t)
(Intercept)	5.3210e+00	5.2061e-01	10.2208	< 2e-16 ***
xUNEMP_ZALUU	5.6032e-02	1.6009e-01	0.3500	0.72680
xLOGHUNAM	-1.0265e+00	7.6508e-02	-13.4170	< 2e-16 ***
xLOGEDUC	1.1000e-01	1.0935e-01	1.0060	0.31592
xGDP1	4.3878e-07	2.5571e-07	1.7159	0.08809 .
xNYGTRAL	-3.3411e-03	2.9062e-03	-1.1496	0.25199

Signif. codes: 0 '***' 0.001 '**' 0.01 '*' 0.05 '.' 0.1 ' ' 1

Total Sum of Squares: 10.341

Residual Sum of Squares: 4.738

R-Squared: 0.54184

Adj. R-Squared: 0.52769

F-statistic: 38.3169 on 5 and 162 DF, p-value: < 2.22e-16

**FEAR OF CRIME AMONG MONGOLIANS IN THE ULAANBAATAR METROPOLITAN AREA:
A TEST OF AN INTEGRATED MODEL
УЛААНБААТАР ХОТЫН ОРШИН СУУГЧДЫН ГЭМТ ХЭРГЭЭС АЙХ АЙДАС:
НЭГДМЭЛ ЗАГВАРЫН ШИНЖИЛГЭЭ**

Chuluunbat Sh, PhD,

Chair, Department for Military Engineering, University of Internal Affairs

Min-Sik Lee, PhD, Professor

Chair, Department of Police Administration, Kyonggi University, South Korea

James Bryan Pattison, PhD, Professor

Department of Police Administration, Keimyung University, South Korea

Abstract: This study is about fear of crime, which is one of the most important topics in the criminological research. The study tested an integrated model in structural equation modeling method by using both SPSS 19.0 and Amos 19.0. Those who perceive higher levels of incivility were found to be more fearful of crime. Policies to reduce fear of crime and implications for future research were discussed based on the findings.

Keywords: Fear of Crime, Integrated Model, Police implications

Товч агуулга: Иргэдийн гэмт хэргээс айх айдсын талаар судлах нь криминологийн шинжлэх ухаанд чухал байр суурийг эзэлдэг. Энэхүү судалгааны ажил нь иргэдийн гэмт хэргээс айх айдас, түүний шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлийг зөв олж танихад чиглэгдсэн бөгөөд онолын үндэслэл бүхий нэгдмэл загварыг боловсруулж, харилцан хамаарлыг нь SPSS 19.0, Amos 19.0. программыг ашиглан тооцоолсон. Улаанбаатар хотод оршин суугч иргэдийн гэмт хэргээс айх айдсын суурь шалтгаан нь “амьдарч буй орчны эмх цэгцгүй байдал” болохыг судалгаагаар нотолсон болно. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, зөвлөмж болон энэ чиглэлийн судалгааны ажилд анхаарах онолын асуудлуудыг судлаачийн байр сууринаас хөндөн дэвшүүлээ.

Түлхүүр үгс: гэмт хэргээс айх айдас, нэгдмэл загвар, хэрэгжүүлэх арга хэмжээ

1.Introduction

Mongolia made its transition from the socialist society into a capitalism-based democratic society by changing the Mongolian Constitution in 1992. Transitional societies which have moved from authoritarian forms into democracies have experienced increases in crime levels and problems with police reform (Bayley, 1999; Jang et al., 2015; Shaw, 2002). Since 1990, after sudden transition to the democracy, social disorganization has accelerated rapidly in Mongolia. Social changes appear to be related to a rapid increase of crime rates. As Shaw (2002) noted, a rise of crime in periods of transition is a complex phenomenon and it's difficult to analyze because comparable statistical data on the levels of crime before and after the transition are difficult to come by, and when available, their accuracy may be open to question.

Most studies on fear of crime have been conducted in the United States and other Western countries, as well as some East Asian countries, including China, South Korea, and Japan. As an initial effort, this study focused on to disclose an understanding of fear of crime among Mongolian citizens. Research on fear of crime has not been broadly studied in Mongolia. Additionally, Mongolia has no long tradition of participating in international crime victim surveys nor has a regular program for national crime victim surveys. However, there are some studies in a descriptive format. For instances, Nyamsuren (2005) noted that the result of the crime victimization research from 2003 showed that actual criminal victimization is 2.5-3 times higher than registered crime rates documented by the National Police Agency. Davaa and Altangerel (2015) provided a comparative analysis on general fear in various categories in the Mongolian society. Final result showed that 32.6 percent of peoples are afraid of crime and 57.4 percent are afraid of strangers in their society. Recently Chuluunbat and Lee (2016) reported two separate studies titled “Fear of Crime in a Transitional Society: The Case of Mongolian Citizens” (2016) and “Fear of crime among Mongolian Immigrants in Seoul, Korea” (2016).

As a result of modernization and urbanization processes in this metropolitan city of Mongolia, it also experiences a great increase in crime to the point that more than a half of entire registered crime in Mongolia is occurring in this capital city. The average of index crime rates per 100,000 for the entire nation was 769 within 2003 and 2014 and for the same period of time the

index crime rate for Ulaanbaatar metropolitan area was 975. Official data show significantly high volume of crime in the capital city more than in any other areas throughout the country. According to the MNPA report (2015), on the average 54.2 percent of entire registered crimes between 2003 and 2014 were committed in the Ulaanbaatar metropolitan area only. In this situation, the topic of fear of crime in Mongolian context is quite timely and suitable to deal with.

The importance of the current study is that it is the first attempt in Mongolian context to explain fear of crime and to test an integrated model using the first scientific crime victimization survey data, which was collected from interviews with 683 citizens of the Ulaanbaatar metropolitan area. Moreover, this study is the first report to testify the mediating effects of collective efficacy and behavioral adaptation on the relationships between perceived incivility and fear of crime in an East Asian country.

2.Literature review

2.2. Conceptual models of fear of crime: The literature on the fear of crime has a substantial and significant history, with an increased presence since the 1960s (Grubb & Bouffard, 2014; Hale, 1996) which has been received significant attention from researchers and policy makers more than five decades. Researchers have developed several distinct models to explain factors and predictors of fear of crime (McGarrell et al., 1997; Taylor & Hale, 1986). These models have emerged as the most prominent explanations of fear of crime (Taylor & Hale, 1986), including victimization, disorder, and community concern/control, risk interpretation models. Among these four models, most traditional, victimization model mainly focused on direct relation between direct or indirect experiences with crime and fear, whereas the disorder model identified physical and social characteristics of communities as significant predictors of fear of crime. The community concern/control model proposes perceptions of the deterioration of social control in the community as a main cause on fear (Hwang, 2006) and community residents, local police, and other public service providers as significant predictors to fear of crime (McGarrell et al., 1997; Skogan & Maxfield, 1981; Taylor & Hale, 1986). Finally, a multi-item, and emotional measure of fear of crime model, 'the risk interpretation model' proposed by Ferraro (1995), considered both on macro and micro conditions, as well as perceived risk and behavioral adaptation as causal predictors on fear.

The victimization model: This model initiated the direct relationship between victimization and fear (Hale, 1996). According to the victimization model, fear of crime is explained as the result of experiences of victimization which are direct and indirect (Skogan and Maxfield, 1981). This model attempts to address the effect of personal experience of victimization and vicarious experiences with victimization through stories of people they know or the media (Hale, 1996; Hayman, 2011; Hwang, 2015, Sookram *et al.*, 2011). Some scholars reported prior victimization is directly related on fear (Hale, 1996; Ollenberger, 1981; Skogan and Maxfield, 1981), but other researchers noted previous victimization is related weaker (Garofalo, 1979; McGarrell *et al.*, 1997). Moreover, some researchers reported stronger relationship between fear and indirect victimization. Taylor and Hale (1986) reported that "indirect victimization perspective, for specifying the crime-fear linkage, despite recognition that connection is not straightforward, is the key focus."

The disorder/incivility model: "Fear of crime is actually presentation of incivilities or disorder" (Hale, 1996). The disorder/incivility perspective emphasizes the relationship between social and physical incivilities and crime. Social disorder is a behavior or situation that people can see and experience, such as public drinking, loud parties, prostitution, panhandling, and drug dealing in the street, etc., whereas physical disorder involves visual signs of negligence and unchecked decay, such as abandoned or ill-kept buildings, broken streetlights, lots filled trash or graffiti, and alleys strewn with garbage (Hwang, 2015; Karakus *et al.*, 2010; LaGrange *et al.*, 1992; Ross and Jang, 2000; Skogan, 1990). The thesis that perceived disorders in the neighborhood increase fear of crime has been widely supported (Franklin *et al.*, 2008; Gibson *et al.*, 2002; Hale, 1996; McGarrell *et al.*, 1997).

The community concern/control model: "The idea that explanations for crime itself may be found in loss of social control, both formal and informal, at the neighborhood level has a long and respectable history" (Hale, 1996). In prior studies, social disorganization theory (Shaw and McKay, 1942) has equally explained crime and delinquency and fear. Several studies show erosion of social control (Franklin *et al.*, 2008), social instability, and moral decline (Gainey *et al.*, 2011) facilitate fear of crime while social ties or social integration (Gibson *et al.*, 2002; Lewis and

Salem, 1986), neighborhood collective efficacy (Gibson *et al.*, 2002), and confidence in the local police (McGarrell *et al.*, 1997) inhibit fear of crime.

The Risk Interpretation Model: The risk interpretation model is “the result of the ten-years research odyssey examining the phenomenon of fear of crime” (Ferraro, 1995), due to extend the inquiry beyond the question, ‘why the elderly is so fearful of crime’ even their actual perceived risk is low’. His model was unique for using concepts and variables from macro and micro levels of sociological analysis in an integrated framework, more comprehensive than three separate models by Taylor and Hale (1986) and parsimonious (Lee, 1998). Major factors of his model were risk assessment and behavioral adaptations. Moreover, a few advantages has in Ferraro’s model, first, systemized interpretive processes by distinguishing judgments of risk from feeling of fear, as two distinct perceptions, second, included a consideration of the effects of objective environmental factors such as crime rates and other community characteristics while compounding perceptions of neighborhood incivilities, third, his model concerned with the effect of behavioral adaptations as another possible reaction to perceived risk (Lee, 1998).

The Vulnerability Thesis: Research on demographics of fear has been related to vulnerability which is those who feel more likely vulnerable to crime are more likely to be fearful. Substantial studies have reported that women and older people are more likely feel fearful of crime (Gainey *et al.*, 2011; Hindelang *et al.*, 1978; Kennedy & Silverman 1985; Taylor & Hale, 1986; Warr, 1984). The concept of perceived vulnerability has been categorized into physical and social vulnerability. Physical vulnerability pertains to the perception of increased risk to physical assault (Franklin *et al.*, 2008) and generally measured based on demographic characteristics (Skogan & Maxfield, 1981). Social vulnerability assumes that those who live in disadvantaged area (Pantazis, 2000; Skogan & Maxfield, 1981) such as high-crime neighborhoods and economically distressed would be vulnerable because of their everyday life.

The Broken Windows Theory: The broken windows theory was originally came from a seminal article by James Q. Wilson and George Kelling, which was published in the Atlantic Monthly, 1982. They advanced Shaw and McKay’s (1942) idea and pointed out that the police organization could more effectively fight against crime by focusing on even more minor annoyances which suffering in the communities. Moreover, a broken windows theory argues that a single broken window left untended is a sign that nobody cares and it invites more broken windows. And disorderly behavior left untended is a sign of ignorance and it leads to fear of crime. Wilson and Killing (1982) reported in their classical work that physical and social incivilities are strong positive relationships with fear of crime.

3. Research methods

3.1. Research purpose: This study is about fear of crime, which is one of the most important topics in the criminological research. Fear of crime is an important issue as it is not limited to the individual psychological safety but expands to the emotional well-being and even to life satisfaction. This study has two objectives. First, we try to testify and compare some conceptual models of fear of crime Disorder, Community concern, Victimization, and Risk interpretation, as well as, Vulnerability thesis and Broken windows theory. Second, testify the mediating effects of collective efficacy and behavioral adaptation on the relationships between perceived incivility and fear of crime.

3.2. Sampling and data: This study used a data from the survey titled as a “Crime Victimization Survey”. The survey was implemented in the Ulaanbaatar city, Mongolia, during September, 2015 by utilizing a stratified random sampling method. The Ulaanbaatar is the largest city of Mongolia, with 1.3 million populations which is almost a half of populations is living now (Mongolian National Statistics Office, 2014). The Ulaanbaatar metropolitan area is administratively divided into nine districts: Baganuur, Bagakhangai, Bayanzurkh, Bayangol, Chingeltei, Khan-Uul, Nalaikh, Songino-Khairkhan, and Sukhbaatar. Additionally, each district is subdivided into several Khorooos (Sub-District) and there are 138 khorooos in total within the nine. Researchers selected six most densely populated districts out of nine. After selecting districts, researchers selected five main khorooos from each district. The survey was based on both door-to-door interview and paper and pencil survey method with family members 14 years of age and above.

Before conducting the survey a short term advisory-training was provided to the research staffs, in order to ensure the quality of the survey. The survey contains approximately 80 items questionnaire based on a developed review of International Crime Victim Survey. The

questionnaire were originally built up in English and translated into Mongolian language by bilingual scholars and reviewed by university level linguists. Lack of the previous studies, scholars faced some difficulties in translating specific definitions and proper naming of some variables in Mongolian language. The survey was conducted about 25 days. A total of 700 responds gathered, however 17 of them were substituted due to of the quality.

3.3. Variables and Measurements: As a recommendation, this study conducted Exploratory Factor Analysis (EFA) for examining construct validities and construct equivalences. As Kline (1994) suggested, a moderately high value of 0.30 is the cut-off value for the accepted factor loading with varimax rotation employed in this study (Cheung et al., 2003). Respective varimax rotation is an orthogonal rotation technique which aimed to maximizing the sum of variances of squared loadings in the columns of the factor matrix. The Cronbach's α scores in each factor were higher than the recommended 0.70 cut-off value (Nunnally & Bernstein, 1994) and all results indicating that the measurement scales employed in the model can be considered to be a valid operationalization of the latent construct.

3.3.1. Dependent variable: The dependent variable of the current study is fear of crime. The study deployed the global measures of fear of crime. Fear of crime *at home* was measured using the question "How much are you fearful in each situation?-When I am staying home alone at night". It was measured based on the five points scale, 1=strongly not fearful, 2=not fearful, 3=neutral, 4=fearful, and 5=strongly fearful. Fear of crime *on the street* was measured using the question "How much are you fearful in each situation?-When I am walking alone on the neighborhood street at night". It was measured based on the five points scale. The Cronbach's alpha for the scale was .774. Exploratory factor analysis with varimax rotation method also showed that these two items were associated with single latent construct (factor loadings .903).

3.3.2. Independent Variables: This study included independent variables of perceived incivility, victimization, collective efficacy, behavioral adaptation, and control variables of age and gender.

The Perceived incivility is a factor-based scale, which is a measure of citizens' perceptions in their neighborhood, about physical and social incivilities. The following six survey items were used to reflect both physical and social incivilities: For *the physical incivility*: 1) My neighborhood is dirty with rubbish; 2) There are many dark and ignored places; 3) There are empty buildings and neglected cars; For *the social incivility*: 1) There are many people breaking basic orders (ex, jaywalking, illegal parking); 2) I often see groups of delinquent juveniles wandering around; 3) I often see people fighting or quarreling. Each item was measured based on the five points scale: 1=strongly disagree, 2=disagree, 3=neutral, 4=agree, and 5=strongly agree. The perceived incivility scale was alpha of .779. Exploratory factor analysis with varimax rotation method indicated that these items were associated with single latent construct (factor loadings >.648).

The Direct Victimization experiences are divided into two categories, property and violent crime victimization, during the past one year (2014). The dummy-coded four items-fraud, theft, burglary, vandalism - are added for *the property crime victimization* variable, while the other dummy-coded four items-assaulted/threatened/robbed at places, assaulted/threatened/robbed with tools, assaulted/threatened/robbed by acquaintances, and unwanted sexual contact by force-are added for *the violent crime victimization* variable. Respondents were asked to indicate their experiences based on the scale yes=1, no=0. The scale of Cronbach's alpha .675 and the exploratory factor analysis with varimax rotation method indicated factor loadings of >.445.

- Сэтгэцийн хосолмол үйлчилгээтэй буюу дээрх шинж тэмдгүүдийн аль алиныг нь үзүүлэх үйлчилгээтэй бодис гэж тус тус ангилна.

¹⁶ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий ба тусгай анги /тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ.,2011. 482-483 дахь тал

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэд хэдэн төрөл ангилал байдаг. (товчоор “хяналттай бодис” гэж нэрлэж болох юм). Хяналттай бодисын бололцоотой ангиллын нэг нь химийн бүтцээр нь ангилах явдал юм. Энэ тохиолдолд тэдгээрийг молекулных нь байгууламжаар нь хэсэг болгож хуваадаг.

Энэ ангиллын дагуу хамгийн чухал бүлгийн гол нь амфетамин ба түүний дайварт бензодиазепин, барбитуратын хүчлийн дайварууд, триптамины дайврууд, фенциклидин ба түүний дайвар, морфин ба түүний дайвар гэх мэт бодисууд багтдаг. Гэвч ийм ангилал нь бага зэргийн болхидуу ангилалд орох бөгөөд эдгээр бодисуудыг хэт олон хэмжээний бүлэгт хуваах шаардлага үүсдэг байна. Түүнчлэн зарим бодисуудыг аль нэг тодорхой бүлэгт багтаах боломжгүй байдаг.

Зарим судлаачдын үзэж байгаагаар хамгийн энгийн бөгөөд зөв оновчтой ангилал бол бие махбодод эмийн үйлчилгээ талаасаа хэрхэн нөлөөлж байгаагаар ангилах явдал юм. Энэ тохиолдолд хяналттай бүх бодисууд 6 хэсэгт хуваагддаг¹⁷. Үүнд:

- 1.Опиоид;
- 2.Каннабисаас гаргаж авсан хар тамхины бодис;
- 3.Өдөөгч, амфетамин;
- 4.Сэтгэцэд нөлөөт;
- 5.Тайвшруулах бэлдмэл болон транквилизатор;
- 6.Хяналтад байдаг бусад бодис гэх мэт.

Зарим бодис хүний биед багц гаж нөлөө үзүүлдэг учраас дээрх хэлбэрээр хуваах нь арай буруу юм. Жишээ нь: фенцикладин өвчин намдаах үйлчилгээтэй бас мансуурахад хүчтэй нөлөө үзүүлдэг бөгөөд хар тамхичид үүнийг мансуурах хэлбэрээр хэрэглэдэг.

Амфетамины дайвар нь (ДОБ) мансууруулах болон өдөөх үйлчилгээтэй.

Опиодын төрлийн хэсэгт дараах бодисууд ордог. Огий, макын дэрс, макын дэрсийн ханд, хандалж шингэрүүлсэн огий, морфин, кодеин, героин, метадон, гидроморфин, петидин, тримеперидин (промедол), фентанилболон түүний дайврууд, гидрокодон, пентазоцин, эксикодон, оксиморфон, пропоксифен гэх мэт ангилж үздэг.

Хэрэглэж буй аргаар нь:

1. Татах
2. Судсаар
3. Уурыг нь сорох
4. Үнэрлэх
5. Уух
6. Идэх
7. Наах гэх мэт ангилан үздэг.

Каннабисаас гаргаж авсан мансууруулах бодисонд марихуан, гашиш, гашишын тос ордог. Амфетамины өдөөгч ба түүний дайврын бүлэгт кокаин (крэк), амфетамин, метамфетамин, метилфенидат, бензфетамин, анфепрамон, фендиметразин, фенметразин, фентермин гэх мэт ордог.

Сэтгэцэд нөлөөлөх (мансууруулах) хэсэгт Лизергид (ЛСД), мескалин, фенциклидин ба түүний дайврууд, триптамин ба түүний дайврууд гэх мэт ордог.

Тайвшруулах бүлэгт барбитуратын хүчлийн дайврууд, бензодиазепин гэх мэт багтдаг. Бусад хяналттай бодисонд фторотан (галотан), эфир, толуолн г.м ордог байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис нь хувь хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг, хууль зөрчих төдийгүй хүний удмын /генийн/ санд хор уршиг учруулдаг. Эрүүл мэндийн талаас сэтгэцийн болон биеийн хамааралд орж, донтох өвчтэй болсноор хүсэл эрмэлзэл, хэрэгцээ нь зөвхөн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхэд тэмүүлэх байдлаар солигдож, сэтгэл санааны хоосрол, итгэл, зүтгэлийн эрч хүч нь буурч, ой ухаан доройтож, амархан ядрах, үг даах чадваргүй, бухимдуу, түрэмгий болж сэтгэцийн өвчтэй болдог.¹⁸

Хар тамхины төрлийн мансууруулах бодис нь сэтгэлийн хөөрөл, тайвшрал, амирлангуй байдал бий болгодог. Анх удаагаа хэрэглэхэд хордох хүртлээ дахин хэрэглэх,

¹⁷ Т.Дамбийням, Б.Аадарсүх, Ц.Өлзийбаяр, Г.Давааням. Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэх ажиллагаа. Тэргүүн дэвтэр. УБ., 2016. 8 дах тал

¹⁸ Б.Болдбаатар, Ж.Мөнхболд. мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг ажиллагаа. УБ.,2012. 11 дэх тал

тэсгэлгүй хүсэл төрүүлэхээс аваад туйлын муухай санагдах хүртэл янз янзын нөлөө үзүүлнэ. Эдгээр бодис хүний биеийн бодисын солилцооны үйл явцад оролцоод ирэхээрээ бие махбодын болон сэтгэл зүйн маш хүчтэй хараат байдал богинохон хугацаанд үүсгэдэг. Хэрэглэгч мансууруулах бодисын хүчээр өөрийн эрхгүй сэтгэлийн тэнцвэрээ алдаж, улмаар уг бодисын үйлчилгээг дахин дахин мэдрэхийг эрмэлзсэнээр бие махбодын болон сэтгэл зүйн хараат байдал илэрч эхэлдэг.

Бие махбодын хараат байдал гэдэг нь хэрэглэгч этгээдийн бие махбодыг мансууруулах бодисгүйгээр хэвийн байж чадахаа байгаад уг бодис л байхгүй бол оршин тогтнох, хэвийн амьдрах боломжгүй мэт сэтгэгдэл төрөх шинжүүд тод илрэн улам даамжрах үйл явц юм. Энэ нь мансууруулах бодис хэрэглэгчийн бие махбодын бодисын солилцооны нэг хэсэг болсонтой холбоо бүхий бие махбодыг болон сэтгэл санааны гүн гүнзгий хямрал юм.

Хүний уураг тархин дахь эерэг сэтгэл хөдлөлийн төв мансууруулах бодисын үйлчлэлээр идэвхжсэний дүнд үүсдэг мансууран согтох, хөөрлийн байдлыг үгүйлэн хүсэх байдал нь сэтгэл зүйн хараат байдал бий болох үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг судлаач эрдэмтэд туршилт, сорилоор тогтоожээ.

Бие махбод хар тамхи, мансууруулах бодис нэхэх дур хүсэл оргилж эхлэх нь хараат байдлын үндэс юм. Эдгээр бодисыг нэхэх дур хүсэл маш хүчтэй бөгөөд өлсөж цангах зэрэг амин чухал, юугаар ч сольшгүй хэрэгцээг ч үгүйсгэдэг. Эдгээр бодисыг хэтрүүлж хэрэглээд ирэх үед бие махбодын хамгаалалтын үүрэг бүхий хариу үйлдлүүд алга болно. Тухайлбал, бөөлжис хүрэн дотор муухайрах, огиулах, арьс салст загатнах, хөлрөх, зогсох, шүлс гоожих, нүд гялалзах зэрэг байдал ажиглагдахаа больж улам гүнзгий автана.¹⁹

Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж дасал болох үед өөдрөг сайхан сэтгэгдэл төрөх, бүх юм биелж бүтэх талаасаа төсөөлөгдөж, тайван амгалан, өөртөө итгэлтэй болоход чухал үүрэгтэй энфорфиныг²⁰ судлаачид “баяр баясгалангийн гормон” гэж нэрлэсэн нь санамсаргүй зүйл биш юм. Ялангуяа сэтгэлийн хөөрөл, хайр дурлал, амжилт ололтын агшинд уураг тархи уг бодисыг ихээр боловсруулан гаргадаг нь тогтоогдсон зүйл юм. Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсний үр дүн болох мансуурал нь хэрэглэгчийн арьсны өнгө цонхийно. Сав л хийвэл нойрмоглож, ер бусын их нойртой болно. Удаан сунжруу яриатай болж ярианы сэдэв, чиглэлээсээ байнга “хоцорно”, зан ааш эелдэг зөөлөн, дуулгавартай, анхааралтай болно. Санааширч бодлогоширсон мэт харагдах зэрэг шинж тэмдгээр илэрнэ. Хар тамхи, мансууруулах бодисын хараат байдлыг биологийн, сэтгэл зүйн, нийгмийн талаас нарийвчлан авч үзэх шаардлагатай юм. Хар тамхи, мансууруулах бодис бие организмын бодисын солилцооны нэг хэсэг болсноор бие махбодын хараат байдал бий болдог. Хараат байдалд олон хүний эрхтэнүүд хэвийн ажиллах чадвараа алддаг.

Эдгээр бодис эхлээд уураг тархийг аажмаар хөнөөдөг. Уг бодисын мэдрэлийн системийг хордуулах нөлөө тархины холтослог буюу доод гадаргуугийн цөм, харааны товгорын үүсвэрүүд, торлог давхарга, бага тархи болон захын мэдрэлийн судал гэмтэх зэргээр илэрдэг. Өөрөөр хэлбэл, уураг тархи бүхэлдээ гэмтдэг. Уураг тархины хэвийн үйл ажиллагаа алдагдахад хөл саа өвчинд нэрвэгдэх, эсхүл бие тал мэдээгүй болно. Эдгээр бодисын хэтэрсэн хэрэглээ эцэстээ бүх дотор эрхтэнүүд, элэг бөөр, уушиг, зүрхийг гэмтээдэг болохоор нэн аюултай үр дагавар үүсгэдэг. Хараат байдлыг сэтгэцийн талаас авч үзэхэд хэрэглэгчийн сэтгэцэд өөрчлөлт гардаг. Тухайлбал,

а/ сэтгэл санаа хоосролд автдаг

б/ идэвх зүтгэл, чармайлт, эрч хүч суларч доройтоно

в/ эрүүл хүсэл эрмэлзэл, эрэлт хэрэгцээ нь мансууруулах бодист тэмүүлэх сэтгэлгээгээр солигдоно.

г/ ой ухаан суудаж, оюуны хөдөлмөрийн чадвар, үр бүтээл буурна.

д/ сэтгэлд түгшүүр, хямрал, цухалдалт нэмэгдэнэ

е/ үе үе дүрэлзтэл уурлан, түрэмгий зан авир гаргана

¹⁹ Мансууруулах эм бодис ба түүний зүй бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэлт. УБ.,2003. 5-6 дахь тал

²⁰ Хар тамхины үйлчилгээ нь түүний молекул эндофин буюу уураг тархи боловсруулан гаргадаг бодистой адилхан байдаг.

ё/ сонирхлын хүрээ хумигдаж, шинийг танин мэдэх, хүсэл эрмэлзэлгүй болно
и/ хийж бүтээх хүсэл үгүй болно.

Хар тамхи, мансууруулах бодисын хараат байдал нийгмийн талаас дор дурдсан хортой үр дагаварт хүргэнэ. Нийгмийн ашигтай хэлхээ холбоо аажмаар алдагдаж, хэрэглэгч ганцаардаж эхэлнэ. Хараат байдал бүрэлдэн тогтох явцад хэрэглэгчийн үнэт зүйлсийн тухай урьдын үнэлэмж эрс өөрчлөгдөнө. Урьд өмнө нь ач холбогдолтой, үнэ цэнэтэй, хайртай дотно, эрхэмлэдэг байсан бүхэн утга учраа алдана. Ойр дотны хүмүүстэйгээ тогтоосон харилцаа холбоо аажмаар суларч мууддаг төдийгүй тэднээсээ алхам алхмаар хөндийрч хүнийрхүү болно.

Мансуурагч этгээд нь амиа хичээх, бусдыг үл тоомсорлох, ойр дотны хүмүүсээ үзэн ядах, шийдвэргүй, зүрх зориг муутай, өөртөө итгэх итгэлгүй, хүсэл эрмэлзэлгүй, түгжигдмэл байдалтай болох зэрэг сэтгэл зүйн онцлогтой болдог.

Хар тамхи мансууруулах бодисын хараат байдлыг оюун санааны талаас авч үзвэл хараат байдалд орсон хүн ёс суртахууны ноён нуруугаа бүрмөсөн алддаг. Оюун санааны эрхэм дээд зорилго, амьдралын үнэт зүйлс /бурхан шүтэх, эх орноо хайрлах, хүмүүст санаа тавих, өвчтэй дорой хүмүүсийг өрөвдөх, бодь сэтгэлтэй байх, өөрийгөө бусдын нөлөө золиослох/ гэх мэт ойлголт түүний хувьд юу ч биш болж хувирдаг байна.

Борлуулагч, хэрэглэгч этгээдүүд өөрсдөө хэрэглэж, түүний хамааралд орохоороо мансууруулах бодисыг аль болох ихээр, олон хүнд худалдаж олсон орлогоороо дахин их хэмжээтэй худалдаж авах, энэ зорилгоор мөнгө олохын тулд гэмт хэрэг үйлдэхэд ч бэлэн болно. Мансууруулах бодисын бүрэн хамааралд орсон этгээд тийм бодисыг хэрэглэхгүйгээр байж чадахаа байж, багахан хэмжээний морфин олж авахын тулд эд хөрөнгөө үрэн таран хийх болон юу ч хийхээс буцахгүй болдог онцлогтой.

Дүгнэлт, санал

Дэлхий нийтээрээ буюу Монгол Улс өнө эрт үеэс хар тамхи, мансуурлын хор хөнөөлийг сайтар ойлгож, түүнтэй тууштай тэмцэл явуулж ирсэн болохыг түүх гэрчилнэ. Өнөөдөр дэлхий дахинд сая, сая хүн хар тамхи, мансууруулах бодис, эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэргийн шинж бүхий худалдаа, арилжаа хийх хууль бус ажиллагаанд татагдан орсон нь хүн төрөлхтнийг түгшээх боллоо.

Мансууруулах эм, бодис хэрэглэх, хууль бус худалдаа хийх нь зөвхөн хувь хүний амьдралыг бусниулаад зогсохгүй нийгэмд гамшиг тарьж, улс орны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Хар тамхи, мансууруулах бодис, эм бэлдмэлтэй холбоотой асуудлууд улс үндэстний хил хязгаарыг нэгэнт давж, дэлхийн ихэнх бүс нутгийг хамраад байна.

Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд зарим иргэд хар тамхи, мансууруулах бодис хууль бусаар олж авах, хэрэглэх, боловсруулах, зарж борлуулах, хил дамнуулан тээвэрлэх явдал өсч, түүнд гадаадын иргэд оролцох нь нэмэгдэж байгаа нь улс үндэстний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, иргэдийн хэвийн амьдрахад бэрхшээл учруулж болзошгүй байдалд тулж ирээд байна.

Монгол Улсад хамгийн их хэрэглэгддэг нь НҮБ-ын 1971 оны сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенцийн 2 дугаар жагсаалтад орсон Каннабис буюу зэрлэг олсны ургамал, НҮБ-ын 1971 оны “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенцийн 2 дугаар жагсаалтад орсон метамфетамин буюу мөс, Экстази болон бусад бодис байна.

Олсны ургамал нь газар зүйн байрлалаар Хэнтий, Хангай, Монгол дагуур, Хянган, Ховд, Их нуурын хотгор, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Булган, Архангай, Увс, Хөвсгөл, Баянхонгор, Орхон, Дархан аймгуудын нутгаар ургадаг үсэрхэг мохоовтор дөрвөлжин талтай ногоон өнгийн 1-6 см урт бариултай, том шүдлэг, 3-7 см урт навчтай 120 см өндөртэй, нэг настай өвсөрхөг ургамал юм.

Каннабисаас гаргаж авсан хар тамхи дэлхий нийтэд хамгийн их тархацтай бөгөөд энэ төрлийн ургамлыг таних, хаана ямар байдалтай ургадаг талаар мэдэх нь тухайн төрлийн хэргийг илрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой.²¹

Мөн газар зүйн нөхцөл байдлын онцлогоос шалтгаалж манай орны зарим нутаг дэвсгэрт мансууруулах төрлийн ургамал ургадаг, түүнийг устгах ажил хангалттай зохион байгуулагддаггүй. Хүүхэд, залуучууд бие биеэсээ сонсох, даган дуурайх, олон нийтийн

²¹ Цагдаагийн ерөнхий газрын албан ёсны эх сурвалж. 2018.

хэрэгсэл, интернет цахим хуудсаар хар тамхи, мансууруулах бодисын ойлголт, хэрэглэх аргыг сурч байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх сэдэл, шалтгаан нөхцөл нь болж байна.

Хяналт, шинжилгээ хийх зориулалт бүхий техник, технологи шаардлагын хэмжээнд хүрдэггүй, хэрэглэгч, донтогч болсон тохиолдолд үзүүлэх эмнэлгийн болон сэтгэл зүйн, нийгмийн тусламж үйлчилгээний стандарт байхгүй зэргээс шалтгаалж нөхцөл байдал хүндрэх эрсдэлтэй байна. Хүүхэд, залуучууд бие биеэсээ сонсох, даган дуурайх, мөн телевиз, интернетээс ямар ч шалгуур, цензургүй мэдээлэл авах боломж нээлттэй байна. Иргэд богино хугацаанд их хэмжээний ашиг олох, орлогын эх үүсвэр болгох зорилгоор энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх, тээвэрлэх явдал ихэссэн, хяналт, шинжилгээ хийх зориулалт бүхий техник, технологи шаардлагын хэмжээнд хүрдэггүй. Хэрэглэгч, донтогч болсон тохиолдолд үзүүлэх эмнэлгийн болон сэтгэл зүйн, нийгмийн тусламж үйлчилгээний стандарт байхгүй зэрэг нөхцөл байдал нь энэ төрлийн гэмт хэрэг өсөн нэмэгдэх шалтгаан болж байна.

Шинжилгээний байгууллагын энэ төрлийн бодист шинжилгээ хийх чадамж хангалттай төвшинд хүрээгүй, тухайлбал LSD, Экстази, Эфедриний агууламжтай байдаг Нангиад Зээргэнэ/*Ephedra Sinica*, бусад төрлийн ургамал, бодис, эмүүдэд шинжилгээ хийх тоног төхөөрөмж, стандарт, дээж, урвалж бодис байхгүй, үйлчлэгч бодисыг илрүүлэх боломжгүй байна. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 26 хилийн боомтод мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх техник тоног төхөөрөмжийг суурилуулах, хэрэглэгч, донтогчдыг эмчлэх, тэдэнд туслалцаа үзүүлэх, эмчилгээний байгууллага, мэргэшсэн эмч ажилтан, наркологийн кабинет, төвтэй болох асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр байна.

Иймд хар тамхи гэх ойлголтыг Монгол Улсын хувьд “мансууруулах эм”, “сэтгэцэд нөлөөт” бодис гэх ойлголтоор хуульчлан, практикт хэрэглэгдэж байна. Энэ нэршлийг БНХАУ-тай, бусад улсын нэршилтэй харьцуулан үзэх зайлшгүй шаардлага байна.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Ц.Мөнгөнзул

*Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Ажлын албаны Зохион байгуулалтын хэлтсийн
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, шашин сүм
хийд, төрийн бус байгууллага харууцсан ажилтан*

Товч агуулга: Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, түүнээс хулгайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл байдал, урьдчилан сэргийлж цаашид анхааран авч хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлохыг зорьсон.

Түлхүүр үг: Гэмт хэрэг, гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдал, хулгайлах гэмт хэрэг.

Удиртгал

Өмчлөх эрх бол хувь хүний оршихуйн үндэс, эрх чөлөөний үнэт зүйлсийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг билээ. Хувийн өмч нь эд баялаг, хөрөнгө чинээтэй холбогдож байдаг боловч хүний үнэт чанарыг түүнээс дээгүүрт тавьж, хувь хүний эрх чөлөөг нөхцөлдүүлэгч нь өмчлөх эрх юм гэдгийг эрх зүйчид, сэтгэгчид байнга сануулсаар иржээ. Ардчилсан нийгмийн үнэт зүйл нь өмчийн халдашгүй байдал төдийгүй хүний эрхийг хүндэтгэж хамгаалахыг чухалчилдаг.²² 1992 оны Үндсэн хуулиар өмчлөх эрхийн суурь зохицуулалтыг тодорхойлсон бөгөөд түүнээс хойшхи хугацаанд төрөлжсөн хуулиудаар чөлөөт нийгмийн үндсэн суурь болсон өмчлөх эрхийг баталгаажуулсан, хувийн өмчийг хамгаалахтай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгосоор ирсэн.

Монгол Улсад сүүлийн 15 жилийн хугацаанд бүртгэгдсэн хулгайлах гэмт хэргийн 52,9% -ийг нийслэлд бүртгэгдсэний дотор сонгинохайрхан дүүрэгт 20% нь бүртгэгдсэн байна. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг нь өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэргийн дотроос иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрд учруулах хор хохирол нь байнга нэмэгдэж тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна. Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд сүүлийн 15 жилийн байдлаар 33390 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 11987 буюу 36% нь хулгайлах гэмт хэрэг эзэлж, тус дүүрэгт бүртгэгдсэн хулгайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл байдал нөлөөлж буй хүчин зүйлийг нээн илрүүлж, урьдчилан сэргийлж цаашид анхааран авч хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлов.

Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг зөв тодорхойлохын тулд тухайн гэмт хэрэгтэй ямар арга замаар тэмцэж, урьдчилан сэргийлж байсан хууль цаазын түүхэн уламжлалыг судлахад Хүннү улсын үед бусдын эд хөрөнгийг хулгайлбал хулгайчийн гэр орныг хурааж хөнгөн хэрэгтнийг бэрээдэж, хүндийг цаазалдаг байжээ. "Их засаг" хуульд эрүүгийн эрх зүйн шинжтэй олон хэм хэмжээнүүд дотор хулгайлах, дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх заалт чухал байр суурийг эзэлдэг байжээ. Монголын эртний хууль цаазын эх сурвалж Алтан хааны цаазад /1507-1582/ хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх талаар анхаарч ийм хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулах ялыг хүндрүүлэх болон тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлсон явдал юм. Тус цаазад 10 наснаас доош бол хулгайчид бүү тооц, 10 наснаас дээш бол хулгайчид тооц гэж субъектийн нэг гол шинж болох насны хязгаарыг тогтоосон, мөн "Халх журам" хуульд хулгайлах гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн 90 гаруй хувь нь торгох ял байсан зэрэг цаазын түүхэн уламжлалтай.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид "Өмчлөх эрхийн эсрэг" гэмт хэргийг 17 дугаар бүлгийн 17.1 дүгээр зүйлд "Бусдын эд хөрөнгийг нууцаар, хууль бусаар авах" хэмээн хуульчилжээ.²³ Гэмт этгээд хууль бус аргаар шунахай сэдэлтээр ашиг хонжоо олж гэм буруутай ажиллагаа нь нөхцөлддөг.

²² Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он 2 дугаар бүлэг 16 дугаар зүйл 14 дэх хэсэг

²³


Гэмт хэргийн нөхцөл байдал

Монгол Улсад сүүлийн 15 жилийн хугацаанд нийт 337844 (жилд дунджаар 22522) гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэлд 193515 (жилд дунджаар 12901), үүнээс Сонгинохайрхан дүүрэгт 33390 (жилд дунджаар 2226) бүртгэгдэж улсад бүртгэгдсэн гэмт хэргийн 57,2% нь нийслэлд бүртгэгдсэн гэмт хэрэг эзэлж байна. Нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 17,2% нь Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

Монгол Улсад гэмт хэргийн гаралтын тоо сүүлийн 15 жилийн хугацаанд тогтмол өссөөр байна. Энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, эрх зүйн актыг боловсронгуй болгох шаардлага, нөгөө талаар одоо мөрдөгдөж хуулийг олон нийтэд сурталчлах, тэдний оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, олон нийтийн хүчинд түшиглэх зарчимд тулгуурлан оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах явдал юм.


График I. Монгол Улс, Нийслэл, Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /2003-2017 он/



Сүүлийн 15 жилийн хугацаанд Монгол улсад 114958 (жилд дунджаар 7663) хулгайлах гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэлд 60865 (жилд дунджаар 4057), үүнээс Сонгинохайрхан дүүрэгт 11987 (жилд дунджаар 800) бүртгэгдсэн байна. Энэ нь сүүлийн 15 жил улсад бүртгэгдсэн хулгайлах гэмт хэргийн 52,9% -ийг нийслэлд бүртгэгдсэн гэмт хэрэг эзэлж байна. Нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 20% нь Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

График II. 2003-2017 онд Монгол Улс, нийслэл, Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн хулгайлах гэмт хэрэг

Бүртгэгдсэн хулгайлах гэмт хэрэг





■ Улс	8762	7861	6683	6657	7927	6609	6376	5777	5276	6266	7884	8424	9169	9065	1222
■ Нийслэл	4072	3242	2437	2416	3684	3266	3374	2897	2559	3385	4184	4685	5899	6098	8667
■ Сонгинохайрхан	524	531	468	530	767	626	815	675	533	635	982	1044	1268	944	1645

Монгол Улс дахь гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн түвшингээс хамааралтай байгааг харуулж байна. 2007 онд өссөн үзүүлэлтэй байсан бол 2011 онд буурч одоогийн хандлага өсөх төлөвтэй байна. Үүнээс харахад энэ төрлийн гэмт хэргийн хандлага эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамаарч байгаа нь харагдаж байна.

Монгол улсад 337844 (жилд дунджаар 22522) нийт гэмт хэрэг бүртгэгдсэнээс хулгайлах гэмт хэрэг 114958 (жилд дунджаар 7663) буюу 34%, нийслэлд 193515 (жилд дунджаар 12901) гэмт хэрэг бүртгэгдсэнээс хулгайлах гэмт 60865 (жилд дунджаар 4057) буюу 31,4%, Сонгинохайрхан дүүрэгт 33390 (жилд дунджаар 2226) гэмт хэрэг бүртгэгдсэнээс хулгайлах гэмт 11987 (жилд дунджаар 800) бүртгэгдсэн 36%-ийг эзэлж байна.

График III. 2003-2017 онуудад Монгол улс, Нийслэл, Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт гэмт хэргийг хулгайлах гэмт хэрэгтэй харьцуулсан байдал



Хүн төрөлхтөний хөгжлийн чиг хандлагыг дагаж гэмт хэрэг үйлдэж байгаа хүний ашиглаж байгаа техник хэрэгсэл улам нарийсч, гэмт хэргийн бүтэц шинж, онцлогт эрс өөрчлөлт гарсны улмаас шинэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх болсон.

Иймээс хууль сахиулах байгууллагын алба хаагчид мэргэжил ур чадвараа дээшлүүлж, гадаад дотоод хамтын ажиллагаагаа сайжруулан ажиллах шаардлагатай болжээ.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:

Тус дүүрэг нь 120.6 мянган га нутаг дэвсгэртэй, засаглалын анхан шатны нэгж болсон 32 хороотой. 86212 айлын 322458 хүн амтай. Нийт өрхийн 22847 өрх буюу 26.5% нь байшин хороололд, 63365 өрх буюу 73.5% нь гэр хороололд амьдарч байна. 2017 оны тооллогоор 72072 толгой мал тоологдсон. 14502 аж ахуй нэгж байгууллагатай. Цагдаагийн 1 дүгээр хэлтэс нь дүүргийн 13 хорооны 110732 га газар нутаг дэвсгэрийн 141991хүн ам, Цагдаагийн 2 дугаар хэлтэс нь дүүргийн 9 хорооны 8544,8 га нутаг дэвсгэрийн 107991 хүн ам, Цагдаагийн 3 дугаар хэлтэс нь дүүргийн 10 хорооны 722,5 га нутаг дэвсгэрийн 72476 хүн амд үйлчилж, гэмт хэрэгтэй тэмцэх, дэмжлэг үзүүлэх, нийтийн хэв журам хамгаалах тасгаас тус тус бүрдсэн алба хаагч нар үүрэг гүйцэтгэж байна.

Нийслэл хотод 2017 онд 21947 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2016 оноос 4038 (22.5%) хэргээр өссөн байна. Нийслэл хотод бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 3691 (16.8%) Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна. 2017 оны 7 сараас хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор зарим гэмт хэргийн арга зүйд өөрчлөлт орсон болно. Өнгөрсөн 2017 оны байдлаар 16-аас дээш насны 10000 хүн амд ногдох гэмт хэргийн тоо нийслэлд 229.2 гэмт хэрэг ногдож байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт 169.7 гэмт хэрэг тус тус ногдож байна.

Өмчлөх хэргийн эсрэг гэмт хэрэг 2017 онд 2262 бүртгэгдсэн нь дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 61.3 хувь болж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2016 оноос 958 буюу 73.5%-иар нэмэгджээ. Нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг хэрэг 1645 (72.7 %) гарсан байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2017 онд нийт 2262 гарснаас 982 (43.4%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 526 (23.2%) цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 754 (33.3%) цагдаагийн гуравдугаар хэлтэст ногдож байна. Нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 1645 (72.7 %) нь бусдын эд хөрөнгийг хулгайлсан хэрэг байна. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 1522 (92.5%) нь хувийн өмчийн хулгай, 14 (0.9%) нь малын хулгай, 29 (1.8%) нь автотээврийн хэрэгслийн хулгай, 67 (4.1%) нь халаасны хулгайн гэмт хэрэг байна. Нийт өмчлөх эрхийн эсрэг хэргийн 10 (0.4%) нь булаалт, 190 (8.4%) дээрэм, 286 (12.6%) нь залилан, 29 (1.3%) завших гэмт хэрэг байна.


Хүснэгт 1. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, төрлөөр /2017 он/

Он	Хэлтэс	Өмчлөх эрхийн эсрэг бүгд	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	Бусдын эд хөрөнгийг хулгайлах				⁴ Бусдын эд хөрөнг ийг булаах	⁵ Бусдын эд хөрөнгийн дээрэмдэх	Бусдын эд хөрөнгийн залилан мэхлэх	Бусдын эд хөрөнгийг завшиж үрэгдүүлэх
				Хувийн өмч хулгайлах	Мал хулгайлах	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай				
2016	I	624	474	421	36	14	3	13	22	69	15
	II	308	251	242	3	4	2	4	11	28	1
	III	372	219	198	0	5	16	12	27	77	8

2017	I	982	762	718	13	18	9	2	58	112	15
	II	526	417	402	1	6	5	4	34	37	5
	III	754	466	402	1	5	53	4	98	137	9

Бүх гэмт хэргээс хулгайлах гэмт хэрэг нь эзлэх хувь харьцангуй их байгаа бөгөөд тогтмол өсөх хандлагатай байгаа нь нэг талаас хүн амын шилжилт хөдөлгөөн, нөгөө талаас хяналт хамгаалалтын тогтолцоо (гэрэлтүүлэг, камер, дохиолол) хангалтгүй байгаатай холбоотой. Сонгинохайрхан дүүргийн хувьд зорилтот бүлгийн нэн ядуу, эмзэг бүлгийн иргэд болон хөдөө орон нутгаас шилжин суурьшигч ихтэй, архидалт, ажилгүйдэл нь энэ төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгдэх шалтгаан нөхцөл болоод байна.

График V. 2017 онд хулгайлах гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн яллагдагчийг нийгмийн байдал, боловсрол, хүйс, үйлдсэн хэлбэрээр авч үзвэл:



Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд 2017 онд 256 хүн хулгайлах гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдож яллагдагчаар татагдсанаас 91% хувь буюу 235 нь эрэгтэй, 8,2% буюу 21 эмэгтэйчүүд байна. Мөн хэрэгт холбогдогсдын 172 буюу 67% нь эрхэлсэн ажилгүй бөгөөд 17,1% хувиараа хөдөлмөр эрхлэгч, 5,4% тэнэмэл, 3,1% оюутан зэрэг байгаагаас 111 буюу 44% нь бүрэн дунд, 69 буюу 27% нь бүрэн бус дунд, 36 буюу 14% нь бага, 11 буюу 4,2% нь дээд боловсролтой байна.

Үүнээс харахад хулгайн гэмт хэрэг үйлдэгчийн 67% эрхэлсэн тодорхой ажилгүй иргэн байгаа нь нийгэм эдийн засгийн суурь нөхцөл байдал энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл болж байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт

Сүүлийн 2017 онд өмнөх онуудаас хулгайлах гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн нь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх бодлого эрх зүйн зохицуулалттай

холбоотойгоор хүний аюулгүй байдал, өмчийн халдашгүй байдлыг хамгаалах бүртгэл харьцангуй сайжирсантай салшгүй холбоотой. Хулгайлах гэмт хэрэг гарч байгаа шалтгааны нэг хэсэг нь ажилгүйдэл, ядуурал гэдгийг үгүйсгэх аргагүй ч ажил хийхийг үл хүсэгчид, бусдын бүтээсэн баялагийг хууль бус аргаар завшигчид олширсон нь хулгайлах гэмт хэрэг өсөх гол шалтгаан болж байна. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудын сонор сэрэмжгүй болон хайхрамжгүй, хариуцлагагүй байдлууд /харуул хамгаалалт, камержуулалт, дотоод хяналт, сонор сэрэмж/ ч гэмт хэрэг гарах таатай нөхцлийг бүрдүүлээд байгаа нь ажиглагдаж байна.

Санал

Мэргэжлийн баг байгууллагаар дамжуулан иргэдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар санамж сэрэмжлүүлэг, сургалт семинар, хууль тогтоомжийн сурталчилгаа, таниулгыг байнга тогтмол мэдээллэх төсвийг хуваарилж, үр дүнтэй зарцуулах;

Өмчийн халдашгүй байдлыг хангах чиглэлээр уулзалт хэлэлцүүлгийг хорооны албан хаагчид иргэний танхимаар дамжуулан тогтмол тасралтгүй явуулах;

Нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ААН байгууллага, их дээд сургуулийн оюутан залуусыг урьдчилан сэргийлэх ажилд оролцох хүч оролцоог нэмэгдүүлэх;

Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд аюулгүй байдал, хяналтыг сайжруулах чиглэлээр (гэрэлтүүлэг, камер, дохиолол) яриа таниулга хийж, орох гарах хаалга, гадна дотор талбайн гэрэлтүүлэг, стандартын шаардлага хангасан хөдөлгөөн мэдрэгч бүхий камер суурилуулах мэдэгдэл өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Нутаг дэвсгэртээ үйлдэгдэж байгаа хулгайлах гэмт хэрэгт дүн шинжилгээ хийж нөхцөл байдлын судалгаанд үндэслэн тохирсон чиглэл маршрутаар эргүүлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, явган эргүүл, машинт эргүүлийн үйл ажиллагааг камерын хяналтын системтэй уялдуулах;

Орон байр, гэр хорооллын, машины эд ангийн, халаасны, мал хулгайлах гэмт хэргийн криминологи шинжид тохируулан тэдгээртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох;

Цагдаагийн байгууллагын үүрэг бүхий алба хариуцсан ажилтны орон тоо, төсөв, цалин, хүч хэрэгслийг нэмэгдүүлэх /Хорооны хүн амын тоонд харьцуулан хэсгийн байцаагчийн тоог нэмэгдүүлэх/;

“Хөршийн хяналт хөтөлбөр”-ийг үр дүнтэйгээр зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон байгууллага, ААН-үүдийг татан оролцуулж хамтран ажиллаж, үр дүнг тооцох;

Гэмт явдлын шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулахын тулд мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар судлуулах /4 жил тутамд/.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002, 2017 он
3. Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1997 он
4. Жанцан.Н, Эрдэнэбат.Г, Мөнхдорж.Б, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, УБ., 2016 он
5. Болдбаатар.Б, Бусдын өмчийг хулгайлах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зарим асуудал, УБ., 2004 он
6. Адъяабазар.Д, Батжав.Л, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, УБ., 2008 он
7. Оюунжаргал.Д, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулах аргачлал, УБ., 2015 он
8. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, судалгааны төв, Монгол Улс дахь 2012 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал УБ., 2013 он
9. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, судалгааны төв, Монгол Улсад 2003-2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт, УБ., 2013 он
10. Улсын бүртгэл статистикийн газар, Монгол улсын статистикийн эмхэтгэл, УБ., 2015 он

11. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл нэгтгэн боловсруулах газар, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, УБ., 2016 он
12. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл нэгтгэн боловсруулах газар, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, УБ., 2017 он
13. Криминологи судалгааны тайлан, Сонгинохайрхан дүүргийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, УБ., 2014 он
14. Үндэсний статистикийн хороо, Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх гарын авлага, УБ., 2017 он

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ГАДААД ХУДАЛДААНЫ НӨЛӨӨЛӨХ ЭРСДЭЛ

С.Урангоо

Дотоод хэргийн их сургуулийн магистрант

Үндэслэл

Монгол Улс сүүлийн жилүүдэд гадаад худалдааны дийлэнх хувийг хөрш хоёр оронтой хийж байна. Манай улс нь өвөрмөц онцлогтой Зүүн хойд Азийн бүс нутагт багтана.

Зүүн хойд Азийг эдийн засгийн талаас нь авч үзвэл тус бүс нутагт үсрэнгүй эдийн засагтай Япон улс, асар хурдацтай эдийн засаг нь өсөж байгаа Хятад улс, эдийн засгийн үсрэнгүй хөгжилд хүрч байгаа Өмнөд Солонгос улс, мөн эдийн засгийн хоригт орсон Хойд Солонгос улс багтаж байна.

Монгол орны хувьд өргөн уудам газар нутагтай, хүн ам цөөнтэй, тархан сууршилт ихэнх хэсгээрээ тархай, нийслэл хотдоо төвлөрсөн байдлаараа онцлогтой. Нэг квадрат километр нутаг дэвсгэрт ногдох суурь дэд бүтэц хэт бага улс учраас суурь дэд бүтцийг бүрдүүлэх, эдийн засаг, нийгэм, соёл, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад худалдааны таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн бүсүүдийн хүрээнд бүс нутаг, хот байгуулалтын уялдааг хангах асуудал ихээхэн чухал ач холбогдолтой болоод байна.

Удиртгал

Зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх үүднээс хууль, эрх зүйн орчин, ДНБ-ий өсөлт, уул уурхайн баялаг болох алт, зэс, газрын тос, нүүрс зэрэг эрдэс баялагийн олборлолт, газар тариалан болон мал аж ахуйн салбараас гарах уламжлалт бүтээгдэхүүний дахин сэргэлт, жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж, хоёр хөрш орны том зах зээлд ойр байдал, хувийн хэвшлийн хурдацтай өсөлт, санхүүгийн салбарын хөгжил зэрэг хөгжлийн олон нааштай хүчин зүйл, үзүүлэлтээс манай орны гадаад худалдааны өсөлт гарсан гэж үзэж болно.

Энэ өргөн уудам газар нутагтай манай улсын хувьд хэдхэн цэгт хүн амын төвлөрөл бий болж зарим бүс нутагт хүн амын тоо эрс цөөн болсон. Манай орон олон улсын худалдаа, дэлхийн зах зээлд 1990 оноос нээлттэй эдийн засгийн бодлогоор оролцох болсноор сүүлийн жилүүдэд бүс нутгийн хэмжээнд худалдааны гол түнш орнуудтай худалдааг өргөжүүлсэн.

НҮБ-ын хүрээнд хэрэгжүүлж буй Түмэн гол төслийн хүрээнд Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засаг, газар зүйн хүрээнд манай улсын Дорнод хэсэг, Хятадын Зүүн хойд хэсэг, Оросын Алс дорнод, Сибирь, Өмнөд болон Хойд Солонгос, Японыг хамруулж үздэг байна.

Бараа, бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ зэрэг эдийн засгийн гадаад хүчин зүйлээс шалтгаалж эдийн засагт гадаад худалдааны нөлөөлөх эрсдэл их болоод байна. Энэ нь мөн улс орны эдийн засаг, санхүүгийн байдалтай холбогдож байна.

Ойрын жилүүдэд дэлхий зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ тогтворгүй байгаагаас манай орны макро эдийн засагт ихээхэн эрсдэл дагуулж байна. Уул уурхай эрдэс бүтээгдэхүүний орлогоор санхүүгийн чадавхийг бүрдүүлдэг манай улсын хувьд энэ нь ихээхэн хүндрэлтэй асуудлын нэг болоод байна.

Үндсэн хэсэг

Манай улс 1961 онд Нэгдсэн үндэсний байгууллага/НҮБ/-д гишүүнээр элсэнээс хойш НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудад гишүүн болж хамтын ажиллагаа өргөжүүлж ирсэн баялаг түүхтэй.

Монгол Улс 1992 оноос Олон улсын Валютын сан, Дэлхийн Банк, Азийн хөгжлийн Банк зэрэг олон улсын санхүү, банкны байгууллагын гишүүн болсон нь санхүүгийн салбарт олон улсын стандартад нийцсэн орчинг бүрдүүлж, шинэ боломжийг нээж таатай нөхцлийг бий болгосон. Монгол Улс 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллага /ДХБ/-д гишүүнээр элссэн нь гадаад худалдааг өргөжүүлж өгсөн гэж үзэж байна.

1997 оноос хойш Монгол Улсад тогтоосон худалдааны дэглэм ДХБ-д элсэхэд тавигдсан нөхцлөөс давсан цар хүрээтэй байсан тул Монгол улс ДХБ-ын гишүүн болсны үр нөлөөг хэмжихэд хэцүү. Үүнээс гаалийн тарифын бодлогын хувьд Монгол улс үндэсний нэн

таатай гаалийн татварыг 20 хувиар тогтоосон боловч үнэн хэрэгтээ бүх төрлийн бүтээгдэхүүнд түүнээс хамаагүй бага тариф ноогдуулж, хэсэг хугацаанд бүр тарифыг нь тэглэсэн тохиолдол ч байсан.

ДХБ-ын дүрмээр зөвшөөрөгдсөн худалдааг хамгаалах арга хэмжээ болох онцгой үеийн худалдааны хориг, шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх ажиллагаа зэргийг хэрэгжүүлээгүйгээс импортын огцом өсөлтөнд өртсөн дотоодын үйлдвэрлэгчид ДХБ-ын дүрмээр олгогдсон эрхээ эдэлж чадаагүй. 1997 онд ДХБ-д элсэхдээ Монгол улс шилжилтийн шатанд нэгэнт орсон байсан тул ДХБ-д элсэх нөхцлүүдээс улбаалж хэдийнээ хэрэгжүүлж эхэлсэн худалдааны арга хэмжээнүүдээ өөрчлөх шаардлага гараагүй байна.

Иймээс энэ үед үндэсний үйлдвэрлэгч нарын эрх ашгийг хамгаалаагүйгээс олон үйлдвэр аж ахуйн нэгж үүд хаалга барьсан. Энэ нь эдийн засагт гадаад худалдааны нөлөөлөх эрсдэл их байгааг харуулж байна. Энэ ойрын жишээнээс сургамж авах нь зүйтэй байна.

1990-ээд онд “Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл” /ЭЗХТЗ/ задарснаар Монгол улсын хувьд дэлхийн эдийн засагт эзлэх байр сууриа үндсээр нь өөрчлөх зайлшгүй шаардлагатай болсон.

Өрсөлдөөн ихтэй зах зээл дээр худалдааны шинэ түнш орнуудыг олох шаардлагатай болсон учир Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д элсэхээс өөр арга тухайн үед байгаагүй.

ДХБ-д элсэн орсноор Монгол улс дэлхийн зах зээлд нэвтрэх илүү таатай бөгөөд найдвартай гарцтай болж, олон талт хамтын ажиллагааны хүрээнд бусад улс оронтой хамтран худалдааны зорилтуудаа биелүүлэх боломжийг олж, улмаар эдийн засгийн нээлттэй, тогтвортой бодлого баримталснаар гадаад худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих болсон байна. Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 2012 онд 4.7 тэрбум ам.долларт хүрсэн нь Монгол улсад хөрөнгө оруулсан гадны хөрөнгө оруулагчдын оргил үе байлаа.

2010-аад оны үед эрдэс баялгийн салбар эрчимтэй хөгжиж ирснээр томоохон ордуудыг шинээр нээж илрүүлсэн, дэлхийн зах зээл дээр алт, зэс, молибден, жоншны үнэ өндөр байсантай холбоотой. Хэдийгээр энэ нь хүний хөгжилд ахиц гарахад дэм болж байгаа ч, нөгөөтэйгүүр эдийн засгийн бусад салбар хоцрогдож байгаа явдал ажиглагдсан.

Тухайн үед нийт эдийн засгийн өсөлтийн үзүүлэлт өндөр харагдаж байсан хэдий ч үнэн чанартаа Монголын нийгэмд ядуурал болон тэгш бус байдал улам газар авсаар байсан. Энэ эдийн засгийн өсөлт зөвхөн эрдэс баялагийн салбараас хамааралтайгаар өссөн өсөлт байсан юм.

Манай улс хоёр хөрш оронтойгоо эрх тэгш харилцаж байна. 1990-ээд оны эхэн үед манай улсын эдийн засгийн амьдрал бүхэлдээ бараг хямралын байдалд орсон байв. Цөөхөн хэдхэн үйлдвэр, үйлчилгээний газрууд нь үлдэж бусад нь “үүдээ барьж”, сургууль, соёлын төвүүд нь эл хулг болчихсон, дэлгүүр хоршоодын лангуу хоосорч, хүн ард нь хөгшин залуугүй гадаад улс орнууд руу явж “ганзгын наймаа”-нд хошуурч байсан. Энэ түүх бол үнэхээр болсон мартах ёсгүй сургамж мөн юм.

Гэхдээ манай хөгжлийн бүх асуудал шийдэгдчихсэн хэрэг огт биш. Өнөө үед тулгарч буй асуудал, зорилт маш их байна. Шийдлээ хүлээж байгаа асуудал ч одоо цөөнгүй байсаар байна.

Энэ нь даяаршлын эрин үед өөрийн улсын эзлэх байр сууриа бодитой авч үзэхийг зүй ёсоор шаардаж байгаа нь эдийн засгийн бодит байдалтай холбогдож байна. Даяарчлал нь эхэндээ аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудын хооронд бий болж, улмаар өндөр хөгжилтэй улс ба хөгжиж байгаа, буурай хөгжилтэй улс хоорондын харилцааны шинэ хэлбэр болж, нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Манай улсын хувьд гадаад худалдаа гэдэг ойлголт хамгийн түрүүнд хөрш 2 орны гадаад худалдааны бодлоготой шууд уялдан гарна. Энэ ойлголт гадаад худалдаа хийх улс орон өргөжиж байгаа энэ үед манай улс эдийн засгийн аюулгүй байдлыг хөрш оронтойгоо холбож байгаа нь 2 хөршийн XVII зууны үеэс хэрэгжүүлж байгаа геополитикийн нөхцөл байдлын өвөрмөц онцлогоор нөхцөлдөж байна. Манай улс Ази-Европ тивийг холбох хамгийн дөт хэсэгт оршдогийг транзит тээврийн салбарт ашигтайгаар ашиглах нь зүйтэй байна.

Манай улсын хувьд аюулгүй байдлыг 1992 онд Үндсэн хуульд нэрлэснээр түүхэндээ анх удаа Үндэсний аюулгүй байдал гэж тодорхойлж, харьцангуй богино хугацаанд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /1994 он/, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль/2002 он/-тай болж, эдгээрийг орчин үеийн нийтлэг чанартай онол, эрх зүй, үзэл баримтлалын дагуу хэрэгжүүлж буй нь ардчилсан шинэ түүхэн ололтын нэг юм.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал /2010 он/-ын 3.1.1.4 дэх заалтад: “ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ” гэж зааснаар харагдаж байна.

Хүснэгт №1.

Тогтолцоо	1921-1989 он	1990-2000 он	XXI зуун
	Үр дүн	<ul style="list-style-type: none"> • Хязгаарлагдмал зах зээл • Эрх чөлөөгүй 	<ul style="list-style-type: none"> • Хумигдмал зах зээл • Эрх чөлөөтэй
Хөгжлийн хязгаарлагдмал боломж	+	+	+
Эдийн засгийн өсөлт, дэвшил	-	-	+

График №1.





График №2.

Монгол Улсын импортын гол түнш улсуудын эзлэх хувь



Монгол Улсын экспорт нь уул уурхайн болон мал аж ахуйн гаралтай түүхий эд, цөөн төрлийн бүтээгдэхүүн зонхилсон нэг орны хараат буюу БНХАУ-аас гэдгийг дээрх графикаас харагдаж байна.

Импорт нь бүх төрлийн машин тоног төхөөрөмж, нефтийн бүтээгдэхүүн, барилгын материал үйлдвэрийн зарим түүхий эд, өргөн хэрэгцээний болон хүнсний бараа зонхилсон хоёр хөршийн хараат орон болсон нь дээрх графикуудаас харагдаж байна.

Манай хөрш БНХАУ-д эдийн засгийн өсөлт нэмэгдэхийн зэрэгцээ дотоод эрэлт илүү хурдацтай нэмэгдэж байгаагаас нүүрс, цахилгаан эрчим хүч, нефтийн бүтээгдэхүүн болон бусад чухал түүхий эд, боловсруулсан материалын нийлүүлэлт, хангалт дутагдалд орж байгааг тогтоож тухайн улсын Засгийн газар нь зохицуулах арга хэмжээ байнга авч хэрэгжүүлж байна.

Мөн Хятад, Япон, Өмнөд Солонгос улсуудын хөгжлийн түвшин адилгүй байгаа хэдий ч аж үйлдвэр, худалдааны салбарт тэд бие биенээ нөхөх байдлаар оршиж тогтнох нь зайлшгүй юм. Эдгээр улсууд хоорондоо өрсөлдөн оршдог хэдий ч хамтын ажиллагаа нь өрсөлдөөнөөс илүү их далайцтай гэдэг дээр талууд санал нэгддэг байна. Эдгээр 3 улсын ДНБ-ний нийлбэр нь дундажаар дэлхийн нийт ДНБ-ны 23%-ийг, Зүүн Азийн 13 орны нийт ДНБ-ны 90%-ийг тус тус эзэлдэг байна.

Монгол, Хятадын гадаад худалдаа нь манай орны нийт гадаад худалдааны эргэлтийн 1/3-ийг дангаараа эзэлж байна. Манай улсаас Хятад улс руу хийсэн 2014 оны экспорт 5070.04 сая.ам.дол-т хүрч өмнөх онтой харьцуулахад 37%-иар өсч, Хятад улсаас авсан импорт 1729.82 сая.ам.дол-т хүрч өмнөх онтой харьцуулахад 3.1%-иар буурсан байна.

Зүүн хойд Азийн бүс нутаг дахь хамгийн тулгамдсан асуудал бол эрчим хүчний хангамж болоод байна. Дэлхий дээр хамгийн том газрын тосны үйлдвэрлэгч бөгөөд байгалийн хийн хамгийн их нөөцтэй улс болох ОХУ нь ойрын жилүүдэд байгалийн хий, газрын тосоор Хятад, Япон, Өмнөд Солонгос зэрэг улсуудын импортын хэрэгцээг хангах хамгийн боломжит эх үүсвэр болоод байна.

Цаг хугацаа урсан өнгөрөхтэй зэрэгцэн дэлхийн газрын тосны нийлүүлэлт мэдэгдэхүйц багасч, хэрэгцээ хурдацтайгаар нэмэгдэж, Зүүн Ази дахь томоохон газрын тос, байгалийн хийн хэрэглэгчид болох Япон, Хятад зэрэг улсуудын өрсөлдөөн улам бүр ширүүсэх хандлагатай болж байна. Энэ хандлагыг Оросын газрын тос, байгалийн хийн шугам хоолой барих төслийн үйл явцаас ажиглаж болно.

Монгол Улсын стратегийн чухал түүхий эд болох нефтийн бүтээгдэхүүний хэрэгцээний 90-ээс доошгүй хувийг манай хойд хөрш болох ОХУ-ын байгалийн арвин нөөц болох Дорнод Сибирээс хангасаар ирсэн ба ойрын ирээдүйд ч энэ байдал хадгалагдах

төлөвтэй байна. Харин өөрийн нутаг дэвсгэрээс олборлосон түүхий нефтийг манай улс түүхийгээр нь БНХАУ-д экспортолсоор л байна.

Монгол Улс нийт импортолж байгаа барааныхаа ойролцоогоор 30 орчим хувийг ОХУ-аас импортлож байгаа нь манай орны импортын 1/3-ийг дангаараа эзэлж байна. Хэдийгээр манай улсын нефть бүтээгдэхүүний хэрэгцээ харьцангуй бага боловч нефтийн бүтээгдэхүүний бүх хэрэгцээ цорын ганц эх үүсвэрээс хамааралтай байх нь улс орны аюулгүй болон тогтвортой байдалд эрсдэл бий болгож байна. Иймээс хэрэгцээнийхээ 1/3-ийг найдвартай хангах өөр эх үүсвэртэй болох нь чухал юм.

Хэрэв худалдаа эдийн засгийн өсөлтөд түлхэц өгч, ажлын байр шинээр буй болгож байгаа бол нэг хүнд ноогдох орлогыг нэмэгдүүлэхийн сацуу хүний чадавхийг бэхжүүлнэ. Чадавхижуулах гэдэг нь хүмүүсийн амьдрал дахь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах явдал юм. Хүмүүсийг дэлхийн эдийн засгийн даяарчлалаас үүдэх сөрөг үр дагавраас хамгаалах шаардлагатай. Дэлхийн зах зээлд нэгдэх нь олон хүний хувьд бүтээгдэхүүнээ борлуулж ядуурлаас гарах боломжийг олгодог ч, импортлогчид зах зээлээ хамгаалах худалдааны арга хэмжээ авсны улмаас экспортын чадвараа хөгжүүлэхээр хязгаалагдмал санхүүгийн хөрөнгө нөөцөө зарцуулсан хүмүүсийн ирээдүйн амьжиргаа баталгаагүй болох эрсдэл байдаг байна.

Эдийн засгийн интеграцилал нь дотоодын зах зээлийг өрсөлдөөнтэй болгодог, харамсалтай нь ихэнх тохиолдолд импортоос үүдсэн шударга бус өрсөлдөөн бий болох нь түгээмэл. Орлого багатай хүмүүс, тэр дундаа газар тариалангийн салбарынханд, энэ нь нэн сөргөөр нөлөөлдөг бөгөөд Монгол улсад ийм байдал хэдийнээ үүссэн байна.

Худалдааны бодлогын хувьд түүний боловсруулалт, хэрэгжилтэнд нийгмийн бүх төлөөлөл оролцох механизмыг бий болгох, үйлдвэрлэгчдэд тэдний аж амьдралыг нь доройтуулж байгаа шударга бус өрсөлдөөн, хямд үнэ бүхий газар тариалангийн татааст импортын эсрэг хамгаалуулах хуулийн эрх олгох замаар иргэдийг чадавхижуулах боломжтой.

Худалдааны гэрээний заалтууд болон засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үүрэг, амлалтууд амьдралд нь үр дагавар өгөх үйл явц, арга хэмжээнд нөлөөлөх хүмүүсийн чадварыг хязгаарласан байж болохгүй.

Энэ нь тухайн улс орон дахь гадаадын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хянах явдалд мөн хамаатай. Худалдааны бодлогын хувьд, улс орон бүр олон улсын худалдааны харилцаанд үндэсний сонирхлоо үр дүнтэйгээр хамгаалах хэлэлцээрийн бүтэц, чадварыг бэхжүүлэх замаар бага орлоготой иргэдээ чадавхижуулж чадна.

Монгол улс далайд гарцгүй хөгжиж буй 31 орны нэг бөгөөд ОХУ, БНХАУ-ын дунд оршдог. Бусад бүх хүчин зүйлийг тогтвортой байхад далайд гарцгүй байрлал дангаараа худалдааны өртгийг нэмэгдүүлнэ.

Адам Смитын үе болох XVIII зууны сүүлээс эхлэн олон эрдэмтэн далайн эрэгтэй болон далайд усан замаар холбогдсон улс орнууд далайд гарцгүй орнуудаас харьцангуй хурдан хөгждөг гэж ажиглажээ.

Тус онол ёсоор далайд гарцгүй байрлалтай улс орон бараа бүтээгдэхүүн, хүн хүч, санаа санаачилгын урсгалын хувьд сул дорой байр суурьтай байдаг байна. Зах зээлд нэвтрэх, худалдаа хийх, шинэ технологи нэвтрүүлэх зэрэг нь эдийн засгийн хөгжлийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тээврийн зардал өндөр байгаагаас бизнес эрхлэгчдийн хувьд гадаадын зах зээлд нэвтрэх болон үйлдвэрлэлийн орчин, худалдан авахад хүндрэлтэй байвал эдийн засгийн бодит өсөлтөд сөргөөр нөлөөлнө.

Гэвч далайд гарцгүй ч гэсэн манай хоёр хөрш орны зах зээлд нийлүүлэх бараа, бүтээгдэхүүний эрэлт их учраас хөрш оронд гадаад худалдаагаар дамжуулан хөгжих боломж байсаар гэж үзэж байна. Одоо үед Эдийн засагт гадаад худалдааны нөлөөлөх эрсдэл өндөр байна.

Монгол Улс бүс нутгийн орнуудтай харьцуулахад харьцангуй нээлттэй эдийн засагтай орон болох нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан индексээс харагдсана. Манай орны гадаад бодлогын 20-иод жилийн амжилт нотлож байна. Нөгөө талаас тодорхой амжилтандаа хэзээ ч назгайрч болохгүй, эдийн засгийн үүднээс гадаад бодлогод, ялангуяа, санхүүгийн үйл ажиллагаанд хамгийн олон төрлийн арга хэлбэрийг, шинэ соргог оновчтой гарцыг хайсаар байх учиртай.

Хэдийгээр хоёр хөрштэй харилцах харилцаа түүхэнд байхгүй таатай, тэнцвэртэй байгаа хэдий ч манай улсын бодлого байр сууринаас илүүтэй гадаад орчноос, хоёр

хөршийн хоорондын харилцааг судлах, Тухайлбал, стратегийн түншлэлийн хэлбэрээр илрэх харилцаанаас хамаарч байгааг тооцож, харилцаанд өөрчлөлт гарах, хүйтэрч харилцаа муудах, эсвэл хэт сайдах, нөхцөлд баримтлах гадаад бодлогын урьдчилсан прогностой байх. Харилцааг хэт нэг талруу хазайхаас сэргийлсэн тоглолт явуулах, хэт сайдах нь хоёр хөршийн хавсарсан шахалтанд орох, хэт муудах нь аль нэгийг сонгож, эргэж нэг гүрний шууд нөлөөнд орох аюул заналыг дагуулж байдгийг санах нь зүйтэй.

Гуравдагч хөршийн бодлогыг цаашид үргэлжлүүлэх нь Монгол улсын эдийн засагт эерэг нөлөөтэй боловч аль нэг улсыг тусгайлан цохож, түүнтэй нягт харилцаанд орох нь эргээд гуравдагчийн зүгээс үзүүлэх тодорхой шахалтад өртөх аюултайг ямагт санах. Гуравдагч хөршийн бодлогыг зөвхөн бүрэн эрхт улсаар хязгаарлалгүй зарим судлаачдын үзсэн байгаагаар олон улсын харилцааны шинэ тоглогчдын хэмжээнд хүлээн зөвшөөрч өргөтгөх боломжтой.

Монгол улс гадаад бодлогын чухал зорилгоо хэрэгжүүлэн Зүүн хойд Азийн салбар бүсэд бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн улс болж чадсан ч цаашид хоёр хөрш, гол донор, хөрөнгө оруулагч орнууд болох Япон, Өмнөд Солонгос, Олон улсын хамтын нийгэмлэгийн хориглолтод буй Умард Солонгосоор өөрийн гадаад орчныг хязгаарлах нь эрсдэлтэй алхам болж болзошгүйг анхаарч ажиглах нь сайн тал болно.

Учир нь эргээд хөрш орнууд болоод хандивлагчдын зүгээс үзүүлэх шахалтад өөрийгөө оруулан, хоёр талт харилцаа хязгаарлагдмал байдалд орж, улмаар зогсонги байдалд орох эрсдэлтэй байх нөхцөл байдлыг тооцоолох нь зөв юм.

Олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоогоо бэхжүүлж чадсан амжилт дээрээ тулгуурлан транзит тээврийн идэвхтэй байдлаар оролцоогоо өргөтгөн бэхжүүлэх нь зүйтэй байна.

Даяаршлын эрин үед бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал нь эдийн засгийн харилцааны цоо шинэ агуулга дээр тулгуурласан геоэдийн засгийн шинэ орчныг эзэмших зарчим болсон. Бүсчлэлийг тивээрээ, тив дотроо бүс нутгаараа, улс дотроо бүс нутгаараа гэсэн олон хэлбэртэй байна.

Газар зүйн түгжигдмэл байршил буюу 2 улсын дунд далайд гарцгүй манай улс нь нээлттэй бодлогыг эрхэмлэж, үндсэрхэг, уламжлалаа товойлгон шинэчлэлээс болгоомжлон, харьцангуй хараат зэрэг жижиг орны нийтлэг чанарыг манай улсаас харж болно. Жижиг улсын үндэсний ашиг сонирхол нь төр, нийгэм, иргэний ашиг сонирхолыг агуулсан байдаг.

Бүс нутгийн хөгжлийн үндсэн хүчин зүйлд “Орон зайн давуу чанар” буюу байршлын онол гэж байдаг. Энд Эдийн засгийн аливаа үйл ажиллагааны дүнд орон зай давуу байдал илрэн гардаг. Давуу байдал нь нэг бүс нутагт тодорхой үйлдвэрлэл юм уу, бизнесийг эрхлэх боломжийг бүрдүүлдэг. Манай орны ирээдүй бусад улс орноос бус зөвхөн бид бүгдээс л хамаарна. Бидэнд ер нь аврагч хэрэггүй, гадны зөвлөх мэргэжилтнүүдээс илүүтэй, өвгөдийнхөө сургаалийг судлах хэрэгтэй.

Дүгнэлт

Монгол улсын хувьд хүн ам цөөхөн учраас дотоодын зах зээлийн эрэлт харьцангуй бага. Тиймээс гадаад зах зээлээс илүү орлого олох боломжтой гэж хэлж болно. Тиймээс манайх шиг жижиг орны хувьд экспорт бол чухал салбар юм.

Одоо үед Эдийн засагт гадаад худалдааны нөлөөлөх эрсдэл өндөр байна. Харин энэхүү салбарт нөлөөлөх нөлөөллүүд, тэр дундаа саад бологч хүчин зүйлсийг олж илрүүлэх нь энэхүү сэдвийн шинэлэг тал болсон.

Чөлөөт зах зээлийн эдийн засагт хувийн чөлөөт өрсөлдөөнийг чухалчилж, эдийн засаг дахь төрийн оролцоог хязгаарлахыг шаарддаг. Гэтэл манай оронд төрийн зохицуулалт байхгүй бол манай улс төрөөр юу хийх билээ гэсэн үзэл мөн байна. Төр байхын хамгийн том зүйл бол улс орноо хөгжүүлэх, ард иргэдийг сайхан амьдруулах гэж ойлгож болно. Иймээс тодорхой зохицуулалт байх хэрэгтэй гэж үзэж байна.

Хөгжиж буй орнуудын хувьд хүн амын өсөлт экспортод хамгийн сөрөг нөлөөг үзүүлж байгаа нь энэ талаар улс орнууд ямар нэг арга хэмжээ авах хэрэгтэйг харуулж байна. Хятад улс энэ талаар арга хэмжээ авдаг хэдий ч бусад буурай хөгжилтэй орнууд төдийлөн анхаардаггүй юм. Нэг талаараа экспорт нь ДНБ-ний бүрэлдэхүүн хэсэг болох боловч ДНБ нь сайжирснаар экспорт өсөх тул бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг сайжруулах хэрэгтэй.

Дэлхий худалдааны байгууллагын гишүүн орон болсноор Монгол улс бусад орны зүгээс түүний эсрэг хэрэгжүүлэх худалдааны сөрөг арга хэмжээг ДХБ-ын Маргаан шийдвэрлэх харилцан ойлголцлын тогтолцооны хүрээнд өөрт таатайгаар шийдвэрлүүлэх боломжтой болсон юм. Түүнчлэн, өөрийн гадаад худалдааны гол түнш болох ОХУ, БНХАУ хоёрыг ДХБ-д гишүүнээр элсүүлэх хэлэлцээрт оролцож эрхээ ашиглаж байна. Энэ эрхээ ОХУ-ын гишүүнчлэлд идэвхтэй ашиглаж тус улс элсэн ороод 5 жил болсон байна.

Томоохон их гүрнүүд улс төр, эдийн засаг, хууль, худалдаа, далай тэнгисийн баялаг, ашигт малтмал, газрын тосны нөөц гэх мэт хөгжилд түлхэц өгөхүйц болдог эх үүсвэрүүдийг эзэмших, ашиглах, хяналтандаа байлгахыг зорьдог.

Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтлах явдал болж байна.

Эдийн засгийн олон тулгуурт бүтэц нь импортыг орлох, экспортыг дэмжих эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрийг хөгжүүлэх төслийг авч хэрэгжүүлж, эдийн засгийн талаас нь дэмжлэг үзүүлэх хөшүүргийг бий болгох нь зүйтэй байна. Ингэснээр эдийн засагт нөлөөлөх гадаад худалдааны эрсдэлийг бууруулж өгч чадна гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001 он
3. Гадаад худалдааны барааны статистикийн мэдээлэл, 2005-2014 он
4. Буджаргал. Б, Зөв хөгжил агуу үндэстэн, Улаанбаатар, 2013 он
5. Вечканов. Г. С, Эдийн засгийн аюулгүй байдал, Орчуулсан: Лувсанцэрэн. Д, Улаанбаатар, 2011 он
6. Даяаршил ба Монгол улс: Үндэсний болон хүний аюулгүй байдал, Улаанбаатар, 2004 он
7. Жижиг улсын аюулгүй байдал Өнөө, ирээдүй, Улаанбаатар, 2010 он
8. Тунгалаг. Д, Эдийн засгийн аюулгүй байдлын тайлбар толь, Улаанбаатар, 2005 он
9. Ринчинбазар. Р, Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлууд, Улаанбаатар, 2004 он

ХҮҮХДИЙН ЭСРЭГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ АСУУДАЛ

М.Уугантуяа

Дотоод хэргийн их сургуулийн магистрант

Товч агуулга: Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүд, охид, хүүхэд бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн хохирогч болох үзэгдэл их болсон. Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээлснээр 2015-2017 онд шүүхээр 786 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Мөн Цагдаагийн ерөнхий газрын гаргасан тоон мэдээллээс харахад 2015-2018 оны хооронд хүчингийн гэмт хэрэг 1417 гэмт хэрэг бүртгэгдсэн ба үүнээс 1382 хохирогчоос 617 нь насанд хүрээгүй хүн хохирчээ. 2017 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчингийн гэмт хэргийн тоо 30 хувиар нэмэгдсэн. Гэвч энэ тоо мэдээлэл бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийг бүхэлд нь илэрхийлэхгүй юм. Ихэнх тохиолдолд хохирогчид хууль хяналтын байгууллагад хандахгүй өнгөрөөдөг, хандсан ч хэрэгсэхгүй болох, өргөдлөө татаж авах, гомдолгүй, тохиролцсон гэх зэргээр асуудал орхигддог. Мөн мөрдөн байцаалтын үе шатад хохирогчид мэдүүлгээс буцаж эхэлдэг. Энэ нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн эрх зүйн орчин дутмаг, хохирогчид ээлтэй бус байгаагийн илрэл юм. Хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд, охидыг хууль сахиулах байгууллагын ажилтнууд зүй бусаар харьцах, буруутгах зэргээр нэр төрийг нь гутаах тохиолдол одоог хүртэл байсаар байна.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт явдлыг шалган тогтооход эрх зүйн орчин, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны хувьд алдаатай, уялдаагүй асуудлууд байхын зэрэгцээ гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийн эрсдлийг тооцон хүүхэд тус бүрт тохирсон хамгаалалт, эрүүл мэндийн, нийгмийн болон сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлэх тусгайлсан хамгаалалт, хохирлын нөхөн төлөлт байхгүй байгаа нь хохирогч давхар хохирсоор байна.

Иймд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж, урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулж, хохирогчийн хамгаалалт, тусламж үйлчилгээг сайжруулсанаар тухайн гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Мөн энэ хорвоод төрөөд амьдралын хөлгүй их далайд сэлж сурах гэж байгаа алдрай бяцхан дүү нартаа хүний ёсоор амьдрахад нь бага ч болов тус дэм болохын тулд энэхүү сэдвийг сонгон судалж дүгнэлт, санал дэвшүүлэв.

Түлхүүр үгс: Хүүхэд, бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэг, хохирогч, хохирол нөхөн төлөлт.

Оршил

Монгол Улс нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцид 1999 онд, Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах тухай 182 дугаар конвенцид 2002 онд, 1989 оны НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцийг баталсан эхний 10 улсын тоонд ордог. Үүнээс хойш хүүхдийн эрхийн чиглэлээр гарсан гэрээ, конвенциуд хөтөлбөр, дүрэм журмуудад нэгдэн орсоор ирсэн.

Хүүхэд хамгааллын эрх зүйн орчин хангагдаж, хамгаалагдсан хэдий ч хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой, хүүхэд хамгааллын асуудал хэвлэл мэдээлэл, цахим орчинд өргөн хүрээтэй яригдаж байгаа нь хэрэгжилтэнд хяналт тавих цаг нь болсныг илтгэж байна. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс, иргэдийн ухамсар, гэр бүлийн тогтворгүй байдал гэх мэт олон хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг ихээр гарах болоод байна.

Энэхүү өгүүллийг бичихдээ хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй холбоотой эрдэм шинжилгээ, судалгааны үр дүн, бүтээл, магистрын ажил, илтгэл, өгүүлэл, гарын авлага, нэг сэдэвт зэрэг эрдэм шинжилгээний бүтээлүүдийг судалсан болно. Түүнчлэн Монгол улсын цагдаагийн байгууллага, прокурор, шүүхийн статистикийн судалгаанд үндэслэн хүүхэд бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт өртөж хохирсон байдлын дүн шинжилгээ хийв. Судалгааг явуулахад нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, баримт бичиг, системийн дүн шинжилгээ хийх зэрэг шинжлэх ухааны түгээмэл аргыг ашиглав.

Хүүхдийн эрхийг хамгаалах, бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрхийг хангах талаарх эрх зүйн актуудыг судалж, хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж практикт тулгамдсан асуудлыг тодорхойлж санал зөвлөмж дэвшүүлсэн.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэгт өртөж хохирсон байдлын талаар явуулсан санал асуулга, чанарын судалгаануудад дүн шинжилгээ хийж, хэрэгсэхгүй болгосон энэ төрлийн тодорхой хэргүүдийн кейс судалгааг гаргаж дүгнэлт хийлээ.

Мөн Хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэгтэй байгууллага болон хуулийн байгууллагуудаас хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний арга барил, шударгаар шүүх, хохирлыг нөхөн төлөх үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, санал дэвшүүлсэнд оршино.

Судлагдсан байдал

Эрдэм шинжилгээ судалгааны ажлын хүрээнд: Д.Төмөрбаатар “Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг нотлох ажиллагаа” УБ, 2014 он, Ө. Дэлгэцэцэг “16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж зүйлчлэлийн зарим асуудал” магистрын ажил УБ, 2014 он, ХСИС-ийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс” судалгааны ажлын тайлан УБ, 2018 он, Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин. тайлангийн эмхтгэл-2 /2010-2011/ он УБ 2012 589-606 дахь тал, Г.Оюунболд “Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулах нь” УБ 2010 он, “Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл” ХЭҮТ. УБ 2007 он тус тус судлагдсан байна.

Хүүхэд бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт хохирсоор байх үү?

Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл /Child Sexual abuse/ гэж бэлгийн харилцааны зорилгоор хүүхэдтэй шууд болон шууд бус замаар ямар нэгэн үйлдэл хийхийг хэлнэ. Энэ нь гэмт хэрэг юм. Хүчирхийлэгч нь заль мэх хэрэглэх, ямар нэгэн зүйл өгч хуурах, сүрдүүлэн, заналхийлэх ба зарим үед хүч хэрэглэн хүүхэдэд хохирол учруулдаг. Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл гэж зөвхөн хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон тохиолдлыг бус доорх завдалт, үйлдэл, эс үйлдлийг хэлдэг. Хүчирхийлэгч нь хүүхдийг дараах бэлгийн хүчирхийлэлд оролцуулсан тохиолдолд хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж үзнэ. Үүнд: хүүхдийн бэлэг эрхтнээр оролдох, амаар секс хийх зорилгоор хүүхдийн биеийг илж таалах, Үтрээ юм уу шулуун гэдэс рүү нь хуруугаа, бэлэг эрхтнээ болон өөр ямар нэгэн зүйл шургуулах, Насанд хүрсэн хүний бэлэг эрхтнийг үзүүлэх, секс санал тавих бүхий л тохиолдлыг гэмт хэрэг гэж үзнэ.²⁴

Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг²⁵ Бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэж 14 насанд хүрээгүй хүнийг хүчиндсэнийг ойлгоно. Бага насны хүүхдийг хүчиндсэн бол Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэрэглэсэн, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг үйлдсэн зэрэг субъектив талын шинжийг хангасан байхыг шаардахгүй.²⁶ Өөрөөр хэлбэл, гэмт этгээд бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн объектив нууц мэдээлэл гээд олон талын хамгаалалт хөндөгдөж байдаг.

Улс болгон хүчирхийллийн тэр дундаа бэлгийн хүчирхийллийг өөр өөр өнцгөөс хардаг. Энэ нь тухайн улс орны зан заншил, соёлоос хамаардаг. Хүчирхийллийг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн²⁷ 19-р зүйлд зааснаар “гэмтэл бэртэл учруулах, зүй бусаар харьцах, анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөлжих зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэр” хэмээн тодорхойлсон байна.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн гаралт

2015-2017 онд шүүхээр 786 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Мөн Цагдаагийн ерөнхий газрын гаргасан тоон мэдээллээс харахад 2015-2018 оны хооронд хүчингийн гэмт хэрэг 1417 гэмт хэрэг бүртгэгдсэн ба үүнээс 1382 хохирогчоос 617 нь насанд хүрээгүй хүн

²⁴ О.Мягмар “Сэтгэц заслын зөвлөгөөний онол арга зүй” УБ 2010 он 172-р тал

²⁵ 1. С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүйн тусгай анги” Улаанбаатар, 2018 он

²⁶ Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар.

²⁷ НҮБ-ийн Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989 он

хохирчээ. 2017 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчингийн гэмт хэргийн тоо 30 хувиар нэмэгдсэн.



Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргээс хамгийн их тоотой үйлдэгдсэн гэмт хэрэг нь хүчиндэх гэмт хэрэг байна. Хүчиндэх гэмт хэрэг нь 2014 оноос байнга өсөж байгаа бөгөөд 2017 онд хамгийн өндөр буюу 32,4 хувиар өссөн байна. Тус гэмт хэргийн улмаас нийт сүүлийн 5 жилийн байдлаар 637²⁸ бага насны хүүхэд хохирогч болсон байна.

Бага насны хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нь ихэвчлэн ахуйн хүрээнд, далд аргаар үйлдэгддэг бөгөөд хохирогчийн бие махбодь, сэтгэл зүйд хүнд хор уршиг учруулдаг, тухайн хэргийг шалгаж шийдвэрлэх явцад хохирогчийн аюулгүй байдал, нэр төрийн баталгаа, хувийн нууц мэдээлэл гээд олон талын хамгаалалт зөрчигддөг.

НҮБ-аас 57 оронд хийсэн судалгаагаар²⁹ хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн 11 хувь нь хуулийн байгууллагад ханддаг гэсэн бол манай улсад үүнийг тооцоолж гаргасан судалгаа одоогийн байдлаар байхгүй байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тоо мэдээнээс харахад нийт хүн амын 17%-ийг эзэлж буй 10-29 насны 500 хүн дутмын нэг нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн золиос болж байна. ЭМЯ, Глобал сангийн захиалгаар ХТЭТ-ийн гүйцэтгэсэн 2017 оны судалгааны үр дүнгээс үзэхэд³⁰ Цагдаагийн байгууллагад хандсан 3 хохирогч тутмын 2 нь шүүхээр асуудлаа эцэслэн шийдвэрлүүлсэн гэжээ. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчдын 53,7% нь гэр бүлийн гишүүдээс үйлдсэн хүчиндэх гэмт хэргийн хохирогч болдог ба ихэвчлэн цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй, хүүхэд хохироод л үлддэг асуудал түгээмэл болсон.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийн хамгаалалт

Манай улсад бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчдыг хүлээн авах тусгай газар байдаггүй. Хүчирхийлэлд өртсөн хохирогч хаана хандахаа мэддэггүй. Төрийн бус байгууллагад хандах хүсэл байгаа хэдий ч шийдвэр гаргах нь түүнд хэцүү байдаг.

Хүчингийн гэмт хэргийн талаар мэдэгдэхийг хүсч Цагдаагийн газарт хандахдаа мөн л ганцаарддаг хэн нэгэн ойр дотны гэр бүл, хамаатнаасаа тусламж хүсдэг. Зарим хохирогч өөрт тохиолдсон явдлыг нууц хэвээр нь үлдээж, хэнд ч ярьдаггүй ч цаг хугацаа өнгөрөх тусам хүчирхийлэлд өртөснөөс нь болж ямар нэгэн сөрөг шинж тэмдэг илрэх магадлал өндөр байдаг.

Иймд хүчингийн тэр дундаа насанд хүрээгүй хохирогчтой харьцах талаар мэргэжлийн бүлгийнхэн нэгдсэн арга, тактик боловсруулах шаардлагатай. Жишээ нь: тухайн гэмт хэргийн хохирогч хууль сахиулах, эмнэлэгийн байгууллагад хандахад анхны туслалцаа үйлчилгээг ижил хүйсийн хүн үзүүлэх нь түүний сэтгэл зүйн хувьд харилцаа тогтооход амар байх болно. Учир нь эсрэг хүйсийн хүн хохироосон гэмт хэрэгт бүх эсрэг хүйсийн хүмүүсээ хамаатуулж үзэх хандлага илүү давамгайлдаг.

²⁸ Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын статистик тоо мэдээнээс.

²⁹ UN Women /May 2013 /. Factsheet- Global, Progress of the World's Women 2011-12 /PDF/

³⁰ ЭМЯ, ГС, ХТЭТ, “ Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх” судалгааны тайлан. УБ, 2018 он, 10 дугаар хуудас

Хохирогчийн ярианаас.. Эрхээ хамгаалуулахаар цагдаагийн байгууллагад очиход эрэгтэй байцаагч байцаалт авсан. Тэр байцаагчийн өрөөнд орсон үеэс эхлээд байнгын дарамт, айдас, үзэн ядсан харц, буруутгасан байдал, доог тохуу хийх зэрэг нь хүнд байдаг. Яах гэж хуулийн байгууллагад хандавдаа гэж бодоход хүргэсэн... ийм учраас хохирогч тэр болгон хуулийн байгууллагад хандахыг хүсдэггүй, энэ асуудлыг орхидог.

Хохирогчийн талаар мэдээлэл тараахгүй байх, хохирогчийг гэмт этгээд, түүний хань хамсаатнаас тусгаарлах нь гэмт явдалд дахин хохирохоос урьдчилан сэргийлэх чухал арга хэмжээ мөн. Энэ арга хэмжээнд: хохирогчийг яллагдагч, мөн гэмт хэргийн хамтран оролцогчид, яллагдагчдын ойр нөхөд болон, гэр бүлийн гишүүдтэй харилцаа холбоо тогтоох явдлыг таслах зэргийг хамааруулж болно. Түүнчлэн хаягийн товчоо, шуудан холбооны лавлах алба, иргэний бүртгэлийн алба, замын аюулгүй байдлын салбарууд болон төрийн мэдээллийн бусад сангуудаас тухайн оролцогчийн мэдээллийг гаргаж өгөхийг хориглох зэргийг оруулан тооцож болно. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бусад этгээдүүдэд хохирогч- бие хүнтэй холбоотой мэдээллийг задруулахгүй байх талаар, гарын үсэг зуруулж сануулах байж болно.³¹

Эрүүл мэндийн тусламж, ач холбогдол

Хүчирхийлэлд өртсөн хохирогч аль болох хурдан эрүүл мэндийн тусламж авах ёстой. Шүүх эмнэлэг, эмэгтэйчүүдийн үзлэгт орж ямар нэг гэмтэл учирсан эсэхийг шалгуулах хэрэгтэй. Шүүх эмнэлгийн шинжилгээгээр үүссэн бэртэл гэмтлээс гадна хүчирхийлэгчийн үрийн шингэн үлдсэн эсэх, ДНК-ийн шинжилгээнд өгч болохуйц үлдэц байгаа эсэхийг тогтоолгох шаардлагатай. Ялангуяа насанд хүрээгүй хохирогчийн хувьд охин хальс гэмтсэн эсэх, урагдал зэргийг сайн тогтоох нь цаашдын эмчилгээнд тустай. Мөн эмчийн үзлэгт хамрагдахын зэрэгцээ заавал жирэмслэлт, ДОХ/ХДХВ, бэлгийн замаар дамжин халдварлаж болох өвчин байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Эрүүл мэндийн үзлэг шинжилгээний хариу нь цаашид гэмт хэргийг хуулийн дагуу шалгахад чухал ач холбогдолтой. Хохирогч хүчирхийлэлд өртсөн даруйдаа биш, тодорхой хугацааны дараа эмнэлэгт үзүүлсэн ч гэсэн тус үзлэг, шинжилгээ чухал. Магадгүй хохирогч хүчирхийлэлтэй холбоотой эрүүл мэндийн асуудал үүссэнээс, эсвэл бүх зүйл хэвийн байгаа эсэхийг мэдэх гэж ирсэн ч байж болно.³²

Чухамдаа хүн өөрийн санаа сэтгэлээр амьдрал ахуйгаа бүтээж зурдаг бөгөөд намайг тоодоггүй, хайрладаггүй гэх айдас бүр хүүхэд ахуй цагаас тогтдог, Хүний бүх л эд эрхтэн нүдэнд үзэгдэж гарт баригддаг гэтэл сэтгэл гээч зүйл тийм мэдрэмжинд мэдрэгдэхгүй ч оршин байдаг нь туйлаас үнэн юм.

Чойном гуайн жаргал зовлон гэж найраглалд, жаргал ховор цагт жаргалын бага нь амттай, хэт элбэг жаргал дунд хэсэгхэн зовлон ч бас амттай гэж хэлдэг. Хүн яг л энэ найраглалд бичсэн шиг үргэлж үүл шиг хувирч өөрчлөгдөж байдаг сэтгэлийн л амьтан юм. Хэн нэгнийг урмаар тэтгэж гэгээлэг бүхнийг хүсэж байвал хэн ч гэсэн өөртөө итгэлтэй байж сайхан бүхнийг төсөөлж, хийж бүтээж, бусдад түгээж чадна харин түүнийг гутаан доромжилж, муу нэрийн шошго зүүх, аль нэг дутагдалтай зүйлээр нь доромжлох ялгаварлан гадуурхах зэрэг нь тухайн хүний өөрийгөө үнэлэх үнэлэмж, амьдралын идэвхгүй болгоно. Үүнээс болж хорт зуршил хэрэглэх муу муухайд уруу татагдах өөрийгөө болоод бусдыг хайрлах сэтгэлгүй болох үүнээсээ болоод ганцаардал, сэтгэл гутралд орох нь олонтаа тохиолддог. Үг гэдэг хэлэхэд амархан хэдий ч туулах зам хол, хүрэх оргил нь хүртэл өндөр байдаг. Үгээр хүнийг үхүүлчиж бас амьдруулж ч болдог хүчтэй зэвсэг юм. Тиймээс хүчингийн гэмт хэргийн хохирогч нэг бүрт сэтгэлийн дэм, итгэлийн гэрэл хамгаас чухал юм. Хохирогчдыг цагдаагийн байгууллагад хандсан үеэс эхлэн мэргэжлийн сэтгэл судлаачийн зөвлөгөөгөөр хангах, сэтгэл зүйн хувьд тогтвортой хэвийн болоход нь туслах нь чухал. Мөн тухайн гэмт хэргийг мартаход нь туслах орчин нөхцлөөр хангах шаардлагатай. Мөн тухайн гэмт хэргийг мартаход нь туслах орчин нөхцлөөр хангах шаардлагатай. Иймд Цагдаагийн байгууллагын салбарт сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлэх, мөн хүчиндэх гэмт хэрэг тэр дундаа хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт тусгай мэргэшсэн баг ажиллах ёстой гэж бодож байна. Хүүхэд бол цэвэр

³¹ Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктимологи” УБ 2005 он 531-р тал

³² Бэлгийн хүчирхийлэл гарын авлага УБ 2019 он. 57-р тал.

ариухан цагаан цаас харин томчууд бид тэднийг бохирдуулж дээр нь хамаагүй сараачдаг....


Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа³³

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүчиндэх гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн 530 хоригдол байгаа нь нийт ял эдлэгсдийн 15 орчим хувийг эзэлж байна. Тэдгээрээс 0-14 хүртэл буюу бага насны хүүхэд хүчиндсэн 387, 15-18 насны хүүхэд хүчиндсэн 63, 18-аас дээш насны хүн хүчиндсэн 80 хоригдол ял эдэлж байна.

Энэ тоо баримтаас үзэхэд Монгол Улсад хүчиндэх гэмт хэрэг ихээхэн үйлдэгдэж байгаа нь харагдана.


Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын 19.4% буюу 103 нь хохирол барагдуулах төлбөрийн өртэй байна.

График 1.15. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн төлбөртэй хоригдлын тоо



Төлбөртэй хоригдлын төлбөрийн хэмжээ, хохирол нөхөн төлсөн байдлыг авч үзвэл:

График 1.16. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын төлбөр барагдуулалт



37 хоригдлын 58.808.240 төгрөгийн төлбөрийг ар гэрээс нь барагдуулсан бол бусад хоригдлын төлбөрийг барагдуулах зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хоригдлыг цалинтай ажлын байраар хангахад ихээхэн анхаарч ирсэн. 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4-т заасан “хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх” тухай заалт 2017 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас хасагдсан нь хоригдлыг хөдөлмөр эрхлүүлж төлбөр барагдуулах ажил үндсэндээ зогссон юм. НҮБ-аас 1955 онд баталсан Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдэд: “Бүх ялтан хоригдлууд ... биеийн болон сэтгэл мэдрэлийн онцлог таарсан хэмжээгээр хөдөлмөрлөх үүрэгтэй гэсэн ч тэдний хөдөлмөр нь нийгэмд болон өөрт нь тустай байх, хоригдлыг ажлын байраар хангах нь юуны өмнө тэднийг хорих

³³ ШШГЕГ-ын мэдээлэл. 2018

газраас суллагдсаны дараа шударга хөдөлмөр эрхлэхэд нь туслах, ур чадварыг бий болгох дээшлүүлэхэд оршино. Хоригдол цалингийн тодорхой хэсгийг ар гэртээ явуулах, хувийн хэрэгцээнд шаардлагатай эд зүйл авахад зарцуулна. Хоригдлын цалингийн тодорхой хувийг хорих ангийн захиргаа үлдээж хадгалах ба хоригдлыг ял эдэлж дууссан, суллагдах үед түүнд буцааж өгөх ёстой”³⁴ заалтыг удирдлага болгон хоригдлыг албадан хөдөлмөрлүүлж учруулсан хохирлыг төлүүлэх заалт хэрэгжихгүй болсон болов уу? хэмээн таамаглаж байна.

Хоригдлын эрх зүйн байдлыг дээрдүүлэх нь зүйн хэрэг ч хохирогчийн эрх зүйн байдлыг хамгаалах заалтыг орхигдуулахгүй байх нь зүйтэй байна.

2018 оны байдлаар хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 167 хоригдол суллагдсан, тэдгээрийн 29 нь төлбөртэй байсан бөгөөд 45.9% буюу 14.2 сая төгрөгийн хохирлыг барагдуулж, 54.1% буюу 16.7 сая төгрөгийн хохирлыг барагдуулаагүй байна.

Гэмт хэргийн хохирогч хүүхдэд хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, хохирлыг барагдуулах болон мөрдөгч, прокурор, шүүгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх асуудал нь мөрдөгч, шүүн таслах ажиллагааны шатанд хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэхэд түлхүү анхаарах, ялангуяа хөрөнгө битүүмжлэх нуугдмал хөрөнгө илрүүлэх талаар идэвх санаачлагатай ажиллах үүргийг хүлээлгэж байна.³⁵

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс төлбөртэй хоригдлын төлбөрийг барагдуулах тэднийг цалинтай ажлын байраар хангах зорилгоор тодорхой ажил зохион байгуулж ирсэн боловч хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх эрх зүйн үндэс шинэ хууль тогтоомжоор байхгүй болсон нь энэ төрлийн үйл ажиллагаа зогсоход хүргэж байна.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээ

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаар хийгдсэн судалгаанаас үзэхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд гэмтлийн дараах стрессийн хурц шинж тэмдэг, сэтгэл гутрал бэлгийн замбараагүй амьдрал, бэлгийн зан үйлийн эмгэг, амиа егүүтгэх хандлага зарим тохиолдолд солиорох зэрэг сэтгэцийн гэмтлүүд илэрдэг байна.

Зарим гэмт этгээдүүд бэлгийн хүчирхийлэл үйлдэхдээ хүүхэд өсвөр үеийнхний сэтгэл зүйн болон хувийн өвөрмөц онцлогийг овжноор ашигладаг байна. Жишээ нь ОХУ-д бэлгийн хүчирхийлэлд өртсөн 7-18 насны 98 охидын талаар хийсэн нэгэн судалгаа үүнийг нотолж байгаа юм. Эдгээр охид хүчин бэлгийн албадан харьцаа насанд хүрээгүй хүүхдийг садар самуунд уруу татсан, хүүхэд өсвөр үеийнхний биеийг албадан үнэлүүлсэн гэх зэрэг төрөл бүрийн бэлгийн хүчирхийллийн хохирогчид байжээ. Судалгаанд хамрагдсан 98 охидоос 28 нь бэлгийн хүчирхийлэлд өртөхөөсөө өмнө сэтгэцийн хувьд эрүүл байсан бөгөөд хүчирхийллийн дараа сэтгэцийн хямрал цочролд удаан хугацааны туршид оржээ. Үлдсэн 70 охин бэлгийн хүчирхийлэлд өртөхөөсөө өмнө сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлттэй байжээ. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд өсвөр үеийнхний талаар хийсэн энэхүү судалгаан дээрээ үндэслэн Н.Б.Морозова “Нас хүйс сэтгэцийн хөгжлийнхөө онцлогоос үл хамааран ямар ч хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөж түүний золиос болж болзошгүй гэдэг нь харагдаж байна гэх зэргээр дүгнэжээ.”³⁶

Монгол улсын судалгаанаас харахад 2015-2017³⁷ онд хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогч буюу 0-18 насны 113 хүүхдэд шүүхийн сэтгэц эмгэг судлалын дүгнэлт гаргасан бөгөөд үүнээс 38 нь сэтгэцийн эмгэгтэй гэсэн дүгнэлт гарсан байна. Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогчийн 44.6 % нь оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой (34.2% нь оюуны хөнгөн хомсдолтой, 5.2% нь оюуны хүндэвтэр хомсдолтой, 5.2% нь төрх үйлийн эмгэгтэй байгаа), 55.4% нь сэтгэцийн хувьд гэмтлийн дараах дасан зохицохуйн хямралтай гэж оношлогдсон нь гэмт хэргийн хохирогч болсны улмаас сэтгэцийн эмгэгтэй болсон гэсэн үг юм.

³⁴ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд. НҮБ. 1955. 71 дүгээр зүйл

³⁵ Ю.Батханд “Хүүхдийн эсрэг гэмт явдал” Улаанбаатар 2014 он 105-р тал

³⁶ О.Мягмар “Сэтгэц заслын зөвлөгөөний онол арга зүй” УБ 2010 он 172-р тал

³⁷ Хууль сахиулахын их сургуулийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс” судалгааны ажлын тайлан УБ, 2018 он. 21-р тал

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч бие, сэтгэлээрээ давхар хохирдог тул материаллаг болон материаллаг бус хохирлыг тооцдог эрх зүйн механизмыг бий болгох, хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс хохирлыг нөхөн барагдуулдаг байх эрх зүйн орчныг бий болгох нь зүйтэй.

Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогчийн 44.6% нь бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болохоосоо өмнө сэтгэцийн эмгэг /оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдол, төрх үйлийн эмгэг/-тэй байсан байна.

Дээрхээс харахад оюуны хомсдолтой гэж оношлогдсон хүүхдүүдийн хууль ёсны төлөөлөгчийн анхаарал халамж, хараа хяналт сул байгаагаас үүдэн өсвөр насны охидын эрх ашиг давхар хохирч байна. Мөн сэтгэцийн эмгэгтэй хүүхдүүд олноор хохирсон байхад асран хамгаалах, харгалзан дэмжигчдийн нэг нь ч хариуцлага хүлээгээгүй байгаа нь харамсалтай.

Иймд сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хууль ёсны төлөөлөгчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хуулийн заалтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байна. Мөн гэмтлийн дараах дасан зохицохуйн хямралтай гэж оношлогдсон хүүхдүүдийн хувьд сэтгэл заслын эмчилгээ зайлшгүй хийх шаардлагатай ч уг эмчилгээ өндөр өртөгтэй байдаг ба зардлыг буруутай этгээдээс гаргуулж байх шаардлагатай байна.

Сонгинохайрхан дүүрэгт гарсан насанд хүрээгүй этгээдийг хүчиндсэн гэмт хэргийн хэрэгсэхгүй болгосон хэргийн судалгаа

Доорх хэргийн материалаас үзэхэд, уг гэмт хэргийн талаарх мэдээллийг зарим асран хамгаалагч, харгалзан дэмжигч өгдөг ч зарим тохиолдолд хохирогч, түүний ар гэрийнхэн нэр хүндээ бодох, эсвэл сургууль завсардах, хасагдах болзошгүй үр дагаврыг тооцох байдлаар хуулийн байгууллагад ханддаггүй, мөн хохирогчийг буруутгах нийтийн хандлага, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогчийн талаарх нууцлалыг хангаж чадахгүйтэй холбоотойгоор хуулийн байгууллагад хандах хүсэлгүй, өөр хоорондоо зохицох байдлаар хүүхдийн эрх ашгийг хохироож байна.

Хүснэгт: 1 Хэрэгсэхгүй болгосон хэргийн судалгаа Гэмт хэргийн хор уршгийн зарим судалгаанаас

Эрүүгийн хэрэг үүсгэх, хэрэгсэхгүй болгох тогтоол /он, сар/	Хэргийн товч утга	Хэргийн шийдвэрлэлтийн талаар	Зүйл анги
Эрүүгийн хуулийн 126.2.4-т зааснаар 2016 оны 06 сарын 17 ны өдөр эрүүгийн хэрэг үүсгэсэн. 2016 оны 08 сарын 22 Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 208 дугаар зүйлийн 208.1.1, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2	Хохирогч О-ын найз хөвгүүний найз А нь, түүний найз хөвгүүнтэй уулзахаар хохирогчийг ганцаараа гэртээ байхад нь орж ирэн түүнийг гэртээ ганцаараа байгааг нь мэдээд хохирогч О-д хүч хэрэглэн хажуу өрөөрүү нь чирч оруулан хаалга түгжсэн. Хохирогч О эсэргүүцэл үзүүлэн хаалганы түгжээг тайлах гэж оролдсон тул түүнийг хараалын үгээр хэлж хоолойг нь боож ухаан алдуулан хүчиндсэн.	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, 208 дугаар зүйлийн 208.1.1 эргэлзээтэй, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-р гэм буруугийд тооцож хэргийг хэрэгсэхгүй болгосон.	126.2.4
Эрүүгийн хуулийн 126.2.4-т зааснаар 2016 оны 09 дүгээр сарын 30-нд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 207-дугаар зүйлийг үндэслэн сэргээсэн. 2016 оны 12 сарын 21-нд хэрэгсэхгүй болгосон.	Намайг гэрийн хаалгаа түгжих гээд зогсож байтал нагац ах С ах нь түгжих өгье гэж хэлээд намайг гэрийн амбаар дотор зогсож байхад араас тэврэн өмд, дотуур хувцасыг шувталсан бэлэг эрхтэнээ миний бэлэг эрхтэн рүү хийн хөдөлсөн өвдөөд байна гэхэд зүгээрээ ахын дүү тэгэж байгаад өвдөхгүй болно гэж хэлсэн түүний бэлэг эрхтэнээс цагаан өнгийн шингэн гарсан Аав, Ээж гэрийхэндээ айгаад хэлээгүй.	2010 оны 05 сарын 03-нд яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон. Хүчиндсэн болох нь тогтоогдоогүй.	126.2.4
17 настай М утсаар танилцсан 20 орчим настай эрэгтэй машинаар далимдуулан явж хүч хэрэглэн хүчиндсэн гэсэн гомдлоор 2016 оны 05 дугаар сарын 06-нд эрүүгийн хэрэг үүсгэсэн. 2016 оны 08 сарын 22-нд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 заанаар хэрэгсэхгүй болгосон.	Хохирогч А, Д өөрийгөө Монхоон гэж утсаар танилцсан тэгээд бид хоёр хэсэг мессежээр харьцсаны дараа уулзахаар болсон. Д машинтай ирсэн бид хоёр машинд уулзсан Д надаас өөртэйгөө унтахыг хүссэн би зөвшөөрөөгүй болохоор тэр хүч хэрэглэн хүчиндсэн.	Хохирогчийн мэдүүлэг, Фесбүүк-т үзлэг хийсэн тэмдэглэл, фото зураг, Гэрч Л,Г-ийн мэдүүлэг бичгийн бусад нотлох баримтаар гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй буюу гэмт хэрэг үйлдээгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон.	126.2.4

Хохирогчдын хувьд 14 насны 2, 15 насны 3, 16 насны 1 хохирогч гэмт хэргийн улмаас жирэмслэн, үр хөндүүлсэн байх ба жирэмсэлсэн болон сэтгэл зүйн хямралд орсон тохиолдолд нөхөн төлбөр нэхэмжлэл гаргаж байжээ. Судалгаанд хамрагдсан хэргээс 3 хохирогч нөхөн төлбөр авчээ. 201425005206 дугаартай хэрэгт 8.000.000₮; 201525011364 дугаартай хэрэгт 1.055.000₮ нэхэмжилснээс 350.000₮; 201525040399 дугаартай хэрэгт 15.000.000₮ тус тус авсан байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан бусаар хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, яллагдагч хоорондоо тохиролцон, бие биедээ мөнгө өгч авалцаж дараа нь тэр тухайгаа мөрдөгчид тэмдэглүүлэх, мөнгө шилжүүлсэн баримтыг хэрэгт хавсаргуулах, гомдолгүй хэмээн мэдүүлэх байдал эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон хэргүүдээс харагдаж байна.

Дүгнэлт

2015-2017 онд шүүхээр 786 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Мөн Цагдаагийн ерөнхий газрын гаргасан тоон мэдээллээс харахад 2015-2018 оны хооронд хүчингийн гэмт хэрэг 1417 гэмт хэрэг бүртгэгдсэн ба үүнээс 1382 хохирогчоос 617 нь насанд хүрээгүй хүн хохирчээ. 2017 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчингийн гэмт хэргийн тоо 30 хувиар нэмэгдсэн.

Гэмт хэргийн улмаас 40 хүүхэд хохирсоны 0-13 насны – 6; 14-15 насны – 19; 16-18 насны – 15 насны, тэдгээрийн 35 нь ерөнхий боловсролын сургуулийн сурагч. 2015 онд 216 хохирогч хүүхэд шинжилгээ хийлгэснээс 14 насны 2, 15 насны 3, 16 насны 1 хохирогч гэмт хэргийн улмаас жирэмслэн, үр хөндүүлсэн, 0-18 насны 113 хохирогчид шүүхийн сэтгэц эмгэг судлалын дүгнэлт гаргуулсан байх бөгөөд 38 хохирогч буюу 33.6 % сэтгэцийн эмгэгтэй 55.4 % нь сэтгэцийн гэмтлийн дараах дасан зохицохуйн хямрал буюу гэмт хэргийн хохирогч болсны улмаас сэтгэцийн эмгэгтэй болсон.

Хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгүүлэн хорих ял эдэлж буй 530 хоригдол байгаа нь нийт ял эдлэгсдийн 15 орчим хувийг эзэлж байна. Тэдгээрээс 0-14 хүртэл буюу бага насны хүүхэд хүчиндсэн 387, 15-18 насны хүүхэд хүчиндсэн 63, 18-аас дээш насны хүн хүчиндсэн 80 хоригдол ял эдэлж байна. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын 19.4% буюу 103 нь хохирол барагдуулах төлбөрийн өртэй байна. 2018 оны байдлаар хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 167 хоригдол суллагдсан, тэдгээрийн 29 нь төлбөртэй байсан бөгөөд 45.9% буюу 14.2 сая төгрөгийн хохирлыг барагдуулж, 54.1% буюу 16.7 сая төгрөгийн хохирлыг барагдуулаагүй байна. 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4-т заасан “хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх” тухай заалт 2017 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас хасагдсан нь хоригдлыг хөдөлмөр эрхлүүлж төлбөр барагдуулах ажил зогссон.

Хүчиндэх гэмт хэргийн хохирогч бие, сэтгэлээ давхар хохирдог тул материаллаг болон материаллаг бус хохирлыг тооцдог эрх зүйн механизмыг бий болгох, хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс хохирлыг нөхөн барагдуулдаг байх эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай.

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч үүргээ биелүүлж чадаж байгаа эсэх эсхүл төлөөлөх боломжгүй нөхцлийн талаар судлах. Эрсдэлтэй, эргэлзээ бүхий үндэслэл буюу хохирогч сэтгэлзүйн хувьд тогтворгүй, мэдүүлэг өгөх чадваргүй, айдастай байгаа эсэхэд дүгнэлт хийх.

Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хууль ёсны төлөөлөгчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хуулийн заалтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан бусаар хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, яллагдагч хоорондоо тохиролцон, бие биедээ мөнгө өгч авалцаж дараа нь тэр тухайгаа мөрдөгчид тэмдэглүүлэх, мөнгө шилжүүлсэн баримтыг хэрэгт хавсаргуулах, гомдолгүй хэмээн мэдүүлэх тохиолдол гарч байгаа нь хохирогчийг давхар хохироож байна.

Санал

1. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдын өмгөөлөгчийг мэргэшүүлэх;

2. Цагдаагийн байгууллагын салбарт сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлэх, мөн хүчиндэх гэмт хэрэг тэр дундаа хүүхдийн асуудал хариуцсан нэгжийг бэхжүүлэх. Хүүхдийн байцаагч нарын орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

3. Гэр бүлийн гишүүдээс дээрх гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд хууль ёсны төлөөлөгчөөр хүүхэд хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах нь илүү үр дүнтэй;

4. Өсвөр насны хүүхдэд гэмт халдлагаас өөрийгөө хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлэх, өөрийн биеийн нандин, нууц хэсгүүдэд бусдыг зөвшөөрөлгүй хүрэхийг хориглож сурахыг тайлбарлах зэрэг агуулгатай сургалт семинарыг зохион байгуулж мэдээлэл хүргэх нь нэн чухал юм;

5. Тухайн засаг захиргааны нэгжид үүрэг гүйцэтгэдэг албан тушаалтаны үүрэг, оролцоо, хариуцлагыг дээшлүүлэх. Тухайн баг, хороонд хойд эцэгтэйгээ амьдардаг эсхүл эцэг эх нь архинаас хамааралтай болсон гэр бүлийн судалгааг өрх тус бүрээр гаргаж эрсдэлтэй гэр бүлийн судалгааг гаргаж хэвших;

6. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн талаар статистик мэдээллийн нэгдмэл байдлыг боловронгуй болгох;

7. Төлбөрийн асуудлаарх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох;

8. Төрийн болон төрийн бус байгууллагууд хүүхдүүдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх бие бялдар, оюун санаагаа хөгжүүлэх үйлчилгээний газруудыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Жишээ нь: тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, спортын секц, дугуйлан, номын сан гэх мэт.

9. Цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх сөрөг мэдээлэлд тавих хяналтыг боловсронгуй болгох. Цагдаагийн байгууллагад мэргэшсэн болон энэ талаар хариуцсан нэгжийг бий болгох.

Эх сурвалжийн жагсаалт

Олон улсын гэрээ, конвенц

1. НҮБ-ийн Хүүхдийн эрхийн конвенц

Хууль тогтоомж

1. Монгол улсын эрүүгийн хууль /2015.12.03/
2. Монгол улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017.05.18/
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Ном, сурах бичиг, гарын авлага

1. Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктимологи” Улаанбаатар, 2005 он
2. С.Гантулга, Б.Энхболд. “Эрүүгийн эрх зүй: тусгай анги” Улаанбаатар, 2018 он
3. Ю.Бадамханд “ Хүүхдийн эсрэг гэмт явдал” Улаанбаатар, 2014 он
4. О.Мягмар “ Сэтгэц заслын зөвлөгөөний онол арга зүй” УБ 2010 он
5. “Бэлгийн хүчирхийлэл гарын авлага” Улаанбаатар, 2019 он
6. “Хүчирхийллээс ангид байх эрх гарын авлага” Улаанбаатар, 2018 он
7. UN Women /May 2013 /. Factsheet- Global, Progress of the Word’s Women 2011-12 /PDF/

Судалгааны ажил

1. Хууль сахиулахын их сургуулийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс” судалгааны ажлын тайлан УБ, 2018 он.
2. Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд. НҮБ. 1955.
3. ЭМЯ, ГС, ХТЭТ, “ Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх” судалгааны тайлан. УБ, 2018 он
4. “Гүнж төв” төрийн бус байгууллагын ярилцлага

**АЛБАН ХААГЧИЙН СТРЕСС - ТОГТВОРТОЙ АЖИЛЛАГААНЫ
ТАЛААР ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ**
/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн жишээн дээр/

О.Баяржаргал

*Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, ахмад*

Түлхүүр үг: Ажлын байрны стресс, сэтгэлийн ядаргаа, тогтвортой ажиллагаа

Үндсэн хэсэг

Ямар ч ажил мэргэжлийн хувьд тогтвортой ажиллана гэдэг нь ажиллах хүчний талаарх судалгаанууд дээр үндэслэсэн ойлголт байдаг. Гэхдээ ажиллах хүчний судалгаа дундаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны тогтвортой ажиллах асуудлыг нийгэм сэтгэл зүйн олон хүчин зүйлтэй холбон тайлбарласан байдаг.

Тухайлбал нийгмийн ажилтнуудын ажлын байрны стресс нь тэдний тогтвортой ажиллагаанд нөлөөлдөг хүчин зүйлийн нэг юм.

Хорих байгууллагын салбарын нийгмийн ажилтнуудын хувьд тэдний ажлын байран дээрх онцлог нь бусад төрлийн ажил мэргэжилтнүүдээс илүү их стрессд ордог байна. Хүмүүс цаг үргэлж хувийн амьдрал дээр ч, ажил дээр ч, удирдлагуудын асуудал дээр ч тэд заримдаа жижигхэн зүйлийг хүртэл маш их хямарч, хэтэрхий хүндээр тусгаж авах ч үе байдаг.

Хорих байгууллагын нийгмийн ажилтнуудын, удирдлагууд өөрсдийнхөө амрах, чөлөөт цаг, бусад стрессээ намжаах цаг заваа ч умартан ажиллах нь бий.

Стрессд орно гэдэг нь хүмүүс хэтэрхий их хямарч бүх зүйлд сөргөөр ханддаг болохыг хэлнэ. Хэт их хямрах нь тэдний гэр бүл, ажил дээрх бусадтай харилцах харилцаанд муугаар нөлөөлдөг. Гэсэн ч бүх стресс муу зүйл биш. Стрессд орно гэдэг нь ямар нэгэн зүйлд онцгой ач холбогдол, дарамт, ачаалал өгөхийг хэлнэ. Үүнийгээ өөрөө удирдаж чадвал эерэгээр шийдэх боломжтой. Гэвч эдгээр нь амархан хийчихдэг зүйл биш байдаг.

Алба хаагчдын стресс ажлын гүйцэтгэлд нөлөөлөх нь:

Хүснэгт 1.

Шийдвэр гаргахад хэцүү болгодог	Эсрэг бодлыг нэмэгдүүлдэг	Анхаарлыг бууруулдаг
Төвлөрөхөд саад болно	Ажлын үр дүнтэй харшилдаг	Шийдвэр гаргах чанарт нөлөөлнө
Нарийн хяналт тавих чадвар мууддаг	Ажлын дуршлыг бууруулдаг	Өөртөө итгэх итгэлийг эвддэг
Шаардлагыг заналхийлэх мэт хүлээж авдаг	Ажилдаа сэтгэл ханамжгүй байдаг	Бусадтай эерэг харилцах чадварыг бууруулдаг

Бие сэтгэлийн тэнхээ барагдах нь удаан хугацааны сэтгэл санааны, сэтгэл зүйн болон бие махбодийн дарамтанд байсны үр дүн. Зарим нэг судалгаануудад үүнийг "сэтгэлийн ядаргаа" гэж тодорхойлсон байдаг бөгөөд удаан хугацааны турш бусдад туслах үүрэгтэй ажил мэргэжлийн хүмүүс ихэвчлэн өртдөг байна.

Сэтгэлийн тэнхээ барагдах нь маш их хичээл зүтгэл гаргасан хүмүүс сонирхолоо алдаж идэвхигүй болох тохиолдлыг хэлдэг. Ихэвчлэн хичээл зүтгэлтэй, тэмүүлэлтэй, сэтгэлийн хөдлөл ихтэй хүмүүс оюун санааны болон бие махбодийн стрессд орох нь элбэг байдаг. Тухайлбал дараах ажилтнууд нь бие, сэтгэлийн тэнхээ барагдах ба сэтгэлийн ядаргаанд орох магадлал өндөр байдаг байна.

- Урт хугацааны турш их хэмжээний дарамт өөр дээрээ хуримтлуулдаг
- Хэтэрхий урт хугацаанд хэт их зорилго тавих
- Ажлын хяналт хангалтгүй байх
- Бага зүйл хийж бүтээж байгаа гэж буруугаар бодох
- Сөрөг бодол нь давуу болох
- Хүч чадал болон зорилгоо алдах

- Бусадтай харилцах харилцаанаас хөндийрөх

Ажилтнуудынхаа бие, сэтгэлийн тэнхээг барагдахаас болон сэтгэлийн ядаргаанд орохоос сэргийлэх нь ажилтнуудаа авч үлдэх зорилготой удирдагч хүний анхааралдаа авах ёстой нэг чухал зүйл юм. Удирдагч хүн хамгийн сайн ажилтандаа хэтэрхий их ярвигтай ажил тасралтгүй даалгахаас зайлсхийх хэрэгтэй. Тэдний оюун санааны хүчний хязгаарыг хүндэтгэж, хүчээ нөхөж, сэлбэж ажиллахад нь туслах хэрэгтэй. Зарим сэтгэл зүйчид алба хаагчдыг ажлаасаа гарахад нь стрессийн түвшин хир байсныг авч үздэг. Тэд ажил мэргэжлийн стресс болон ажлаас хамааралгүй бусад стрессийн нөлөөг ч авч үздэг. Мөн түүнчлэн хувь хүний сайн сайхан байдал, ажилдаа сэтгэл ханамжтай байх болон ажлаасаа болж бага стрессдэх нөхцөл, шалтгаан болдог байна.

Биеийн болон сэтгэлийн тэнхээ барагдах нь бас нэг ажлаасаа гарах шалтгаан болдог байна. Жишээ нь: Маслакийн загварт /1984/ харуулснаар сэтгэл зүйн ядаргаа, өөрийгөө удирдаж чадахаа болих, өөрийнх нь амжилтын талаарх санаа бодол зэрэг нь ажлаасаа гарч байгаа ажилтнуудын стрессд нөлөөлсөн байдаг байна.

Дрек, Ядама /1996/ нар биеийн ядаргаа ажлаасаа гарахад шууд нөлөөлдөг гэдгийг нотолжээ. Өөрийгөө удирдаж чадахаа больсон нь ажилдаа үлдэх эсэхэд хамааралгүй. Онолын хувьд дараах 3 зүйл нь хүнийг ажилд нь бэхэлж өгдөг байна.

1. Байгууллага доторх бусад хүмүүстэй харилцах харилцаа
2. Ажил мэргэжил, байгууллага, олон нийтийн дунд багтаж буй эерэг мэдрэмжүүд
3. Ажлаасаа гарвал гарч болох гарз хохиролын талаарх үнэлгээ

Урьдчилсан судалгаагаар дээрх ажилтайгаа холбогдох холбоо дутагдсанаар ажлаасаа холдох урьдчилсан шалтгаан болдог бөгөөд ажлаасаа гарах нь ажлын сэтгэл ханамж, хичээл зүтгэл зэрэг бусад шалтгаантай холбоотой байдаг.

Стрессийн ангилал:

1. Амьдралын явцад үүссэн стресс
2. Орчны болон ажлын байрны стресс
3. Сэтгэл санааны стресс
4. Хэт их ажлын ачаалал болон ядарснаас үүссэн стресс

Хорих байгууллагын нийгмийн ажилтнууд ажлын байрнаасаа маш их сэтгэлийн дарамтыг шууд болон дам байдлаар авдаг байна.

Хүснэгт 2.

Алба хаагчдын хүсэл	Байгууллагын хүсэл	Удирдлагын хүсэл
Өөрт нь тусалж дэмжихийг мэдрэх	Тогтвортой боловсон хүчин, ажлын байр нэмэгдүүлэх	Шинэ ажилтныг ажилд авах, сургахад цаг хугацаа харьцангуй бага зарцуулах
Стрессдэхээ багасгаж, бие болон сэтгэл санааны тэнхээгүй байдалд орохгүй байх	Үйлчилгээнийхээ үр ашгийг нэмэгдүүлэх	Туршлага хуримтлуулах болон өөрийгөө нээх
Хүүхэд болон гэр бүлтэйгээ ойлголцох шинэ арга зам нээх	Байгууллагын нийт бүтээмжийг сайжруулах	Өдөр өдрөөр бага асуудалтай тулгарах
Өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэх	Байгууллагын өргөн харилцаа холбоог бий болгох	Удирдах чадвараа нэмэгдүүлэх
Байгууллагынхаа зорилгыг, үнэ цэнийг мэдрэх	Байгууллагын үнэнч байдлыг төлөвшүүлэх	Өөрийгөө хүндлэх нь нэмэгдэх
Ажлын болон хувийн зорилгоо гүйцэлдүүлэх	Олон нийтэд байгууллагынхаа талаар эерэг ойлголтыг төрүүлэх	Үүрэг, чадвараа шинэ түвшинд мэдрэх
	Байгууллагадаа тогтвортой ажиллах уламжлал тогтоох	Алба хаагчдыг хувь хүнийх нь, мэргэжлийн хувьд ч өсөж дэвшиж байгааг харна
	Хорих байгууллагат тогтвортой ажиллах хүчнийг	Удирдлагын хувьд өөртөө итгэх итгэлийн нэмэгдүүлэх

Алба хаагчдынхаа сэтгэл санааны байдалд санаа зовдог удирдлагын хувьд тэдэнд хэт их хямрал нь эргээд биеийн болон сэтгэл санааны ядаргаа болох магадлалтайг ойлгож тийм зүйл гаргахгүй байх тал дээр анхааруулах нь зүйтэй.

Хэт их стрессд орох нь тухайн хүний бусадтай харилцах харилцаанд нөлөөлж эхэлдэг. Энэ нь эргээд эрүүл ухаанаар сэтгэж ямарваа асуудлыг зөв зохистой шийдвэрлэх чадваргүй болгодог.

Удирдах ажилтнууд стрессээ хэрхэн зохицуулж сурахыг зааж сургаж байх нь маш чухал гэдгийг ойлгож урьдчилан сэргийлж байх хэрэгтэй.

Хорих байгууллагын стрессийн удирдлагын арга зүйг боловсронгуй болгох нь: Алба хаагчдаа өгөх нэмэлт үүрэг даалгаврыг хийх чадалгүй болсон ч татгалзаж чадалгүй хийхээр зүтгэх байх гэдгийг урьдчилан мэднэ гэдэг бол сайн удирдлагын нэг шинж чанар. Бас ажилтнаа нэг төсөл дээр хэтэрхий их ачаалж ажиллахаас хамгаалах зэрэг ч сайн удирдлагын шинж чанар.

Албан хаагчийг сэтгэлийн дарамтанд орохоос сэргийлэх аргууд:

- Зорилгыг нь дахин тодорхойлж дэс дараалалд оруулж өгөх
- Тэдэнд тавигдах шаардлагуудыг үнэлээд, тэдгээр шаардлагуудыг биелүүлж чадах эсэхийг нь бодолцож, хэрхэн зорилготойгоо нийцүүлэх тал дээр нь туслах
- Хэрэггүй үүрэг хариуцлагуудыг нь багасгах
- Тэндээс хэтэрхий их сэтгэл санааны хүч шаардаад байгаа хүмүүстэй арай хөнгөн хандаж, харьцаж сурахыг заах
- Хэтэрхий их сэтгэл санааны хүч шаардаад байгаа ажилд нь тус болж дэмжих хүмүүсийг оролцуулах
- Стрессээ даван туулах аргуудад суралцаж, стресс багасгадаг зүйлсийг хийх
- Өөрийнх нь амьдралд өөр стресс үүсгэж байгаа эх үүсвэрүүдийг мэдэж авах
- Гэр бүл найз нөхөдийн дэмжлэгийг авах
- Тэд амрах болон тайвшрах эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх

Тогтвортой ажиллагааг хангагч удирдагчийн шинж

Зүрх сэтгэлийн зам – Тогтвортой ажиллахыг зорилгоо болгодог удирдлага байх нь хэцүү ч ажилд гайхалтай сэтгэл ханамж авдаг. Энэ нь ажлын утга учрыг бий болгож, зүрх сэтгэлийн замыг нээж өгдөг.

Төлөв даруу байх – Байгууллагын зорилго, алба хаагчдынхаа хувийн болон мэргэжлийн өсөлт дэвшилтийг өөрийнхөө байр суурь, эрх мэдлийг гартаа авч байх хүслээсээ дээгүүр тавих

Урамшуулах – Албан хаагчдаа өөртөө итгэлтэй болгож, тэднийг ойлгодог гэдгээ харуулж, сэтгэгдлийг нь сонсож, хийсэн ажлыг нь үнэхээр сайн болсон гэдгийг хэлж байх.

Хүлээн зөвшөөрөх – Ажилтан бүрийн өөр өөр зан, авьяас, өвөрмөц шинж чанарыг нь хүлээн зөвшөөрч, хувь хүний хэрэгцээ, шаардлага, хүч чадалд нь тохируулж удирдах

Хүндлэл – Ажилтан удирдлагын хооронд тодорхой хязгаар тогтоож, харилцан ойлголцол, харилцан хүндлэлийг хадгалах

Итгэл – Өөрийгөө нээж суралцах таатай, ажлын аюулгүй орчинг бий болгох

Дүгнэлт

Хорих байгууллагын алба хаагчдын ажлын байрны стрессийг шийдэж чадахгүй бол энэ нь явсаар бие сэтгэлийн тэнхээг барж, сэтгэлийн ядаргаанд оруулдаг ба ийм байдалд хүрсэн ажилтан нь ихэнхдээ ажлаасаа гардаг байна. Хорих байгууллагын удирдлага ажилтнуудынхаа ажлаас гадуурх дарамтыг зохицуулж чадахгүй ч ажлын байран дээрх стрессийн түвшинг багасгах боломжтой байдаг. Энэ нь ажилтнуудын стресс нь байгууллагын үйл ажиллагаа, түүний орчинд гарч байгаа учраас удирдлага болон ажлын гүйцэтгэлтэй холбоотой юм. Тус илтгэл нь онолын судалгаанд суурилсан бөгөөд ажлын байрны стресс, сэтгэл ханамж болон удирдлагын арга барил зэрэг нийгмийн ажлын менежмент хүний нөөцийн бүрдлийг авч үзсэнээрээ сонсогч болон судлаачдад мэдээлэл өгөх ач холбогдолтой болно.

Эх сурвалжийн жагсаалт

1. Нийгмийн ажлын багш сургагчдын холбоо. (2003). Нийгмийн ажлын удирдлага, Улаанбаатар
2. Acter.G.M (1999). The impact of clients mental illness on social workers job satisfaction and burnout. Health and Social work, 24 (2)
3. Gary Anderson, Ph.D, Staff Retention in child and Family Service The Practice of Retention Focused Supervision, Workbook 2, at 2007

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Ч.Нямсүрэн

*Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Цагдаа судлалын төвийн эрхлэгч, доктор, дэд профессор*

Хүмүүн биеийг олж эх дэлхийдээ өлгийдүүлэхдээ авч мэндэлдэг жам ёсны нэг эрх бол өмчлөх эрх мөн. “Хомо сапиенс” буюу ухаант хүмүүн олон зуун мянган жил өмч дээр суурилсан нийгэм эрх зүйн харилцаанд аж төрж, амьдарч ирсэн түүхтэй. Ийм ч учраас хүн төрөлхтний түүх бол өмчийн харилцааны түүх мөн.

Эрх зүйн онолын үүднээс хүний өмчлөх эрхийн хамгаалалтыг олон улсын эрх зүйн хамгаалалт; үндэсний эрх зүйн хамгаалалт гэсэн хоёр түвшинд авч үздэг.

1789 оны Францын Их хувьсгал өмчлөх эрхийн олон улсын эрх зүйн хамгаалалтын эх суурийг тавьж “Хүн ба Иргэний Эрхийн Тунхаглал”-ын Арван долоодугаар зүйлд “Өмч бол хэн ч халдашгүй, ариун эрх мөн”³⁸ хэмээн хүний өмчтэй байх жам ёсны эрхийг анх зарлажээ.

1949 оны Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйлд: “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй. Хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй” гэж заажээ.

XXI зууны гарааны нэг онцлог болсон глобалчлах явц эрчимжиж буй орчин үеийн олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн уялдаа холбоо нь олон улсын эрх зүйн примат (primatus-тэргүүлэх, голлох, давамгайлах гэсэн латин үг) буюу голлох шинжээр тодорхойлогдож байна.³⁹ Энэ байдлыг олон улсын эрх зүйн ноёрхол, үндэсний эрх зүйн дээрхи эрх зүй гэсэн монист утгаар бус харин энэ хоёр тогтолцооны уялдаа холбооны шинжээр нь ойлгох ёстой юм.

Олон улсын хувийн эрх зүй нь олон улсын эрх зүйн этгээдтэй холбоо бүхий иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн, өмчлөх эрх зүйн зэрэг нэг улсын хүрээнээс хальсан харилцааг зохицуулах учраас улс бүрийн онцлогийг илэрхийлсэн үндэсний эрх зүйн тогтолцоонуудын зөрчилдөөнийг шийдвэрлэх, өмчлөгчийн эрхийг олон улсын болон бүс нутаг, гадаад улсад хамгаалах асуудлыг шийднэ.

Өмчлөх эрхийн үндэсний эрх зүйн хамгаалалт нь өөрийн нутаг дэвсгэр дотор дотоодын хууль тогтоомжоор өмчлөгчийн эрхийг хангахад чиглэнэ.

Монгол Улсад өмчлөгчийн эрхийг хамгаалах тогтолцоо Үндсэн хуулийн эрх зүйн хамгаалалт; иргэний эрх зүйн хамгаалалт; захиргааны эрх зүйн хамгаалалт; эрүүгийн эрх зүйн хамгаалалт зэргээс бүрдэж байна.

Монгол Улсын өмчлөх эрхийн эрүүгийн эрх зүйн хамгаалалтын онолын үндэс нь Монгол Улсын үндсэн хууль түүний дотор Үндсэн хуулийн оршил хэсэгт байгааг анхаарах хэрэгтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт: Хүний эрх, эрх чөлөө.. эрхэмлэн дээдэлж, эх орондоо.. иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж тунхагласан.

Иргэний нийгмийн тухай төсөөллийг Г.Гегель “Эрх зүйн гүн ухаан” бүтээлдээ “Иргэний нийгэм бол тухайн бие хүний хувийн онцгой зорилго, ашиг сонирхол хэрэгжих хүрээ мөн. Хүн бүр өөртөө зорилготой, бусад хүмүүс түүний хувьд энэ зорилгодоо хүрэх арга хэрэгсэл болдог учраас иргэний нийгэм нь “онцгой” ба “нийтлэг” гэсэн хоёр үндсэн зарчмын харилцаагаар тодорхойлогдоно. Тухайн бие хүний “онцгой зорилго” хэрэгжих

³⁸ Хрестоматия по истории государства и права зарубежных стран. М., 2000. С 41

хэрэгцээ бусдынхаар хязгаарлагдаж байдаг учраас уг зорилгоо биелүүлэхийн тулд хүн бүр “нийтлэг зорилгын” төлөө тэмүүлдэг. Учир нь онцгой зорилгоо биелүүлэхдээ аргагүйн эрхэнд бусдын төлөө зүтгэх шаардлага гарна” гэжээ⁴⁰.

И.Кант: а) хүн бүр өөрийн хүчээр бүхнийг бүтээх ёстой бөгөөд бүтээсэн зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстой; б) хүмүүсийн ашиг сонирхол зөрчилдөх, түүнийг хамгаалах шаардлага нь хүмүүсийг хөгжүүлэх үндсэн шалтгаан мөн; в) эрх зүйгээр хуульчлан хамгаалагдсан иргэдийн эрх, эрх чөлөө бол хүний нэр төрийг дээдлэх, хамгаалах баталгаа, өөрийгөө хөгжүүлэх зайлшгүй нөхцөл мөн⁴¹ гэжээ. Энэ үзэл санаа нь иргэний нийгмийн тухай онолын нэг гол үндэслэл болсон юм.

Эдийн засгийн хүрээнд дэх иргэний нийгмийн шинж нь хүн бүр оршин тогтнох, амьдрах үндэс болсон хувийн өмчтэй байх явдлаар илэрнэ. Иргэний нийгэм нь анх хувийн өмч дээр тулгуурлан үүсч хөгжсөн байна. Хувийн өмч нь хүмүүсийг өөр хооронд нь ялгаж салгаад зогсохгүй, түүнчлэн тэдний шунахай, хувиа хичээсэн, бялдууч зусарч болон бусад олиггүй олон тооны зөн билгийг сэргээсэн боловч, нөгөө талаас тэдний бүтээлч идэвх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх сонирхлыг урд үзэгдээгүй хэмжээгээр өрнүүлдэг. Үүнээс үзэхэд хувийн өмч нь иргэний нийгмийн гол цөмийг бүрдүүлж, төрийн засаглалаас хараат бус боломжийг олгоно. Иргэний нийгмийн гүнд бүрэлдэж байгаа эрх зүйт төрийн нэг урьдчилсан нөхцөл бол бие даасан үйлдвэрлэгч, хэнээс ч хараат бус хэрэглэгч, эрх чөлөөт иргэн байдаг⁴². Францын гүн ухаантан Жан Жак Руссо “өөрийн хэсэг газартаа хашаа хатгаж энэ минийх гэж хэлсэн тэр хүн л иргэний нийгмийн жинхэнэ үндэслэгч” гэжээ. Одоо бидний нэрлэж заншсан “засгийн ордон тойрон гороолж байгаа” ашиг сонирхлын нэгдлүүд иргэний нийгмийн төлөөлөл яв чиг биш. Харин хөдөөний хот айл л иргэний нийгмийн анхдагч нэгж гэж харагдаад байгаа..

Иргэний нийгмийг орчин үеийн хөгжлийн хандлагаар нь тодорхойлбол, хүний эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн хангаж, тэдний бүтээлч, овсгоот үйл ажиллагааны эрх чөлөөг хангах үндсэн дээр элбэг хангалуун амьдрах боломжийг нь бүрдүүлж, хүмүүнлэг, шударга ёс, эрх зүйн уламжлал, хууль ёсны үзэл санааг дээдлэн хүндэтгэж, төрөөс хараат бус, хувь хүнийг хөгжүүлэхэд чиглэсэн чөлөөт, ардчилсан, эрх зүйт нийгэм мөн. Английн гүн ухаантан Жон Локк тухайн үедээ “засгийн газарт өмчлөх эрхийг хамгаалахаас өөр зорилго үгүй” гэсэн нь иргэний нийгмийн эрүүгийн эрх зүйн хамгаалалтын мөн чанарыг тодорхойлсон хэрэг.

Монгол Улсын Үндсэн хуульд: “Монгол Улс эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална. Өмчлөх эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан нь өмчлөх эрхийг баталгаажуулж эрүүгийн эрх зүйгээр хамгаалах эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг тодорхойлсон.

Өмчлөх эрхийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт нь Үндсэн хуулиар баталгаажуулсан өмч, өмчлөх эрхийг бүхэлд нь хамгаалах, тодруулбал өмч дээр суурилсан иргэний нийгмийг хамгаална гэсэн ойлголт мөн.

Хуулийн зорилго нь тухайн хуулиар зохицуулах, бэхжүүлэх, хамгаалах харилцааг тодорхойлдог журамтай.

Эрүүгийн эрх зүйгээр хамгаалах харилцааг Монгол Улсын Эрүүгийн 2015 оны хуулийн 1 дүгээр зүйлд: “Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино” гэжээ. Түүнээс гадна энэ хуулийн 17 дугаар бүлэгт тусгайлан хамгаалах харилцааг нарийвчлан тодорхойлсон.

Одоо Эрүүгийн 2002 оны хуулийн зорилттой харьцуулалт хийж үзье.

⁴⁰ Г.Гегель. Философия права. М., 1990. С 227-228.

⁴¹ И.Кант. Сочинения. Т 1. Трактаты и статьи. М., 1994. С 285.

⁴² Үзнэ үү.: Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал. Уб., 2017

2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль	Харьцуулалт
<p>“Монгол Улсын Эрүүгийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино”</p>	<p>“Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино”</p>	<p>Эерэг тал: -2015 оны хуульд “эрүүгийн эрх зүйн хамгаалалтын хүрээнд “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зорилгыг тодорхойлсон нь төрийн эрүүгийн бодлогын нэг гол чиг хандлагыг бэхжүүлсэн нь маш оновчтой болсон (+). Сөрөг тал: -Нийтийн ба хувийн өмчийг гэмт халдлагаас хамгаалах зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хүрээнд далдалсан (+ -); -“үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам”, гэмт халдлагаас хамгаалах зорилгыг орхигдуулсан, эсхүл нийтийн болон үндэсний ашиг сонирхлын хүрээнд багтаасан (-); -Иргэний нийгмийн нэг үндсэн шинж болох хувийн ашиг сонирхол эрүүгийн эрх зүйн хамгаалалтын зорилгын хүрээнд хөндөгдөөгүй (-)</p>

Эрүүгийн хуулийн зорилго нь Үндсэн хуулиар бэхжүүлж, хамгаалж, зохицуулсан хамгийн амин чухал харилцааг хамгаалахад чиглэнэ. Харьцуулалтаас харахад хүний хувийн өмчид тулгуурласан иргэний нийгмийн хамгаалалт орхигдсон нь хууль тогтоогч, түүнийг төслөгчдөөс онолын суурь мэдлэг ямар түвшинд байгааг илэрхийлж байна. Эрүүгийн эрх зүйн зорилгыг тодорхойлох энэ оролдлого нь социологи онолыг социалист чиг баримжаагаар, өөрөөр хэлбэл эрүүгийн эрх зүйн хувийн ашиг сонирхлыг хамгаалахаас нийт нийгмийн ашиг сонирхол, хүн амын дийлэнх олонхын ашиг сонирлыг илүү хамгаалахад чиглэсэн, хувийн өмчийг орхигдуулсан хуучин номлол гэлтэй.

Хэрэв эрүүгийн эрх зүйгээр хамгаалбал зохих нийгмийн амин чухал харилцаа, зорилгыг тодорхойлж чадахгүй бол гадаадын улс орнуудын туршлагаар хууль зүйн өөр техникийг хүлээн авах нь зүйтэй мэт. Жишээ нь Герман улсын эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйл нь ердөө л “хуульгүй бол ялгүй” гэсэн зарчим буюу “хууль тогтоомжоор ял шийтгэхийг урьдчилан тогтоосон бол тухайн үйлдэлд ял шийтгэж болно” гэсэн зарчмаар л эхлэнэ. Гэхдээ эрүүгийн эрх зүйн зорилгогүй гэсэн үг биш, Герман, Францын шүүгчид эрүүгийн эрх зүйн номлол, эрдэмтдийн бүтээл нь сайн хуулиас ч илүү чухал гэдгийг цөөнгүй тэмдэглэдэг.

Эрүүгийн хуулийн зорилгоо эдгээр улс орнууд эрх зүйн номлол, төрийн бодлогоороо тодорхойлдог. Монгол Улсын эрүүгийн нэгдсэн бодлого томъёологдоогүй учраас хууль зүйн арга хэрэгслийг ашиглаж эрүүгийн хуульд хамгаалах харилцааг тодорхойлох гэж оролдоход хүргэж байна.

Эрүүгийн эрх зүйн номлол нь хууль тогтоомж болон хууль хэрэглээний практикт туйлын бага судлагдсан асуудлын нэг мөн. Эрх зүйн номлол гэдэг нь эрдэм шинжилгээ суурь судалгааны үндэслэсэн, албан ёсоор хүлээн зөвшөөрсөн сургааль буюу шинжлэх ухааны үзэл баримтлалыг хэлнэ. Энэ нь аливаа онол хөгжих тулгуур суурь мөн. Чухамдаа төрөөс албан ёсоор хүлээн зөвшөөрсөн номлол, эсхүл төрөөс эрдэмтэн судлаач, практик ажилтнуудын оролцоотойгоор боловсруулсан эрүүгийн бодлого, үзэл баримтлал ус агаар мэт хэрэгтэй байна.

Орчин үеийн эрүүгийн эрх зүйн нэг гол чиг хандлага болох актуар номлол нь эрүүгийн эрх зүйн хориг зөрчсөн үйлдэл эс үйлдэхүй бус, харин нийгмийн аюулгүй байдалд хор уршиг учруулах далд шинж чанарыг илүүтэй тодорхойлоход оршиж байна.⁴³

Судалгаанаас үзэхэд өнөөдөр төрийн эрүүгийн бодлого боловсрогдоогүй, эрүүгийн эрх зүйн хамгаалалтын цогц тогтолцоо бүрдээгүй, ялангуяа өмчлөх эрхэд суурилсан иргэний нийгмийн хамгаалалт үгүйлэгдэж байна.

Бидний дагаж мөрдөж ирсэн эрүүгийн эрх зүйн номлол нь европын эрх зүйн сонгодог болон социализмаас өвлөж ирсэн гэмт хэрэг үйлдэх нь аливаа этгээдийн “аюултай байдлын” шинж (симптом) гэж үзэх социологи чиг хандлага, түүний дотор Орос, Германы нөлөөгөөр бүрэлдэн тогтсон, хамгийн түгээмэл шинжээрээ баруун европын номлолын рецепцийг нутагшуулсанд оршино.

2015 оны Эрүүгийн хуулийн үзэл баримтлал нь энэ ягшмал байдлаас салахын тулд эрэл хайгуул хийсэн боловч эрүүгийн бодлогын чиг хандлагаа ямар нэгэн эрдэм шинжилгээ судалгааны үндэслэлгүйгээр эрүүгийн эрх зүйн либерализмын онолын аболиционист урсгалыг буюу ямар нэгэн шүүлтүүргүйгээр эрүүгийн цээрлүүлэх бодлогоос ялыг хэт зөөлчихсөн, гэмт хэрэгтэнд хэт энэрэнгүй хандсан “Криминологийн романтизм”-д суурилсан бодлогыг нэвтрүүлсэн нь ихээхэн шүүмжлэлд өртөөд байна. Шоронжсон хэмээн цоллуулсан 2002 оны эрүүгийн хуулийн ялын бодлогод баримталж байсан социологи хандлагыг үгүйсгэснээр гяндан, чанга дэглэмд ял эдэлж байсан ялтнууд жирийн дэглэмд “султан хаан” шиг эрх ямбатай байгааг хуульчид шүүмжилдэг. Шоронжих ойлголт нь хоригдлын тоо нэмэгдсэнээр бус, харин шоронгийн гаж соёл, субкультур жирийн сул дэглэмээр дамжин ниймийн дунд түгэн дэлгэрэх боломж олгосон хуулийг л шоронжсон хууль гэмээр.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл нь парламентын сонгууль, түүнээс байгуулсан засгийн газрын мөрийн хөтөлбөртэй уялдан байнга өөрчлөгдөж ирсэн нь мөн л төрийн нэгдсэн тогтвортой суурь бодлого үгүйлэгдэж буйн жишээ. Шинэ Засгийн газар бүр л өөр өөрсдийн эрүүгийн бодлогыг тодорхойлж, өөрийн гэсэн халаасны “ажлын хэсэг” бүрдүүлж, гадны аль таалагдсан зүйл заалт, рецепцийг шууд хуулбарлаж ирсэн нь туйлын эмгэнэлтэй. Иймд аль нэг эх баригч нам, тухайн үеийн засгийн газрын мөрийн хөтөлбөрт үл автах төрийн эрүүгийн “Хар хайрцагны” бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх нь өнөөгийн тулгамдаж буй асуудлын нэг мөн.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлт нь хүний эрхийг хамгаалах талаарх олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг хэрэгжүүлэхийн хамт гадаад улс орнуудын хууль тогтоомжийг судалж нэвтрүүлэхдээ өөрийн орны эрх зүйн тогтолцооны уламжлалд суурилсан шинэчлэл үгүйлэгдэж байна.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд эрүүгийн бодлого, эрүүгийн хууль тогтоомжийг шинэтгэх арга зам төдийгүй, тухайн шинжлэх ухааны өнөөгийн статус, хөгжлийн чиг хандлага ч тодорхой бус байна.

Төрийн эрүүгийн бодлого нь гэмт явдлыг аль болох бууруулах, тогтоон барихад чиглэсэн төрийн үйл ажиллагааны стратегийн зорилт, чиглэлийг тодорхойлоход оршино. Эрүүгийн эрх зүй нь эрүүгийн хэрэг шийдвэрлэх ажиллагааг хангаж, хүн, хуулийн этгээдэд зан үйлийг гэмт хэрэгт тооцож ялтай болгосон эрх зүйн хэм хэмжээний тогтолцоо, эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл мөн.

Гадаад улс орнуудын туршлагаас үзэхэд, эрүүгийн бодлого боловсруулах нийтлэг технологи, процедурыг баримталж байна:

- Эрүүгийн эрх зүйн онол номлолын үндэслэлийг боловсруулах (Энэ хүрээнд эрүүгийн эрх зүйн эрдэмтдийн хүчин чармайлтыг нэгтгэж, эрүүгийн эрх зүйн ямар онол, үзэл баримтлал, рецепцийг нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэнэ);
- Онолын үндэслэлд тулгуурлан эрүүгийн бодлогын талаарх төрийн үзэл баримтлалыг хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд боловсруулах (Энэ хүрээнд аль ч Засгийн үед үл солигдох төрийн эрүүгийн хар хайрцагны бодлого боловсрогдоно);

⁴³ Freeley M., Simon J. Actuarial Justice the Emerging New Criminal Law // The Futures of Criminology. L.: Sage, 1994. P. 173—201.

- Эрүүгийн бодлогын эрх зүйн орчин, эрх зүйн үндсийг хөгжүүлэх (Эрүүгийн багц хуулийг номлол, үзэл баримтлал, бодлогод нийцүүлэн боловсруулж, батлуулах, уг хуулийг хэрэгжүүлэх тогтолцоо, санхүү хөрөнгийн эх үүсвэрийг хамт шийдвэрлэх);
- Эрүүгийн бодлогыг улс даяар хэрэгжүүлэх;
- Эрүүгийн бодлогын дэд хөтөлбөрүүдийг (өмчлөх эрхийг хамгаалах гэх зэрэг) боловсруулж хэрэгжүүлэх;
- Эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хууль хэрэглэх үйл ажиллагаа зэрэг.

Эрүүгийн бодлогын цогц тогтолцоо нь:

- Эрүүгийн болон эрүүгийн нөлөөллийн арга хэрэгслээр гэмт хэрэгтэй тэмцэх;
- Эрүүгийн процессын буюу гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, нотлох, албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх;
- Эрүүгийн ял эдлүүлэх;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого (криминологи, виктимологи, деликтологи)
- Зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, гэмт хэргийн хохирол, хор уршгийг арилгах, нийгэмшүүлэх бодлого зэргээс бүрдэхээр төсөөлөгдөж байна.

Орчин үеийн эрүүгийн эрх зүй нь шинжлэх ухааны янз бүрийн чиг хандлагын нөлөөллийн үр дүн гэж үзэж болно. Хэрэв зонхилох чиг хандлагын хувьд авч үзвэл аль ч орны хууль тогтоогчид гэмт явдлын асуудалд хандахдаа хориотой үйлдлийн шинж чанарыг аль болох нарийн тодорхойлохын тулд эрүүгийн эрх зүйн сонгодог үндэслэлд, харин ялын асуудалд хандахдаа гэмт хэрэгтнийг залхаан цээрлүүлэх бус харин тэднийг нийгэмшүүлэх, хэрэв нийгэмд аюултайд тооцвол аюулгүй байдлын үүднээс найдвартай тусгаарлах асуудлаар эрүүгийн эрх зүйн социологи чиг хандлагад тулгуурлаж байна. Мөн орчин үеийн улс орнуудад гэмт явдлыг эрүүгийн эрх зүйн онолын үүднээс, харин тодорхой төрлийн ялын хэмжээг улс төрчдийн номлолын үндэслэлээр тогтоох хандлага зонхилж байна.

Иймд:

Нэгдүгээрт, төрийн эрүүгийн бодлогын онол, үзэл баримтлалын үндсийг тогтоож, төрийн эрүүгийн “хар хайрцаг”-ны бодлогын эрдэм шинжилгээ судалгаанд суурилсан үзэл баримтлалыг хууль тогтоогчоос боловсруулах;

Хоёрдугаарт, төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжих эрх зүйн цогц орчинг бүрдүүлэх (эрх зүйн үндэс, уялдаа холбоо бүхий тогтолцоо, санхүүгийн эх үүсвэр гэх зэрэг);

Гуравдугаарт, энэ үйл ажиллагаанд хууль зүйн болон бусад эрдэмтэн судлаачдын хүчийг нэгтгэх;

Дөрөвдүгээрт, Эрүүгийн хууль Үндсэн хуульд хэр нийцэж байгаа талаарх мониторинг хийх шаардлагатай.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ БАРИВЧЛАХ, ТАСЛАН ЗОГСООХ ЗОРИЛГООР ХАЛДАХ ХЭМ ХЭМЖЭЭГ БУСАД НӨХЦӨЛ БАЙДЛУУДААС ЯЛГАХ НЬ

Л.Бат-Очир

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч, докторант

Эрүүгийн хуулийг Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээ, конвенцуудын үзэл санаа, агуулга, нийгмийн шаардлагад нийцүүлэх, ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг хангах үзэл баримтлалд тулгуурлан 2015 онд Улсын их хурлаас шинээр баталсан нь Эрүүгийн эрх зүйн хөгжилд чухал алхам болсон.

Энэ хуулийн дөрөвдүгээр бүлэгт заасан гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал нь эрүүгийн эрх зүйд чухал байр суурь эзэлдэг тулгуур асуудлын нэг бөгөөд аргагүй хамгаалалт, баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах, гарцаагүй байдалд хохирол учруулах, албадлага эрхшээлд автах, үндэслэл бүхий эрсдэл, тушаал, даалгавар биелүүлэх гэсэн зургаан үндсэн төрөлтэй. Эдгээр нь гадаад хэлбэр, шинж байдлаараа гэмт хэргийн шинжтэй боловч дотоод агуулга мөн чанар, нийгэмд ашигтай шинж, зорилгоороо гэмт хэргийн нийгэмд аюултай шинжийг үгүйсгэж байдгаараа нийтлэгээс гадна, өөр хоорондоо ялгагдах онцлог шинжүүдтэй. Практикт ижил төсөөтэй олон тохиолдлыг буруу зүйлчлэлж Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх зэрэг алдаа дутагдал их байдаг нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын талаарх онолын мэдлэг дутмаг, хоорондын нарийн зааг ялгааг мэддэггүй, хууль хэрэглэх ур чадвар дутагдалтай байгаагийн илрэл юм. Гэмт хэргийг үгүйсгэсэн нөхцөл байдлын хэм хэмжээнүүд нь өргөн утгаараа гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг, өөрийн болон ойр дотны хүний, бусдын эрх, эрх чөлөө, нийгмийн эрх ашиг сонирхлыг хамгаалах, баталгаажуулах хэм хэмжээ юм.

Тийм учраас тэдгээрийн ялгаатай шинжийг эрүүгийн эрх зүйн онолын үүднээс зөв тодорхойлох, практикт үйлдэгдсэн тохиолдлын хууль цаазны шинж, түүний мөн чанарт зөв үнэлэлт, дүгнэлт өгөх, эрүүгийн хуулийг зөв хэрэглэх шаардлагатай төдийгүй онол практикийн чухал ач холбогдолтой юм. Доктор, профессор С.Жанцан, судлаач Б.Ганболд нар гэмт хэргийг үгүйсгэх зарим нөхцөл байдлуудын төсөөтэй болон ялгаатай талыг⁴⁴ гаргахдаа зөвхөн аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох нөхцөл байдлын хүрээнд тэдгээрийг хооронд нь харьцуулсан. Үүнээс өөр бүх нөхцөл байдлыг хооронд харьцуулж ялгаатай болон төстэй шинжийг тодорхойлсон тохиолдол байхгүй байна. Энэ сэдвийн хүрээнд баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээг бусад таван төрөлтэй харьцуулан ялгаатай талыг гаргахыг зорьсон. Ингээд баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах болон гэмт хэргийг үгүйсгэх бусад нөхцөл байдлуудын нийтлэг болон ялгагдах шинжийг төрөл тус бүрээр нь авч үзье.

1. Аргагүй хамгаалалтаас ялгах нь

Аргагүй хамгаалалтын ухагдахуун нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд чухал суурийг эзэлдэг.⁴⁵ Эрүүгийн эрх зүй дэх аргагүй хамгаалалтын тухай асуудлыг онол практикийн үүднээс зөв тайлбарлаж хэрэгжүүлэх нь хууль ёсыг бэхжүүлэх, улс нийгмийн болон иргэдийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн нэг чухал баталгаа юм.

Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах болон аргагүй хамгаалалт нь хэд хэдэн шинжүүдээрээ төсөөтэй юм. Тухайлбал:

1.Эдгээрийг хэрэгжүүлэх үндэслэл нь хүний хууль бус ажиллагаа байдаг.

2.Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдах, аюултай довтолгоон хийж буй этгээдийн довтолгооныг няцаахдаа зөрчлийн болон Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж баривчлагдаж буй этгээд, довтлогчид гэм хор учруулж болно.

⁴⁴.Жанцан.С.Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол.УБ.,2009.734-736 дугаар тал.Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээг, Аргагүй хамгаалалт, Гарцаагүй байдлын хэм хэмжээтэй харьцуулан ялгаатай 8 шинжийг тодорхойлсон.

⁴⁵ Ганболд.Б.Эрүүгийн эрх зүйлд нэвтэрхүй. УБ.,2012. 560 дахь тал.

3.Баривчлагдаж буй болон хамгаалж буй хүмүүсийн зан байдал гадна илрэх шинжээрээ төсөөтэй байдаг.

4.Дээр дурдсан хоёр нөхцөл байдлууд нь нийгэмд ашигтай зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг

5.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд гэмт этгээдийг баривчлах үед болон аргагүй хамгаалалт хийж учруулсан гэм хор хоёулаа эргэн төлөгдөх учиргүй зэрэг болно.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдах болон аргагүй хамгаалалт нь дараах шинжээрээ ялгаатай байна. Тухайлбал:

1.Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох эрх, үүрэг нь тодорхой этгээд гэмт хэрэг үйлдсэн болон сэжигтэн яллагдагч, шүүгдэгч, ялтан оргон зайлсан, гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж эхэлсэн, хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, зугтаасан үеэс, харин аргагүй хамгаалалт хийх эрх бол өөрийн болон ойр дотны хүний эсрэг чиглэсэн нийгэмд аюултай довтолгоон бодитойгоор эхэлсэн үеэс тус тус үүснэ.

2.Хамгаалж байгаа нийгмийн харилцаа, эрх ашиг сонирхолд халдаж байгаа хор аюулын эх үүсвэрээрээ ялгаатай. Аргагүй хамгаалалтын үед тулгарч байгаа хор аюулын эх үүсвэр нь зөвхөн хүний ухамсартай, нийгэмд аюултай үйл ажиллагаа байдаг. Өөрөөр хэлбэл, аргагүй хамгаалалтыг Эрүүгийн хуулиар хамгаалагдсан өөрийн болон эхнэр нөхөр, хамтран амьдрагч, эцэг эх, өвөг эх, эмэг эх, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү хамт амьдарч байгаа бусад төрөл садагийн хүний амь нас эрүүл мэндийн эсрэг хууль бус тулгарсан довтолгооны эсрэг хэрэглэнэ.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдах нь гэмт хэрэг үйлдэж оргосон хүн, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хийж буй хүний үйлдлийг таслан зогсоох, төрийн зохих байгууллагад хүргэх, урьдчилан сэргийлэх зорилготой байна. Өөрөөр хэлбэл иргэд болон хууль сахиулагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, олон нийтийн амгалан тайван байдлын эсрэг хийсэн идэвхтэй довтолгоон, хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, зугтаасан аливаа үйлдэл эс үйлдэхүйн эсрэг хэрэгжүүлнэ. Аргагүй хамгаалалтын зорилго нь өөрийн болон ойр дотны хүний хуулиар хамгаалагдсан эрх ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

3.Аргагүй хамгаалалтыг хэрэгжүүлэх явцад хэр хэмжээнд хийгдсэн байх шаардлагыг тавихгүй. Аргагүй хамгаалалтыг хэрэгжүүлж буй субъект нь өөрийн мэргэжил, тусгай бэлтгэл, албан ажлын байдал, довтолгооноос зайлсхийх боломж байсан эсэх, бусдаас тусламж авахаар хандах боломжтой байсан эсэхээс үл хамааран аргагүй хамгаалалт хийх эрхтэй. Өөрөөр хэлбэл аргагүй хамгаалалтын үед учирч болох байсан хохирлоос илүү хохирол учруулж болдог. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдах үед тодорхой хүрээ хязгаарын дотор хийгдсэн байхыг шаардах ба гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохиороогүй, зайлшгүй хохирол учруулж гэмт этгээдийг баривчлах шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж бусдад халдаж хохироосныг хэр хэмжээ хэтрүүлсэнд тооцно. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед ийм боломж байхгүй бөгөөд аль болох хохирол учруулахгүй байх бүх нөхцөлийг хангах, зайлшгүй тохиолдолд учирч болох хамгийн бага хохирлыг учруулах ёстой ба хэрэв баривчлах, таслан зогсоох ажиллагааны нөхцөл байдал хэр хэмжээнд тохиороогүй илүү хохирол учруулсан бол гэмт этгээдийг баривчлах, таслан зогсоох ажиллагааны хэр хэмжээг хэтрүүлсэн гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

4.Аргагүй хамгаалалтыг өөрийн болон ойр дотны хүний амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулахуйц довтолгоон чиглэгдсэн хэн ч хэрэглэж болох ба гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед гуравдагч этгээд, хууль сахиулагч субъект хэрэгжүүлнэ.

5.Аргагүй хамгаалалт нь зөвхөн идэвхтэй довтолгоон болон довтолгоон эхлэх гэж байгаа нь тодорхой болсон үед хэрэгжүүлдэг бол гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдахдаа хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэгжүүлэхээс гадна гэмт хэрэг үйлдэгдэж дууссаны дараа эсвэл гэмт хэрэг үйлдэж байх явцад хэрэгжүүлнэ. Гэхдээ гуравдагч хүний эсрэг довтолсон тохиолдолд аргагүй

хамгаалалт бус гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээгээр шийдвэрлэнэ.

6. Аргагүй хамгаалалтын үед довтолгооны эсрэг хэрэгжүүлсэн арга нь онцын ач холбогдолгүй байдаг бол гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдах үед хэрэглэсэн арга нь гэмт үйлдлийн шинж чанар, тухайн нөхцөл байдалд тохирсон, шат дараалан хэрэгжүүлсэн, гэмт этгээдийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хууль ёсны эрх ашиг сонирхолд хамгийн бага хохирол учруулахуйц арга байх ёстой.

7. Аргагүй хамгаалалтын үед зөвхөн довтлогч этгээдэд хохирол учруулдаг бол гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед гуравдагч этгээдэд хохирол учирч болно.

8. Гэмт этгээдийг баривчлах, таслан зогсоох ажиллагааны зорилго бол дээр дурдсан этгээдүүдийг төр, засгийн байгууллагад хүргэх, шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой байдаг бол аргагүй хамгаалалт нь эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг нийгэмд аюултай довтолгооноос хамгаалах зорилгод чиглэгддэг.

9. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үйлдэл нь хуулиар ийм эрхтэй, үүрэг хүлээсэн хүний хүсэл зоригоос хамаардаг бол аргагүй хамгаалалтыг хэрэгжүүлсэн хүн нь өөрийн хүсэл зоригоос ангид бий болсон довтолгооноос хамгаалж, довтлогч этгээдэд хохирол учруулахаас аргагүй байдалд орсон байдаг.

10. Гэмт этгээдийг баривчлах, саатуулах ажиллагааг өөр аргаар хэрэгжүүлэх боломжгүй аргагүйдсэн үед гэм хор учруулбал хууль ёсны үндэслэлтэйд тооцогдох бөгөөд аргагүй хамгаалалт хийж довтлогч этгээдэд хохирол учруулах нь түүнээс зайлсхийх, бусдын тусламж авах боломжтой байсан эсэхээс үл хамаардаг онцлогтой.⁴⁶

Тишкевич.И.С.: "Баривчлагдаж, буй субъект нь довтолгооноо зогсоосон тохиолдолд баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлнэ. Аргагүй хамгаалалт, баривчлах саатуулах үед гэм хор учруулах үйлдэл адил түвшинд өрнөдөг. Гэмт этгээдийн довтолгоон эхэлмэгц аргагүй хамгаалалт хийж үйлдлийг нь таслан зогсоосны дараа гэмт этгээдийг баривчлах, саатуулах хүйл ажиллагаа явуулна. Довтолгоон хийсэн үед аргагүй хамгаалалт хэрэглэсний дараа баривчилж саатуулна"⁴⁷ гэсэн нь гэмт этгээдийн үйлдлийг таслан зогсоож буй субъект нь хэн байхаас хамаарч аргагүй хамгаалалтын нөхцөл юм уу гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох нөхцөл байдал юм уу гэдгийг тодорхойлох шаардлагатай.

Хууль сахиулагчийн эсрэг чиглэсэн довтолгооныг таслан зогсоож буй үйлдлийг аргагүй хамгаалалт гэж үзэхгүй, харин гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох нөхцөл гэж үзнэ. Энэ нь аргагүй хамгаалалтыг хэрэглэх эрх бус гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах нийтлэг үүрэгтэй холбоотой юм.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцад учруулсан хохирол нь нийгэмд аюултай довтолгооны хэр хэмжээтэй нийцэж байх ёстой ба энэ нь шинж чанараас гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарыг үнэлэх асуудал бий болно. Энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хоёрдугаар бүлгийн зургадугаар зүйлд заасан гэмт хэргийн ангиллаас хамаарах ба тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл хэмжээгээр тодорхойлогдоно. Ийм учраас аргагүй хамгаалалтыг гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох институтаас мөн чанар, агуулга, шинж чанараар нь зөв ялгаж ойлгож хэрэглэснээр практикт ач холбогдол нь тодорхойлогдоно.

2. Гарцаагүй байдалд хохирол учруулахаас ялгах нь

Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын нэг төрөл нь гарцаагүй байдал юм. Эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд тулгарсан аюулыг өөр арга хэрэгслээр арилгах боломжгүй нөхцөл байдалд учирч болох байсан аюулын хэр хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр Эрүүгийн хуулийнтусгай ангид заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж бусдад хохирол учруулсан нийгэмд ашигтай үйл ажиллагааг гарцаагүй байдал гэнэ.

⁴⁶. Бат-Очир.Л. Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд ба аргагүй хамгаалалтын асуудал. УБ., 2007. 20-21 дүгээр тал.

⁴⁷. Тишкевич.И.С. Условия и пределы необходимой обороны. М., 1969. стр. 197.

Гарцаагүй байдал нь аргагүй хамгаалалттай нэг адил Монгол улсын эрүүгийн эрх зүйн нэг судлагдахуун байсан тул энэ талаар харьцангуй өргөн хүрээнд судлагдсан.

Гарцаагүй байдлын талаар эрүүгийн эрх зүйн бүтээлүүдэд өөр өөр байдлаар тусгаж ирсэн ч энэ хэм хэмжээний ач холбогдлыг бууруулаагүй ба онолын болон нэгдмэл ойлголтын талаар судалж ирсэн гэж ойлгож болно.⁴⁸ Гарцаагүй байдал нь гэмт халдлага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг биелүүлэх үүднээс хэрэгждэггүй онцлогтой. Гарцаагүй байдалд эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийтлэг эрх ашиг сонирхолд тулгарсан аюулыг тухайлбал, хүний үйлдэл, байгалийн давагдашгүй хүчин зүйл, араатан амьтдын довтолгоон, техникийн аюул болон бусад хүчин зүйлээс хамгаалах зорилгоор тухайн аюулын эсрэг хэрэгждэг хохирол учруулсан идэвхтэй үйлдэл хийдэг.

Гарцаагүй байдалд хохирол учруулах нөхцөл байдлыг, баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах нөхцөл байдлаас ялгагдах шинжүүдийг тодорхойлох шаардлагатай. Үүнд:

1.Гарцаагүй байдлын үед учруулсан хохирол нь учирч болох байсан хохирлоос ямагт бага байх зарчмыг баримтлах ёстой. Үүнтэй холбоотой зарим эрдэмтэд гарцаагүй байдлын үед хохирол учирч болох байсан олон эрх ашгаас хамгийн амин чухал эрх ашиг сонирхлыг л хамгаалах нь зүйтэй гэж үздэг. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үйлдэл нь гагцхүү хэр хэмжээнд хийгдсэн байх ёстой байдаг тул учруулсан хохирол нь бага, эн тэнцүү эсвэл хэтэрсэн байж болно.

Өөрөөр хэлбэл учирсан хохирол болон уг хохиролд хүргэсэн үйлдэл нь хэм хэмжээнд хийгдсэн байна гэсэн үг юм. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед ямар хохирол учруулах нь тухайн баривчлах, таслан зогсоогдож буй гэж буй субъектийн хувийн байдлаас хамаардаг.

2.Гарцаагүй байдлын үед учирч болох хор аюулыг өрсөн зайлуулах талаар ямар нэгэн санаачилга гаргаагүй бол эрүүгийн хариуцлага хүлээнэ. Тусгай субъектийн хувьд тухайн нөхцөл байдлын талаар ерөнхий урьдчилан төсөөлж тооцоолсон байдаг тул тулгарсан аюулыг өөр аргаар зайлуулах боломжгүй үед хэрэглэх үүрэг хүлээсэн байдаг.

3.Гэмт хэрэг үйлдэж оргосон болон гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж буй хүний үйлдлийг таслан зогсоох, шинээр дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, түүнийг төрийн байгууллагад хүргэх зорилгоор хийгддэг бол гарцаагүй байдлын үед эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд тулгарсан аюулыг зайлуулах зорилготой байна.

4.Гарцаагүй байдлын үед тулгарч байгаа хор аюулын эх үүсвэр нь зөвхөн хүний үйл ажиллагаа төдийгүй давагдашгүй хүч, физиологийн шаардлага, адгуусан амьтны довтолгоон зэрэг байж болдог онцлогтой. Тэгвэл гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох ажиллагааны эс үүсвэр нь гэмт хэрэг үйлдсэн болон үйлдэж буй хувь хүний үйлдэл байна.

5.Гарцаагүй байдлыг хэн ч хэрэгжүүлж болно. Тэгвэл гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор хууль сахиулагч болон энгийн иргэд ч хэрэгжүүлж болно.

6.Гарцаагүй байдлын хэрэгжүүлэх үндэслэл нь нийгмийн эрх ашигт тулгарсан аюул байдаг бол гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үндэслэл нь гэмт хэрэг үйлдсэн болон гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж буй хүний эсэргүүцсэн, зугтаасан, зайлсхийсэн гэмт хэргийн шинжтэй идэвхтэй үйлдэл байна.

7.Гарцаагүй байдлын үед учирсан хохирол нь ямагт бага байх шаардлагагүй, харин учирч болох байсан хохирлоос л бага байх ёстой. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед учруулсан хохирол нь мөн бага байх ёстой ба хохирол учруулахааргүй нөхцөл байдал үүссэн бол түүнийг заавал ашиглах ёстой. Эдгээр шинжээрээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн, гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох, гарцаагүй байдалд хохирол учруулах хэм хэмжээ нь хоорондоо төсөөтэй.

8.Гарцаагүй байдлын үед эрүүгийн хуулиар хамгаалсан нийтлэг эрх ашиг байдаг бол гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед зөвхөн гэмт этгээд болон түүний амь нас, эрүүл мэнд, өмч гэх мэт гэмт этгээдтэй холбоотой бусад эрх ашигт халддаг.

⁴⁸ Жанцан.С.Моногл улсын эрүүгийн эрх зүйн онол.УБ.,2009.718 дугаар тал.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох, гарцаагүй байдалд хохирол учруулах явцад баривчилж таслан зогсоосон, тулгарсан аюулыг зайлуулсан үйлдэл, аюулын шинж чанар хэр хэмжээ нь учруулсан хохиролтой нийцэж байх ёстой.

9.Гарцаагүй байдалд хохирол учруулсан нь цаг үеэ олсон байх ба тулгарсан аюул бий болсон үеэс түүнийг зогсоох хүртэлх тэр цаг үед хохирол учруулсан бол цаг үеэ олсон гэж үзнэ. Энэ цаг үе нь урт, богино хугацааны байж болох бөгөөд хугацаа нь тулгарсан аюулын шинж байдлаас хамаарна. Тулгарсан аюул нь зогсох, хохирол учрахаас өмнө тухайн аюулыг өрсөн зайлуулж хийгдсэн байна. Хэрэв дээрх нөхцөл байдал бий болоогүй байхад буюу хохирол учирч дууссаны дараа үйлдэл хийвэл нийгэмд аюултай, хууль бус үйлдэлд тооцогдоно.

Харин гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хохирол учруулах нь эрүүгийн хариуцлагад татах хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй, тодорхой гэмт хэрэг үйлдэгдсэний дараа л хохирол учруулдгаараа ялгаатай байна. Ийм учраас гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үеийн цаг хугацааны асуудал нь илүү тодорхой байна гэсэн үг юм.

10.Гарцаагүй байдалд хохирол учруулах явцад гарцаагүй байдлын хэр хэмжээ хэтрүүлсэн тохиолдолд ямар эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар тусгай ангид тодорхой заагаагүй, учруулсан хохирлын шинж чанар, тухайн үеийн нөхцөл байдал, хэр хэмжээнээс хамаарч Эрүүгийн хуулийн тусгай ангийн зохих зүйл хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно. Харин гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцад хэр хэмжээ хэтрүүлж хүнийг алсан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10 дугаар бүлгийн гуравдугаар зүйлд заасан Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргээр, хэр хэмжээ хэтрүүлж эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангийн зохих бүлэг, зүйл хэсгээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 108.2 дугаар зүйлд заасан: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах хэр хэмжээ хэтрүүлж хүний санаатай алах, 114.2 дугаар зүйлд заасан :Гэмт хэрэг үйлдсэн хүнийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах хэр хэмжээ хэтрүүлж хүний бие махбодод хүнд хохирол учруулах гэмт хэргээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол⁴⁹, Гарцаагүй байдлын үед хэр хэмжээ хэтрүүлсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61.1 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага оногдуулахдаа хөнгөрүүлж үзэхээс гадна гэмт хэргийг үгүйсгэх бусад бүх нөхцөл байдлуудыг хамааруулдаг.

Манай улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн дөрөвдүгээр бүлэгт зааснаас үзэхэд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын үед хэр хэмжээ хэтрүүлэх тухай асуудлыг зөвхөн Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах, Гарцаагүй байдалд хохирол учруулах, Үндэслэл бүхий эрсдэл, Албадлага эрхшээлд автах институтэд тусгасан бөгөөд Аргагүй хамгаалалт, Тушаал даалгавар биелүүлэх үед хэр хэмжээ хэтрүүлэх тухай асуудал яригдахгүй. Энэ нь дээрх нөхцөл байдлуудын үед хэмжээ хязгааргүй чөлөөтэй хэрэглэх тухай ойлголт огт биш бөгөөд гэмт хэргийг үгүйсгэх үндэслэл, хууль цаазын шалгуурыг тодорхой заасан.

3.Тушаал, даалгавар биелүүлэхээс ялгах нь

2002 оны эрүүгийн хуульд энэ хэм хэмжээний анх хуульчилсан нь төрийн тусгай албан тушаалтны тушаал, даалгаврын үнэ цэнэ, ач холбогдлыг дээшлүүлж, тушаал, даалгавар биелүүлэгч субъектийн аюулгүй байдлыг бэхжүүлж өгснөөр ач холбогдолтой болжээ.

Тушаал даалгавар биелүүлэх хэм хэмжээ нь Эрүүгийн хуульд тусгасан нэг шинэ төрөл бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн дөрөвдүгээр бүлгийн зургаа дугаар зүйлд “Цэргийн алба хаагч, хууль сахиулагч дээд албан тушаалтны бичгээр, амаар өгсөн заавал биелүүлэх тушаал, даалгаврыг хууль бус болохыг мэдэх боломжгүй, мэдэлгүйгээр биелүүлж энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй. Хууль бус тушаал, даалгавар өгсөн албан тушаалтныг уг гэмт хэргийг үйлдсэн

⁴⁹.Уголовное право.Общая часть./Отв.ред.Здравомыслов.Б.В/./М.,1996.с 68.

гүйцэтгэгчид тооцно⁵⁰ гэж заасан байна. Харин Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан илэрхий гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг хийлгэхээр өгсөн илт хууль бус тушаал, шийдвэр нь цэргийн алба хаагч, хууль сахиулагч өөрөө бие даан шийдвэрлэх ёстой албаны үүрэг, эрх мэдэлд хамаарахаар байтал уг даалгаврыг зориуд биелүүлсэн бол тухайн цэргийн алба хаагч, хууль сахиулагчийг гэмт хэрэг үйлдсэн гүйцэтгэгчид, тушаал, даалгавар өгсөн албан тушаалтныг бусдыг ашиглан гэмт хэрэг үйлдсэн гүйцэтгэгчид тооцно.

Эрүүгийн эрх зүйн онолын үүднээс хууль бус тушаал, даалгавар биелүүлсэн этгээд нь уг тушаал, даалгавар нь хууль бус гэдгийг мэдэх боломжгүй, мэдэлгүйгээр биелүүлсэн байдаг учраас гэмт хэрэгт тооцохгүй үгүйсгэгддэг. Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах нөхцөл байдал болон тушаал, даалгавар биелүүлэх хэм хэмжээг өөр хооронд нь ялгаж ойлгох шаардлагатай. Эдгээрийн ялгааг дараах байдлаар авч үзье.

1. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох ажиллагаа нь нийгмийн хор аюул, хэр хэмжээ, зарим тохиолдолд гэм буруугүй байдал, үндэслэл, журмаараа хэм хэмжээнээс ялгаатай бол, тушаал, даалгавар биелүүлэхэд гэм буруутай байх шинж байдаггүй. Өөрөөр хэлбэл дээд шатны албан тушаалтны өгсөн үүрэг даалгавар биелүүлж байгаа учир субъектийн гэм буруу биш юм.

2. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох, тушаал даалгавар биелүүлэх үед хохирол учруулах үндэслэл журмаараа ялгаатай байна. Тушаал, даалгавар биелүүлэх үед ямар үндэслэл журмын дагуу, ямар хохирол учруулах талаар тодорхойгүй байдаг ба хэрэв тушаал, даалгавар биелүүлэх үед хохирол учруулсан, мөн тушаал, даалгавар нь хууль бус гэдгийг мэдэх боломжгүй үед хохирол учруулсан тохиолдолд гэмт хэрэгт тооцохгүй.

3. Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаанд хохирол учруулж буй явдал нь цэргийн алба хаагч, хууль сахиулагчид хуулиар олгогдсон эрх хэмжээ, нийгмийн харилцааны бусад тохиолдол, тухайн үеийн нөхцөл байдал зэргээс хамаардаг. Харин гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хохирол учруулах үндэслэл нь оргосон ялтан, гэмт хэрэг үйлдэж буй этгээдийг өөр арга хэрэгслээр баривчлах, таслан зогсоох боломжгүй байсан зэргээс хамаардаг.

4. Тушаал, даалгавар заавал биелэгдсэн байх явдал нь тушаал, даалгаврыг ямар нөхцөлд өгөгдсөн, түүнийг биелүүлэх үед ямар нөхцөл байдал үүссэн зэргээс хамаарна. Энэ нөхцөл байдал нь гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хамаарахгүй. Хууль сахиулах байгууллагын хувьд гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох талаар тушаал даалгавар өгч болох боловч баривчилж, таслан зогсоож буй субъектын хувьд энэ нь хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх албаны үүрэг болдог. Цагдаагийн алба хаагчийн хувьд үүнийг мэргэжлийн үүрэг гэж үздэг үзэл баримтлал байдаг⁵¹ боловч үүнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

Учир нь гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцад өгсөн тушаал даалгавар нь заавал хууль ёсны байхыг шаардана, харин цэргийн алба хаагч, хууль сахиулагчид өгсөн тушаал, даалгавар нь хууль бус болохыг мэдэх боломжгүй, мэдэлгүйгээр биелүүлсэн бол Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн дөрөв дүгээр бүлгийн зургаа дугаар зүйлд зааснаар тушаал, даалгавар биелүүлсэн гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй. Старостина.Ю.: "Хууль бус тушаал, даалгавар биелүүлэх явцад эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсан бол тухайн хүнийг гэмт хэрэгт тооцно"⁵² гэснийг дэмжих боломжгүй юм. Уг тушаал, даалгаврыг хууль бус гэдгийг мэдэх боломжгүй, мэдэлгүйгээр биелүүлсэн бол гүйцэтгэсэн этгээдийн үйлдлийг гэмт хэрэг тооцохгүй, харин хууль бус тушаал, даалгавар өгсөн дээд шатны албан тушаалтныг гэмт хэрэг үйлдсэн тооцоно. Өөрөөр хэлбэл тушаал, даалгавар өгсөн албан тушаалтан гэмт хэрэг үйлдэх гэсэн өөрийн санаа зорилгоо бусдаар дамжуулан хэрэгжүүлсэн гэж үзэх ба тушаал, даалгаврын хэлбэр, агуулга, гарах үр дагаварын талаар урьдчилан тооцоолсон байдаг.

⁵⁰. Эрүүгийн хууль. УБ., 2015. 4.6 дугаар зүйл.

⁵¹. Михайлов. В. И. Нормативное регулирование исполнения приказа и некоторые вопросы уголовного права. Государство и право. М., 1996. №12 стр 66.

⁵². Старостина. Ю. Обязательность приказа, как обстоятельство, исключающее преступность деяния. Законность. М. 2000. №4 стр 11.

5.Тушаал, даалгавар нь албадлагын шинжтэй учраас субъектийн үйлдэл гэж үздэггүй, учраас, тухайн үеийн нөхцөл байдлыг үнэлэх, дүгнэх шаардлаггүй. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед ихэвчлэн тушаал өгдөггүй ба баривчилж, таслан зогсоож буй субъект нь тухайн нөхцөл байдлыг үнэлж дүгнэж байдаг.

6.Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хууль сахиулагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, биелүүлэхээс татгалзсан, зугтаасан эсэхээс хамаарах бөгөөд тушаал, даалгавар биелүүлэх үед зөвхөн албан тушаалтны албадлага байна.

7.Тушаал, даалгавар биелүүлэх явдал нь цаг хугацаа, хэр хэмжээний хувьд тодорхойгүй байдаг ба шүүх өөрийн үзэмжээр үнэлж дүгнэх нөхцөлийг бүрдүүлсэн байх болох талтай юм. Харин гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед тухайн үеийн нөхцөл байдал, үйлдлийн шинж чанар, хэр хэмжээ, хохирлыг үнэлэх боломжтой.

Эндээс дүгнэхэд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын нэг бие даасан төрөл болох болох тушаал, даалгавар биелүүлэх нь бие даасан хууль цаазын шинж болон практикийн үүднээс үнэлж, дүгнэхэд эрс ялгаатай.

4.Үндэслэл бүхий эрсдэлээс ялгах нь

Улсын их хурлаас 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн дөрөвдүгээр бүлгийн тавдугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Нийтэд тустай үр дүнд хүрэхийн тулд үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлыг хийхдээ хууль стандартад заасан эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан боловч энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол, хор уршиг учирсан бол гэмт хэрэгт тооцохгүй⁵³” гэж, энэ зүйлийн 2 дахь хэсэгт “Хүний амь насанд хохирол учруулах, нийтийг хамарсан, гамшигт хүргэх аюултай нөхцөлд эрсдэл хийсэн, хүний биед туршилт хийснийг үндэслэл бүхий эрсдэлд тооцохгүй” гэж тус тус заасан. Эрсдэлийн тухай ойлголтыг иргэний эрх зүйд даатгалын эрсдэл гэдэг нэр томъёогоор хэрэглэдэг⁵⁴ ба даатгалын тухай хуульд⁵⁵ даатгуулсан зүйлд учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг даатгалын тохиолдол буюу даатгалын эрсдэл гэж заажээ.

Шүүхийн практикт үндэслэл бүхий эрсдэлд хамаарах нөхцөл байдлуудыг мэргэжлийн үүргээ биелүүлэх, эсвэл болгоомжгүй үйлдэлд хамааруулан үзэх хандлага түгээмэл байдаг. Үндэслэл бүхий эрсдэлийн талаар судалсан анхны судлаач нь Гринберг.М.С бөгөөд⁵⁶ энэ талаар нэг сэдэвт бүтээл туурвиж хэвлүүлжээ.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэм хэмжээг, үндэслэл бүхий эрсдэлээс ялгах шаардлагатай байдаг. Үүнд:

1.Үндэслэл бүхий эрсдэлийг хэрэгжүүлэх хүрээ хязгаар нь зөвхөн үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд байдаг бол, гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явдал нь гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хүрээнд хэрэгжүүлнэ.

2.Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох нь гэмт этгээдийн үйлдлийг таслан зогсоох, төрийн зохих байгууллагад хүргэх зорилгоор, харин үндэслэл бүхий эрсдэл нь нийтэд тустай үр дүнд хүрэх зорилгоор хийгдэнэ.

3.Үндэслэл бүхий эрсдэл хийхээс өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангалттай авсан байх ёстой ба гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээг хэрэгжүүлэх нь тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарна. Зарим тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй гэнэтийн шинжтэй нөхцөл үүсч болно. Урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээний хангалттай байсан эсэх гэдэг нь үнэлэмжийн тухай ойлголт бөгөөд энэ үнэлэмж нь олон хүчин зүйлээс хамаарна.

⁵³ Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д “эрсдэх” гэдэг үгийг “хэлмэгдэх”, “нэрвэгдэх” хилс хэрэгт эрсдэх, “галын аюулд эрсдэх” гэж тайлбарласан. Дурдсан зохиол. 884 дүгээр тал.

⁵⁴ Монгол Улсын иргэний хууль.УБ.,2002.431.4.2 дугаар зүйл.

⁵⁵ Даатгалын тухай хууль.УБ.,1998.4.1.4 дүгээр зүйл.

⁵⁶ Гринберг.М.С.Момент оправданного риска в производственном процессе и его уголовно-правовое значение// Сов. гос-во и право.М.,1954.№ 1 стр 45

4. Үндэслэл бүхий эрсдэлийг үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэшсэн, тусгай мэргэжлийн субъект хэрэгжүүлдэг бол гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үйлдлийг хууль сахиулагч, эрх олгосон улсын байцаагч, байгаль хамгаалагч, иргэд хэрэгжүүлнэ.

5. Эрсдэлтэй үйлдэл хийж буй субъект олон үйлдлээс сонгох боломжтой байдаг. Эсвэл эерэг, сөрөг үр дагаврыг сонгох боломж юм. Энэ нь үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын ямар ч үед үүснэ. Эдгээр үйл ажиллагааны чиглэлээс хамаарч ямар тохиолдолд үндэслэл бүхий эрсдэл хийж хохирол учруулж буйг олон талаас нь авч үзэх нь зүйтэй. Харин гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцад энэ ажиллагааг хэрэгжүүлэгч болон баривчлагдаж буй субъектийн аль алиных нь үйлдлээс хамаарч байдаг.

6. Үндэслэл бүхий эрсдэлийн үед эрдэм, шинжилгээ, судалгааны ажлын үндсэн дээр ямар эрсдэл учрах, ямар үйлдэл хийхийг урьдчилан мэдэх бололцоотой байдаг бол, гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцад гэмт этгээдийн үйлдсэн болон үйлдэж буй гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, тухайн үеийн нөхцөл байдал, объектив олон хүчин зүйлээс хамаарна. Үндэслэл бүхий эрсдэл нь хүний амь насанд хохирол учруулах, нийтийг хамарсан гамшигт хүргэх аюултай нөхцөлд эрсдэл хийсэн, хүний биед туршилт хийсэн тохиолдолд үндэслэл бүхий эрсдэлд тооцохгүй бөгөөд нийтлэг үндэслэлээр гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

5. Албадлага, эрхшээлд автах аас ялгах нь

Монгол улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн дөрөвдүгээр бүлэгт заасан гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд, албадлага эрхшээлд автах хэм хэмжээг шинэчлэн нэмж хуульчилсан. Энэ талаар Академич С.Нарангэрэл: "Бие махбодын болон сэтгэл санааны талаар албадан хавчих нь гэмт хэргийн аюулыг үгүйсгэх онолын нэг үндэслэл мөн. Энэ талаар дагаж мөрдөж байгаа эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж үзэхгүй байх тохиолдлыг заасан хэм хэмжээ ерөнхий ангид байхгүй. Энэ асуудлыг онол болон практик талаас нь нарийвчлан судалж эрүүгийн хуульд тусгах нь онцгой чухал⁵⁷ гэжээ.

"Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал"-ын талаарх судалгаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа боловч манай улсын хувьд энэ төрлийн судалгаа төдийлөн сайн судлагдахгүй байна. ОХУ-ын эрдэмтэн Слущкий 1950 онд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлуудыг цаг үе, нийгэмд ашигтай байх шинжээр нь төрөлжүүлэн ангилж үндэс суурийг тавьсан юм. Тэрээр:

-Байнга буюу үргэлж нийгэмд ашигтай байх

-Тодорхой цаг үед л нийгэмд ашигтай байх гэж ангилсан.

Албадлага, эрхшээлд автах нь тодорхой цаг үед нийгэмд ашигтай байх ангилалд хамаарна. Албадлага гэдэг нь-Хүчлэн тулгах, захиран тушаах, албадан хөдөлмөр хийлгэх, хавчлага⁵⁸, эрхшээл гэдэг нь-Хүний эрх мэдэлд орох, аяаг харах, эрхшээлд орох⁵⁹ гэсэн утгатай үг юм.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэм хэмжээ нь, албадлаг эрхшээлд автах хэм хэмжээнээс дараах шинжээрээ ялгаатай байна. Үүнд:

1. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед нийгэмд аюултай шинж үгүйсгэгддэг бол албадлага, эрхшээлд автах үед гэм буруугийн шинж байдаггүй. Өөрөөр хэлбэл бусдыг албадан нийгэмд аюултай үйлдэл хийлгэдэг, гэмт хэрэг үйлдэх талаар санаа зорилго, сэдэлт байдаггүй учир гэм буруугүй буюу гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинж байдаггүй.

2. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох ажиллагааны явцад хууль сахиулагч өөрийнхөө үйлдлийг удирдан жолоодох чадвартай байна. Тэгвэл албадлага эрхшээлд автсан хүн өөрийн үйл ажиллагааг удирдан жолоодох чадваргүй бусдын хүсэл зоригийн үндсэн дээр хэрэгжүүлсэн үйлдэл байна. Албадлага эрхшээлд оруулахдаа биеийн хүч хэрэглэх (эрүү шүүлт тулгах, зодох, тарчлаах, хэрцгий

⁵⁷ Нарангэрэл. С. Монгол улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 1996. 186 дугаар тал.

⁵⁸ Цэвэл. Я. Монгол хэлний тайлбар толь. УБ., 1963. 29 дүгээр тал.

⁵⁹ Монгол хэлний их тайлбар толь. УБ., 2014. 69 дүгээр тал.

харьцах, түргэн шатамхай бодис, химийн бодис ашиглах, хүлэх гэх мэт), эсвэл биеийн хүч хэрэглэхгүй (хорих, өлсгөх, цангаах, дааруулах, наранд шарах гэх мэт) байж болно.

3.Албадлага эрхшээлд автсан үед хэдэн хүн байсан, албадлага, эрхшээлд оруулсан үйлдэл, шаардлага, арга хэлбэр, шинж, өрнөл, ашигласан зэвсэг хэрэгсэл, биеийн хүчний харьцаа, эрүүл мэнд, өндөр, биеийн ерөнхий хөгжил, хүч, цаг, шөнө өдөр, газар орны онцлог, мөн бусад объектив шинжтэй хүчин зүйлээс хамаарна.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох ажиллагааны үед гэмт хэрэг үйлдэж оргосон ялтан, гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж буй хүний эсэргүүцлийн шинж чанараас хамаарах ба биеийн хүчний албадлага нь хуулиар хамгаалагдсан эрх ашиг сонирхолд халдсан гэмт үйлдэл хийлгэхийн тулд албадаж буй субъектийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл юм.

4.Албадлага, эрхшээлд автсан хүн бусдын хүсэл зоригын үндсэн дээр гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийдэг бол гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох ажиллагаа нь хуульд заасан эрх үүргээ хэрэгжүүлэх, хууль бус үйлдэлтэй тэмцэх үүднээс хэрэгжүүлнэ.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ЭДЛЭХ ЭРХ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Т.Мөнхдалай

*Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн
ахлах багш, докторант*

Товч агуулга: Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны үед гэмт хэргийн нотлогдвол зохих байдлыг тогтоохдоо гэмт хэрэг үйлдсэнд сөрдэгдэж буй хүнийг сэжигтнээр тооцох, ял сонгож яллагдагчаас мэдүүлэг авахын өмнө түүнээс гэрчээр мэдүүлэг авч байгаа нь шүүн таслах ажиллагаанд хуулийг буруу ойлгож хэрэглэсэн, хууль зөрчсөн ажиллагаа тул хуулийн хийдэгдлийг арилгах нь хүний эрх, эрх чөлөөг хангахад онолын болон практикийн ач холбогдолтой асуудал болно.

Түлхүүр үгс: Хүний эрх, эрх чөлөө, хүлээх үүрэг, гэрч, сэжигтэн, яллагдагч, мэдүүлэг, мэдүүлэг авах, хуулийн хийдэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал нь нийгмийн хэрэгцээ, шаардлага, захиалгаар тасралтгүй хэрэгжих байнгын үйл явц бөгөөд энэ нь зөвхөн хуулийг шинээр батлах, зохих нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн найруулснаар хангагдчихдаг асуудал төдий бус нэгэнт батлагдсан хуулийг зөв ойлгож, тайлбарлан амьдралд хэрэгжүүлэх, онол болон практикийн уялдаа холбоо, харилцан хамаарлыг зөв тодорхойлж, шударгаар хангах явдал билээ. Өөрөөр хэлбэл батлагдан гарсан аливаа хуулийн онол, практик хэрэглээ бодит амьдралтай нийцсэн, шинэ онол, дэвшүүлсэн үзэл баримтлал нь үндэснийхээ өв соёл, уламжлалыг хадгалсан хуулийг хэрэглэх практик ажиллагаа бусад салбар хууль эрх зүйтэй харилцан шүтэлцэж уялдсан тохиолдолд уг хууль хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Үүнийгээ бид сайн хууль батлагдлаа гэж ярьдаг, бас магтдаг.

Энэ тухай криминологийн сонгодог сургаалийг үндэслэгч Чезаре Беккариа өөрийн бүтээлдээ “Хуулийг хүмүүс уншаад шууд ойлгохоор энгийн ойлгомжтой бичих⁶⁰” хэрэгтэй гэж тэмдэглэжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь Эрүүгийн хуулийн материаллаг хэм хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн байдаг тул хуулийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэхдээ түүний утга санаа, агуулгыг нэг мөр ойлгож сахин биелүүлэх нь хамгаас чухал болно.

Энэ нь “... Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно...” хэмээн Үндсэн хуулиндаа зарлан тунхагласан Монгол Улсын хууль, шүүхийн практикт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл заалтыг нэг мөр олгон хэрэгжүүлэх улмаар хуулийн гажуудал, хийдэл гаргахгүй байхад анхааран ажиллах шаардлагатай бөгөөд хуулийг хэрэглэх явцад орчин цагийн хуулийн хэлмэгдүүлэлт удаа дараа гарах хандлагатай байгаа талаар Академич С.Нарангэрэл “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь шинжлэх ухаанч биш, шинжлэх ухааны чанараа алдсан. Үүнээс болж иргэд их хохирно, цадиггаа алдсан замбараагүй явдал газар авна⁶¹” хэмээн тэмдэглэн хэлж байсанг дурьдах нь зүйтэй.

Бидний амьдран буй өнөөдрийн цаг хугацаа нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, оюун санааны амьдралд гарсан өөрчлөлт шинэчлэлтийн дагуу төр, түүний байгууллага, албан тушаалтнаас иргэний эрх, эрх чөлөөг аливаа нэг гэмт халдлагаас баталгаатай хамгаалж, зөрчигдсөн эрхийг нь тухай бүрд сэргээн эдлүүлэхэд чиглэсэн, дэлхий нийтийн жишигт нийцсэн хууль тогтоомжийг батлан гаргаж хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдсэн тэр цаг хугацаа юм.

⁶⁰ Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. /Г.Эрдэнэбатын орчуулга/. УБ. 2007.62 дах тал

⁶¹ “Хууль сахиулах үйл ажиллагаа онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын ЭШХурал дээр хэвлэл мэдээллийн ажилтнуудад өгсөн ярилцлагаас

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”⁶² гэж заажээ.

Гэсэн хэдий ч үйлдэгдэн гарсан “гэмт хэргийг түргэн шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх”⁶³ ажиллагааны явцад хуулийн хэрэглээнд ноцтой зөрчил гарч байгааг хуульч бид мэдсээр байж хуулийг буруу хэрэглэх, тэр явдалдаа нүд дасах болсон нь, хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг зөрчихөд хүргэсэн буруу жишиг тогтож байгааг өөрчлөх, хуулийн заалтыг нэг мөр, зөв ойлгож мөрдөх хэрэгтэй байна.

Чезаре Беккариа нэгэнтээ “Хуулийг тайлбарлах нь нүгэл, гэвч түүнийг тайлбарлахаас зайлсхийж бүрхэг тодорхойгүй хэвээр үлдээж байгаа нь мөн л нүгэл. Харь улсын хэлээр хуулийг бичиж нийтийн зүйлийг хувийн болгож, ард олныг өөрийн эрх чөлөөний хэмжээ хязгаарыг шүүн хэлэлцэх боломжийг хязгаарлаж, хувь хүний эрх чөлөөг хэдхэн хүнээс хамааралтай болгож байгаа нь энэ нүгэл туйлдаа хүрсний жишээ”⁶⁴ юм хэмээн тэмдэглэсэн байдаг.

Үүнийг тэрлэгч миний бие мөрдөгч, прокурор, шүүгчээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтыг Үндсэн хуулийн заалтанд нийцүүлэн хэрэглэх нь шударга ёс, хууль ёсны зарчмын илрэл болох талаар та бүхэнтэй өөрийн санаа бодлыг хуваалцахыг хүссэн болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болох сэжигтэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “7 дугаар бүлэгт заасан яллагдагчийн эрхийг эдлэхээр”⁶⁵ хуульчилсан нь учир дутагдалтай бөгөөд энэ талаар мөн хуулийн 31.11 дүгээр зүйлд “мөрдөгч нь баривчлагдсан сэжигтнээс мэдүүлэг авахын өмнө түүнд ямар хэрэгт холбогдуулан мэдүүлэг авч байгаа талаар танилцуулж, дараахи эрхийг тайлбарлана...гээд энэ хуулийн долоодугаар бүлэгт заасан бусад эрх”⁶⁶-ийг нэмж эдлэхийг заажээ.

Энэ нь зөвхөн баривчлагдсан сэжигтнээс мэдүүлэг авахад баримтлах хуулийн заалт бөгөөд шүүхийн зөвшөөрөлтэй буюу зөвшөөрөлгүйгээр баривчлагдаагүй боловч яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтнээр⁶⁷ тооцох, түүнээс мэдүүлэг авах ажиллагааг хуульчилж өгөөгүй, зөвхөн баривчлагдсан сэжигтний эрхийг хамгаалахаар хуульчилсан гэж үзэж болохоор байна.

Сэжигтэн, яллагдагч нарын эдлэх эрх, хүлээх үүргийн талаар ярихаас өмнө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болох субъектын тухай тодруулан авч үзье.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн харилцааны субъект, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид гэсэн ойлголт нэгэн ижил агуулгатай болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн харилцааны субъект гэдэг нь уг харилцаанд оролцож эрх эдэлж, үүрэг хүлээж буй этгээд гэсэн утгаараа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид нь гэмт хэрэг илрүүлэх, бүртгэх, мөрдөн байцаах, хэрэг шийдвэрлэх эрх бүхий байгууллага, түүний албан тушаалтан, өөрийн эрх ашиг сонирхлыг хамгаалж буй хүн, хуулийн этгээд, ашиг сонирхол нь хөндөгдөөгүй боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад тус дөхөм үзүүлж байгаа гэрч, хөндлөнгийн гэрч, шинжээч, мэргэжилтэн, барьцаа гаргач хүн, хуулийн этгээд байна.

Иймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар эрх зүйн байдал нь тодорхойлогдож улмаар эрх эдэлж, үүрэг хүлээж буй хүн, хуулийн этгээдийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч гэж нэрлэж болно.

⁶² Төрийн мэдээлэл. 1992 он.№1

⁶³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.1 дүгээр зүйл

⁶⁴ Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай./Г.Эрдэнэбатын орчуулга/УБ.2007. 8 дах тал

⁶⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 7 дугаар бүлэг “Яллагдагч”

⁶⁶ Дурьдсан хуулийн 31 дүгээр бүлэг, 31.11 дүгээр зүйл “Сэжигтнээс мэдүүлэг авах”, 1.8 дах хэсэг

⁶⁷ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ” хуулийн 31.2 дугаар зүйлийн 31.2.1 дэх хэсэг

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид нь эдлэх эрх, хүлээх үүргийн хэмжээ, уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болсон үндэслэл, гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл, шинж чанар, цаг хугацаагаараа харилцан өөр өөр байдаг. Тодруулбал: Барьцаа гаргагч хүн, хуулийн этгээд нь зөвхөн яллагдагчийг шүүх прокурорын дуудсан цагт ирүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байхаар өөрийн мөнгөн хөрөнгөө барьцаалж үүрэг хүлээнсээр уг харилцаанд оролцдог бол мэргэжилтэн, сурган хүмүүжүүлэгч, хөндлөнгийн гэрч нар тодорхой нэг мөрдөн шалгах ажиллагаа явуулахад уригдан оролцоно.

Яллагдагч. Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоогдсон журмын дагуу прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэж, уг тогтоолыг мөрдөгч сэжигтэнд танилцуулснаар яллагдагч гэсэн ойлголт бий болно. Гэтэл яллагдагч гэж ямар хүн болох талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэр томъёоны тогтоосон тодорхойлолтонд болон хуулинд тусгайлан утгыг тайлбарлаагүй байна. Харин 2002 оны ЭБШХуульд “энэ хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагч гэнэ⁶⁸” гэж тодорхойлсон байдаг.

Гэм буруугүйд тооцох (rule principle innocent/ly/ -принцип невиновный) зарчмын хүрээнд яллагдагч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахын тулд хуулиар өргөн эрх эдэлдэг. Үүний нэг тод илрэл бол шүүгдэгч /шүүхэд шилжсэн яллагдагчийг шүүгдэгч гэнэ/ нь шүүх хуралдааны ажиллагаанд оролцохдоо улсын яллагч, өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгчдийн нэгэн адил нотлох баримт гаргах, нотлох баримтыг шинжлэхэд оролцох, хүсэлт гаргах талаар тэгш эрх эдэлж байгаа явдал юм. /ЭХХШТ хуулийн 35.19 дүгээр зүйл/

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу яллагдагч нь дор дурдсан эрхийг эдэлнэ. Үүнд:

- Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх
- Яллагдагчаар татсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийдвэртэй танилцах
- Сонсгосон ялын талаар бичгээр болон амаар тайлбар гаргах
- Баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах
- Эх хэлээрээ болон өөрийн сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах, мэдүүлэг өгөхөөс татгалзах
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар шүүх, прокурор, мөрдөгчөөс энэ хуульд заасны дагуу өгөхийг зөвшөөрсөн мэдээллийг авах
- Яллагдагчийн өөрийнх нь хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, уг ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах хүсэлт гаргах
- Шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцах
- Яллагдагч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах, амаар, эсхүл бичгээр чөлөөтэй харилцах
- **Баривчлагдсан сэжигтэн**, цагдан хоригдсон яллагдагч, шүүгдэгч нь түүнийг баривчилсан, цагдан хорьсон нь хууль ёсны эсэхийг шүүхээр хянуулах, хууль бусаар **баривчилсан**, цагдан хорьсон бол суллуулахаар шүүхэд гомдол гаргах
- Яллагдагч хэргээ шүүхэд шилжүүлж, хэлэлцүүлэхийг шаардах, энэ талаар гомдол гаргах
- Анхан шатны болон давж заалдах шатны хуралдаанд оролцох
- Яллагдагч нь шүүх, прокурор, өмгөөлөгч, мөрдөгчийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах
- Бусад этгээдээс шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцах, түүнд тайлбар өгөх
- Мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах эрхтэй.
- Шүүх хуралдаанд эцсийн үг хэлэх

⁶⁸ Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг. 2002 он /2017 оны 05 сарын 18-ны өдрийн хурлаар хүчингүй болсонд тооцсон/

- Шүүхийн шийдвэрт гомдол гаргах
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах зэрэг болно.

Түүнчлэн Шүүхийн хуралдааны үед хуралдаан даргалагч нь шүүгдэгч нэг бүрээс яллах дүгнэлтийн агуулга ойлгогдож байгаа эсэхийг асуух, хэрэв шаардлагатай байвал шүүгдэгчид яллах дүгнэлтийн утгыг улсын яллагчаар тайлбарлуулан өгөх /ЭХХШТ хуулийн 35.8 дугаар зүйлийн 35.8.4 дэх хэсэг / болон давж заалдах шатанд хэргийг хянах үед шүүхэд шийтгэгдсэн буюу цагаатгагдсан этгээд тайлбар өгөх эрхийг /39.4 дүгээр зүйлийн 39.4.4 дэх хэсэг/ эдэлж байгаа нь тухайн яллагдагчийн хуулиар олгогдсон эрхээ бодитойгоор хэрэгжүүлэх хууль зүйн баталгааны нэг хэлбэр мөн.

Нөгөөтэйгүүр ял сонгосны дараа яллагдагчийг нэн даруй байцаах нь мөрдөгчийн үүрэг байдаг. Энэ нь юуны өмнө яллагдагчийн зүгээс өөрийгөө цаг алдалгүй өмгөөлөх, тэрчлэн цагаатгах буюу хариуцлагаа хөнгөрүүлэх зэрэг нөхцөл байдлын талаар баримт сэлт гарган өгч хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломжийг бүрдүүлж өгдөг. Ямар ч үед яллагдагч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, өөрийн гэм бурууг болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй. Мөн худал мэдүүлэг гаргах, мэдүүлэг өгөхөөс татгалзахад эрүүгийн хариуцлага хүлээхгүй. Тэрчлэн хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, хууран мэхлэх, хууль бус өөр арга хэрэглэх замаар тулган хавчиж, эрүүдэн шүүх аргаар яллагдагчаас мэдүүлэг гаргуулахыг хориглоно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.3 дугаар зүйлд зааснаар мөрдөгч, прокурор, шүүх нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ба шүүхийн баримт бичгийг яллагдагчийн өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар хэргийн материалтайгаа бүрэн танилцах эрхийг нь хангаж өгнө.

Шинжилгээ хийлгэх үед яллагдагч нь дор дурдсан тусгайлсан эрхийг эдлэнэ. Үүнд:

1. Шинжээчийг татгалзах
2. Нэр цохсон хүмүүсээс шинжээч томилохыг хүсэх
3. Шинжээчээр дүгнэлт гаргуулж авах ба нэмэлт асуулт тавих
4. Мөрдөн байцаагч буюу хэрэг бүртгэгчийн зөвшөөрлөөр шинжилгээ хийхэд байлцах,
5. Шинжээчийн дүгнэлттэй танилцах зэрэг эрхийг эдэлнэ.

Яллагдагч нь тодорхой эрх эдлэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохын зэрэгцээ хуулиар тогтоосон тодорхой үүрэг хүлээнэ. Тухайлбал: Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор түүнийг дуудсан цагт яллагдагч ирэх /12.1 дүгээр зүйл/, оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар, шуудангийн хаяг өөрчлөгдсөн, эсхүл өөрчлөгдөх гэж байгаа талаар мэдэгдэх /14.3 дугаар зүйлийн 14.3.2 дахь хэсэг/, түүнд хэрэглэсэн таслан сэргийлэх арга хэмжээний дагуу биеэ авч явах /14.2.2, 14.5.3, 14.6.5/, биед нь үзлэг хийх /23.2 дугаар зүйл/ харьцуулан шинжлэхээр хэв хэлбэр авах /27.9 дүгээр зүйл/ зэрэг тогтоолын заалтуудыг яллагдагч заавал дагаж биелүүлэх үүрэг хүлээнэ.

Түүнчлэн шүүгдэгч шүүх хуралдааны ажиллагаанд оролцогчдын нэгэн адил хуралдаан даргалагчаас шүүх хуралдааны дэг сахих талаар өгсөн шийдвэрт захирагдах /34.20 дугаар зүйл/ үүрэгтэй.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээхээс гадна цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж буй эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам, зааврыг дагаж биелүүлэх үүрэгтэй.

Сэжигтэн: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлийн дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ⁶⁹. Өөрөөр хэлбэл өөрт нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдэгдэгдсэн хүн, хуулийн этгээд байна.

Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй⁷⁰ дуудан ирүүлсэн сэжигтэнд танилцуулна.

⁶⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.2 дугаар зүйлийн 31.2.1 дэх хэсэг

⁷⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.4.18 дах хэсэг зааснаар “даруй” гэж боломжит богино хугацааг ойлгоно.

Сэжигтэнг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болохынх нь хувьд мөрдөн байцаалтын өмнө шатанд хэрхэн нэрлэж буй нэршлийн асуудал, хэрэг бүртгэлтийн шатанд түүний эдлэх эрх, хүлээх үүргийн тухайд хэрхэн хуульчлагдсан болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах үйл явцыг авч үзье.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.8 дугаар зүйлийн 30.8.1 дэх хэсэгт мөрдөгч нь гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авч хянан үзсэн даруйд:

1. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх
2. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурорт гаргах
3. Харьяаллын дагуу шилжүүлэх саналыг прокурорт гаргах шийдвэрийн аль

нэгийг хуульд заасан хугацаанд гаргаж прокурорт даруй мэдэгдэх үүрэгтэй⁷¹ гэжээ.

Мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл болох ба хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн талаар гомдол, мэдээлэл гаргасан, мөрдөгч прокурор нь гэмт хэргийн шинжийг өөрөө шууд илрүүлсэн буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт үйлдлийг таслан зогсоож, шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчилсан, гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийгөө илчилж ирсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээд хэн болох нь тодорхой байхад хэрэг бүртгэлтийн хэрэг нээх “тогтоолд хүн, хуулийн этгээдийн нэрийг холбогдуулан бичихийг хориглоно” гэж хуульчилсан.

Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг сэжигтнээр тооцсон тогтоол үйлдэх, тогтоолтой танилцуулах, сэжигтний эрх, үүргийг тайлбарлан өгч түүний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, сэжигтнээс мэдүүлэг авах зэрэг ажиллагааг бүрэн хуульчлаагүй, зөвхөн сэжигтнийг баривчласан даруй “Мирандагийн зарчим” гэх хэвшин тогтсон эрхийг тайлбарлан өгөх, дараа нь тэднээс мэдүүлэг авахаар хуульчилсан мэт харагдаж байна.

Тодруулбал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.11 дүгээр зүйлийн /Сэжигтнээс мэдүүлэг авах/ 31.11.1 дэх хэсэгт мөрдөгч баривчлагдсан сэжигтнээс мэдүүлэг авахын өмнө түүнд ямар хэрэгт холбогдуулан мэдүүлэг авч байгаа талаар танилцуулж, дараахь эрхийг тайлбарлана:

1. өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;
2. өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах;
3. өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах, өмгөөлөгч байлцуулан мэдүүлэг өгөх;
4. эх хэлээрээ, эсхүл өөрийн сайн мэдэх хэлээр мэдүүлэг өгөх;
5. орчуулагч, хэлмэрчийн туслалцааг авах;
6. мэдүүлэг өгөхөөс татгалзах;
7. мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрчээс татгалзах;
8. энэ хуулийн долоодугаар бүлэгт заасан /яллагдагчийн эрх/ бусад эрхийг

тайлбарлан өгнө гэжээ.

Мөн түүнчлэн өсвөр насны сэжигтэн, яллагдагч нараас мөрдөн байцаалтын шатанд хууль ёсны төлөөлөгч оролцуулан мэдүүлэг авахаар⁷² хуульчилсан бөгөөд “Арван зургаан насанд хүрсэн, арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлана⁷³” гэжээ.

Хуулийг хэрэгжүүлэх ажиллагааны хүрээнд дээрхи асуудлыг авч үзвэл “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт”-ын шатанд 16 насанд хүрсэн 18 насанд хүрээгүй гэрч, хохирогч нараас мэдүүлэг авахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлан өгч байгаа явдал нь санаатайгаар худал мэдүүлэг өгвөл хариуцлага хүлээлгэх тухай урьдчилан сануулсан анхааруулга гэж үзэх үндэслэл болохгүй боловч Эрүүгийн хуульд заасан “Гэрч хохирогч санаатайгаар худал мэдүүлэг өгөх” гэмт хэрэгт хариуцлага хүлээх субъект нь хуульд заасан 16 насанд хүрсэн, сэтгэцийн хувьд эрүүл, гэрч хохирогч байдаг нь материаллаг болон процессын хуулийн заалт зөрчилтэй байгааг харуулж байна.

⁷¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.8 дугаар зүйлийн 30.8.1 дэх хэсэг

⁷² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.5 дугаар зүйл, 18.5-ын 2.3 дах хэсэг

⁷³ Дурьдсан хуулийн 25.3 дугаар зүйл, 25.3.1 дэх хэсэг

Хэрэг мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд сэжигтэн, яллагдагчид хууль сануулж мэдүүлэг авах явдал, хэрэг бүртгэлтийн шатанд гэрчээс мэдүүлэг авах хэлбэрээр явагдаж байгаа хууль хэрэгжүүлэх ажиллагааны буруу практик хэлбэршин тогтоосон нь өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өмгөөлөгч авах “Мирандагийн зарчим” болон Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн явдал болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “... иргэн **өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх**, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. **Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно**” гэж заасан нь мөрдөн шалгах ажиллагаанд оролцогчдоос мэдүүлэг авах ажиллагааны эрх зүйн үндсэн гол зохицуулалтын нэг юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн⁷⁴ 30.7 дугаар зүйлийн 30.7.1-д “Мөрдөгч гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох шаардлагатай бол гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас гадна дараахь мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно” гээд мөн зүйлийн 30.7.1.3-д “...Гэрчээс мэдүүлэг авах” тухай заажээ.

Хуулийн дээрхи заалтыг мөрдөгч, прокурор, шүүгч мөрдөн шалгах болон шүүн таслах ажиллагааны явцад хэрэглэхдээ нэг мөр ойлгож хэрэгжүүлээгүйгээс хүний эрхийг зөрчих явдал удаа дараалан гарч байгаа гэж үзэж байна.

Үүнд тайлбар өгөхийн тулд хоёр, гурван тодорхой баримтыг авч үзье.

Шигтгээ.1

Эрүүгийн 180300054 тоот хэрэг яллагдагч Э овогтой Г-ийн 2018.02.23 өдөр яллагдагчаар мэдүүлэг өгсөн тэмдэглэлд /XX-59-р хуудас/

Асуулт: Танд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллагдагчаар татаж мэдүүлэг авах гэж байна. Иймд та сонсгож буй зүйл ангийг хүлээн зөвшөөрч байна уу?

Хариулт: Миний хувьд сонсгож буй зүйл ангийг хүлээн зөвшөөрч байна.

Асуулт: Та болсон асуудлын талаар тодорхой ярина уу?

Хариулт: **Гэрчийн мэдүүлгийг** үнэн зөв өгсөн учраас дахин мэдүүлэг өгөх шаардлага байхгүй гэж бодож байна.

Асуулт:**Гэрчийн мэдүүлэг** дээр нэмж ярих зүйл байна уу?

Хариулт: Байхгүй гэжээ.

Уг мэдүүлгийг мөрдөгч нь Э овогтой Г-д ял сонсгон яллагдагчаас мэдүүлэг авахдаа баримтжуулсан тэмдэглэлийн хэсэг бөгөөд Э овогтой Г-ээс гэрчээр мэдүүлэг авсан баримт хавтаст хэрэгт байхгүй байгаа явдал сонирхол татаж байна.

Шигтгээ.2

С овогтой О, М овогтой А нарт холбогдох Эрүүгийн 17060619 тоот хэрэгт хэргийн оролцогч⁷⁵ болох С.О, М.А нарыг хохирогчоор тогтоож мэдүүлэг авсан, мөн ял сонсгож яллагдагчаар татан мэдүүлэг авсан бөгөөд энэхүү ажиллагааны өмнө С.О, М.А нараас гэрч⁷⁶-ээр мэдүүлэг авчээ.

Шигтгээ.3

Эрүүгийн _____ тоот хэрэг яллагдагч Ц овогтой О-гийн 2018.10.31 өдөр гэрчээр мэдүүлэг өгсөн тэмдэглэлд “би хийсэн хэрэгтээ гэмшиж байна, өөр хэлж ярих зүйлгүй гэх мэдүүлэг /XX-26-р хуудас/ өгчээ.

Дээр дурьдсан баримтаас харахад яллагдагч, шүүгдэгч нарыг хэрэг бүртгэлтийн шатанд гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг шалгах явцдаа тус хэрэгт сэрдэгдэж байсан хүмүүсээс гэрчээр мэдүүлэг авсан байна.

⁷⁴ Төрийн мэдээлэл.2017 он. №3

⁷⁵ “оролцогч” гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг хэлнэ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2015 он.1.4 дүгээр зүйл, 1.4-ийн 1.13 дэх хэсэг.

⁷⁶ “гэрч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг хэлнэ. Дурьдсан хуулийн .9.6 дугаар зүйл,9.6-ийн 1 дэх хэсэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлийн 30.7.1.3-д заасан "...Гэрчээс мэдүүлэг авах" тухай заалт нь "гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүний гэмт хэрэг үйлдэхийг харсан, сонссон, түүний буруутай үйлдлийн талаар мэдэх хүнээс мэдүүлэг авах ажиллагаатай холбогдох заалт бөгөөд "гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн, эсвэл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан /Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.2 дугаар зүйл/ хариуцлага хүлээнэ"⁷⁷ гэжээ.

"Гэрчийн мэдүүлгийн үнэн худал нь яллагдагчтай найз нөхрийн буюу дайсагнасан харилцаатай алин болохоос илүүтэй шалтгаална. Гэрч нь батлаад сэжигтэн нь үгүйсгээд байгаа тохиолдолд аль аль нь гэм буруугүйд тооцогдох эрхтэй тул нэг гэрч хангалтгүй"⁷⁸ гэж Ч.Беккариа өөрийн бүтээлдээ тодорхойлсон байдаг.

Эндээс дүгнэлт хийхэд гэмт хэрэг үйлдсэн гэж сэрдэгдэж байгаа хүнээс гэрчээр мэдүүлэг авч байгаа нь өөрийн үйлдсэн хэргээ үнэн зөвөөр мэдүүлэх үүрэг хүлээлгэн, хэрэв худал мэдүүлэг өгвөл эрүүгийн хариуцлага хүлээхээр болж байна.

Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн хүн гэрчийн мэдүүлэг өгөхдөө мэдүүлэг өгөхөөс татгалзахгүйгээр, өмгөөлөгч авахгүйгээр мэдүүлэг өгөхөө илэрхийлж өөрийгөө гэмт хэрэг үйлдээгүй болгож, хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг зориуд өөрчлөн худал мэдүүлэг өгсөн нь ял сонгож яллагдагчаар татагдсаны дараа нотлох баримт, мэдээллээр тогтоогдвол, гэрч худал мэдүүлэг өгсөн асуудлаар нэмж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байна.

Нөгөө талаар тодорхой нэг гэмт хэрэг үйлдсэн хүн өөрт оногдуулах эрүүгийн хариуцлага, ялаас айж эмээх, оногдох ялаас зайлсхийх, ял завших зорилгоор гэрчийн мэдүүлэг өгөх явдал гардаг. Энэ тохиолдолд "Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх"⁷⁹, "Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх"⁸⁰ эрхтэй гэж заасан хуулийн заалт үйлчилнэ.

Гэмт хэрэг үйлдэж, ял сонсон яллагдагчаар мэдүүлэг өгсөн хүн, хэрэг бүртгэлтийн шатанд гэрчээр мэдүүлэг өгч байгаа явдал нь Монгол Улсын Үндсэн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд "Иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно"⁸¹, "Яллагдагч өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруугүйгээ, эсхүл хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээхгүй"⁸², "Яллагдагчийг өөрийнх нь эсрэг мэдүүлэг авахаар албадахыг хориглоно"⁸³ гэсэн хуулиудын заалттай зөрчилдсөн хэм хэмжээг агуулж байна.

Мөн түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэр томъёоны тодорхойлолтод⁸⁴ "оролцогч гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг ...", "бусад оролцогч гэж гэрчийг ..." ойлгоно хэмээн тусгайлан тайлбарласан ба мөрдөн шалгах болон шүүн таслах ажиллагаанд оролцогч нэг бүрийн эрх үүрэг нь өөр өөр байхаар хуульчилсан байна.

Аливаа нэг хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж сэрдэн мэдүүлэг авахад өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, дуугүй байх, өмгөөлөгч авах эрхийг нь заавал урьдчилан танилцуулах, уг эрхээ эдлэн мэдүүлэг өгөхөөс татгалзсан тохиолдолд мэдүүлэг авах ажиллагааг даруй зогсоох бөгөөд түүний үйлдсэн хэрэг нь хэрэгт авагдсан бусад нотлох баримтаар хангалттай нотлогдохгүй, эргэлзээ гарвал сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанг ашигтайгаар шийдвэрлэх⁸⁵ нь гэм буруугүйд тооцох зарчмын хэрэгжилтийг хангах үндэс болно.

Сэжигтэн, яллагдагчаар тооцохын өмнө түүнээс худал мэдүүлбэл эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж хууль сануулан гэрчээр мэдүүлэг аваад дараа нь уг мэдүүлгийг

⁷⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2015 он. 9.6 дугаар зүйл, 9.6-ийн 4 дэх хэсэг.

⁷⁸ Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. /Г.Эрдэнэбатын орчуулга/УБ.2007. 19 дэх тал

⁷⁹ Дурьдсан хуулийн 9.6 дугаар зүйл, 9.6-ийн 5 дах хэсэг.

⁸⁰ Дурьдсан хуулийн 9.6 дугаар зүйл, 9.6-ийн 6 дах хэсэг.

⁸¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг

⁸² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.УБ. 2015 он. 7.4 дүгээр зүйл, 2 дах хэсэг.

⁸³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.УБ. 2015 он. 7.4 дүгээр зүйл, 3 дах хэсэг.

⁸⁴ Дурьдсан хуулийн 1.4 дүгээр зүйл.

⁸⁵ Дурьдсан хуулийн 1.15 дугаар зүйл.

нотлох баримтын эх сурвалж болгон сэжигтэн, яллагдагч нараас мэдүүлэг авч тэдний гэм бурууг тогтоож байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд ноцтой алдаа мөн агаад ингэж хууль бусаар цуглуулсан нотлох баримт нь нотлох чадвараа алдах бөгөөд уг баримт нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болох учиргүй.

Сэжигтэн, яллагдагчийн өөрийнхөө гэм бурууг хүлээн зөвшөөрсөн мэдүүлэг нь хэргийг шууд бөгөөд бүрэн дүүрэн нотлох баримт болохгүй, шүүх хэргийг бүх талаас нь бүрэн бодитой шийдвэрлэхийн тулд бусад нотлох баримтад тулгуурлахыг зорьдог хэдий ч мэдүүлгэн нотлох баримт зарим хэргийг нотлох ажиллагаанд голлох байр суурьтай байдаг.

Дээрхи тохиолдолд сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах ажиллагаа эрүү шүүлт, хууль бус дарамт, шахалт, ятгалга, хууран мэхлэлтээс ангид, гагцхүү хуулийн дагуу явагдаж, тэдний бодит мэдүүлгийг бэхжүүлж авах баталгааг бүрдүүлэх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нэг чухал хамгаалалт болно.

Эцэст нь дүгнэж хэлэхэд өмнөх хуульд иргэдээс тайлбар авах, гаргуулах зэрэг хойшлуулшгүй ажиллагаа явуулсны дараахь эрүүгийн хэрэг үүсгэж дахин хэргийн оролцогчоор тогтоон мэдүүлэг авах нь чиргэдэл үүсгэдэг байсныг шинэ хуулиар халж анхнаас нь хууль сануулан мэдүүлэг авснаар шүүхийн шатанд нотлох баримтаар үнэлэгдэх боломжийг бүрдүүлсэн гэж үздэг нь сэжигтэн, яллагдагчаас гэрчээр мэдүүлэг авах ёстой гэсэн буруу практикийг тогтоох үндэс болжээ.

Санал

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлийг засаж сайжруулах талаар дараах саналыг дэвшүүлж байна.

1. Хуулийн хийдэгдлийг арилгахын тулд хэрэг бүртгэлтийн шатанд гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл гаргах ажиллагааг шалгахад хэрэгт сэрдэгдэж буй хүнээс гэрчээр мэдүүлэг авдаг зөрчлийг арилгуулах, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах
2. Хууль тогтоох байгууллагаас хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхийн тулд хуулинд зохих тайлбар хийх
3. Гэмт хэрэг үйлдсэн гэх хангалтай үндэслэл байгаа үед уг хүнийг сэжигтнээр тооцож, мэдүүлэг авах зохицуулалтыг хуульд нэмэлтээр оруулах
4. Сэжигтэний эрхийг тайлбарлан өгөхдөө нэмж яллагдагчийн эрхийг нэмж тайлбарлаж буй хуулийн заалтыг хасах
5. Баривчлагдсан сэжигтнээс мэдүүлэг авна, баривчлагдаагүй бол мэдүүлэг авахгүй гэх хуулийн хийдлийг засах
6. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн зөрчлийг арилгах үүднээс гэрч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн тусгай субъект болохын хувьд Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд заасан “Худал мэдүүлэх” гэмт хэрэг үйлдсэн хүний хэрэг хариуцах хуульд заасан насны доод хязгаар 16 нас байсныг 18 нас болгон өөрчлөх зэрэг болно.

ХҮНИЙ АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНД, СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

*Ч.Отгонсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн
сургуулийн цэргийн хэргийн
тэнхимийн ахлах багш, докторант,
хошууч*

Товч агуулга: Энэ илтгэлээр хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохиролд үнэлгээ хийж буй үйл ажиллагааны эрх зүйн өнөөгийн орчин, тулгамдаж буй зарим асуудлын судалж, цаашид олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох арга замыг эрэлхийлсэн зарим дүгнэлт хийж, санал дэвшүүлсэн.

Түлхүүр үг: Хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа, хохирол үнэлгээ.

Манай улсад үнэлгээний үйл ажиллагаа үүсч хөгжөөд 20 гаран жилийн хугацаа өнгөрч байна. Хувийн хэвшлийн төлөвшил, өмчийн харилцааны эрх зүйн өөрчлөлтийг даган үнэлгээний үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж байгаа тул 2010 онд Хөрөнгийн үнэлгээний тухай Монгол Улсын хууль батлагдаж, үнэлгээний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байдаг. Мөн нөгөө талаас хараат бус үнэлгээний үйл ажиллагаа нь хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлын үнэлгээний чиглэлээр Эрүүгийн хуулийн гол үзэл санаа болох хохирогчийн эрхийг хангах, хохирол хор уршгийг арилгахад үнэлгээ нь гүйцэтгэх чухал үүрэгтэй тул энэ чиглэлээр эрүүгийн эрх зүйд орсон өөрчлөлтүүд хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны зориулалттай үнэлгээг сайжруулах, хөгжүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Виктимологи нь гэмт хэргийн хохирогч, гэмт хэрэгт хохирох эрсдэл, түүний гэмт хэрэгт өртөмтгий чанар, гэмт хэрэгт хохирох учир шалтгаан, нөхцөл, тодорхой гэмт хэрэгт хохирохоос урдъчилан сэргийлэх тухай криминологийн шинжлэх ухааны нэг институц мөн.

НҮБ-ийн Ерөнхий ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29–ний өдрийн 40/34 дүгээр шийдвэрээр “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаар урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал” батлагдсан нь дэлхийн улс орнуудад виктимологийн шинжлэх ухаан хөгжих гол үндэслэл болсон.

Дэлхийн улс орнууд хохирогчийг хамгаалах үзэл санааг амьдралд хэрэгжүүлээд хагас зуун жил болжээ. Харин манай улсын хувьд энэ асуудалд анхаарлаа хандуулан урьдчилан сэргийлэх тогтолцоогоо эргэн харах шаардлага тулгараад байна.

АНУ, Герман, Япон зэрэг орнуудад хохирол судлалын шинжлэх ухаан тодорхой хөгжлийг олж байгаа бөгөөд сэтгэл зүйн болон хүмүүжлийн ажлын тусгай лаборатори бүхий Хууль зүйн шинжилгээ судалгааны болон Цагдаагийн шинжлэх ухааны институтиудад виктимологийн судалгаа шинжилгээний ажлуудыг хийж, хохирогч бие хүн, тэдгээрийн зан үйл, тэдэнд үүссэн хохирол, эрх зүйн зөрчигч ба хохирогчийн харилцаа холбооны хэлбэрүүдийг судалж байна. Тодорхой үе шаттайгаар олон улсын семинар, симпозиум, конгресс зохион байгуулагдаж, гэмт хэргийн хохирогчийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт, тэдэнд үзүүлэх тусламжийн талаар хууль тогтоомжийг улам боловсронгуй болгож байна.

Манай улсын эрдэмтэн судлаачид онолын болон практикийн зарим нэгэн туршлага хуримтлуулсан бөгөөд виктимологийн үзэл баримтлалын талаар зарим бүтээл бичиж, гэмт хэргийн хохирогч-бие хүн, тэдний зан үйлийн талаар судалгаа хийж байна.

Гэмт хэргийн хохирогч, хохирол

Улсын хэмжээнд 37173 иргэн, 86 хуулийн этгээд хохирсон байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол түүнд хамаарах статистикийг харуулбал.

Хохирогч бүгд		Иргэн		Үүнээс				Хуулийн этгээд		Учирсан хохирол бүгд /сая.төгрөг/		Нөхөн төлүүлсэн байдал /сая.төг/	
				Нас барсан		Гэмтсэн							
2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017
			7				7						

2777	3725	27689	371	880	1129	1125	105	84	86	16290	198073	4396	7450
3	9		73			7	10			9.4	.2	4.0	8.2

Прокурорын байгууллагын мэдээнээс үзвэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 онд 198.1 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 74.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос учирсан хохирол 35.2 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирол 30.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн статистик мэдээнээс үзвэл амь хохирсон хүний тоо өмнөх оноос 63 хүнээр буюу 11,9%-иар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас 663 хүн хүнд гэмтэл, 904 хүн хүндэвтэр гэмтэл, 3105 хүн хөнгөн гэмтээсэн бөгөөд 2016 онтой харьцуулбал хөнгөн гэмтэл авсан хүний тоо 2,5 дахин өсжээ.

Улсын хэмжээнд 2017 онд шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нийт хэмжээ 84.8 тэрбум төгрөг байна. Үүнээс улсад учирсан хохирол 3,8 тэрбум төгрөг аж ахуй нэгжид учирсан хохирол 11 тэрбум 955 сая төгрөг, иргэнд учирсан хохирол 69.3 тэрбум төгрөг байна гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг 2016 онтой харьцуулбал 69.5 тэрбум төгрөг буюу 5,6 дахин өссөн дүнтэй гарсан байна.

Эрүүгийн хуулийн гол үзэл санаа болох хохирогчийн эрхийг хангах, хохирол хор уршгийг арилгах талаар зохицуулсан Эрүүгийн хуулийн 2.5-р зүйл гэмт хэргийн хохирол, хор уршиг, Эрүүгийн хуулийн 6.7-р зүйл болох Гэм буруугаа хүлээсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаарх зүйл, хэсэг заалтууд нь хэрэгжиж эхэлсэн байна.

Гэмт хэргийн хохирлын үнэлгээг тооцож буй практик

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн хохирлын үнэлгээг бодитой тогтоох шийдвэрлэх, нөхөн төлүүлэх нь хууль зүйн болон нийгмийн тулгамдсан асуудлын нэг мөн бөгөөд эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн хохирогчийн үндсэн эрхийн нэг бол учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх юм. Хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны үндэс нь хохирлын төрөл, хэмжээ, түүнийг үнэлэх асуудал байдаг. Эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирол төрөл, шинж чанар, хэмжээг тогтоох түүнийг зөв үнэлснээр хохирогчийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх эрх хангагдана.

Хохирол шаардсан хэргүүдээс гэм хэргийн зүйлчлэл нь шууд нөлөөлдөг онцлогтой бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 80 гаруй зүйл, хэсэгт давхардсан тоогоор хохирлын хэмжээг шаардсан материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргүүд байна.

Иймд хохирлын хэмжээг мөнгөн илэрхийллээр зөв тогтоох нь хэргийн зүйлчлэлд чухал байхаас гадна гэм хэргийн улмаас хохирол хүлээсэн хохирогчийн хохирлын хэмжээ үнэн зөв тогтоогдож, хохирол нөхөн төлүүлэх эрх хангагдах ач холбогдолтой юм.

Манай практикт гэм хэргийн улмаас үүссэн хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоохдоо:

1. Шинжээчийн дүгнэлт /шүүх эмчийн, криминалистикийн, аудитын, нягтлан бодох бүртгэлийн гэх мэт/
2. Үнэлгээний комиссын тодорхойлолт
3. Сум, багийн Засаг даргын тодорхойлолт
4. Татвар, гааль, мэргэжлийн хяналтын байцаагч нарын акт
5. Зардлын баримт
6. Байгууллагын дансанд тусгагдсан үнэлгээ
7. Даатгалын үнэлгээ зэргийг нотолгооны эх сурвалж болгож байна

Гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын хэмжээг тогтоож буй байдлыг авч үзвэл:

Үнэлгээний комисс:

Эрүүгийн хэргийн материалаас судлан үзэхэд эд хөрөнгийн хохирлын хэмжээг ихэвчлэн аймаг, дүүргийн Засаг даргын дэргэдэх Үнэлгээний комисс тогтоодог бөгөөд комиссын бүрэлдэхүүн нь үндсэн ажил үүргийнхээ хажуугаар эд хөрөнгө үнэлэх ажлыг гүйцэтгэдэг, эд зүйл буюу хөрөнгө үнэлэх тусгай зөвшөөрөлгүй хүмүүсээс бүрдэж байна. Энэ эв эд хөрөнгийн хохирлын үнэлгээг бодитой, зөв хийж буй гэдэгт эргэлзээ төрүүлэхээс гадна хохирлын хэмжээг бодит бусаар тогтоох, хохирогчийн хохирол нөхөн төлүүлэх эрх зөрчигдөхөд хүргэж байсан.

Үүнээс гадна Үнэлгээний комисс гэх ойлголт, нэр томъёо ЭХХШХ-д байхгүй, эрүүгийн хэрэгт эд хөрөнгийн хохирлын хэмжээг үнэлэх эрх хэмжээгүй этгээд байх бөгөөд эд хөрөнгийн хохирлын үнэлгээг ямар аргаар, юуг үндэслэж, хэрхэн үнэлж байгаа нь тодорхой бус байна. Эд хөрөнгийг үнэлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу бус, комиссын гишүүд өөрийн үзэмжээр үнэлгээ хийж, хохирогчийн үнийн саналыг ихэвчлэн бууруулж үнэлдэг, бууруулсан үндэслэлдээ тайлбар хийдэггүй байдал нь хохирогчийн хохирлоо үнэн зөв бодитой нөхөн төлүүлэх эрх зөрчигдөхөд хүргэж байгаагаас гадна гэмт хэрэг үйлдэж буй хүмүүсийг эрүүгийн хариуцлагаас мултрах ял завших нөхцөлийг бүрдүүлж байна. Үнэлгээ хийх эд хөрөнгөнд үнэ тогтоох ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага иргэд хийж байх нь бодит үнэ тогтоох нөхцөл бүрдэнэ.

Иймд гэмт хэргийн халдлагад өртсөн эд хөрөнгөнд буюу гэмт хэргийн улмаас үүссэн эд хөрөнгийн хохирлын тогтоодог мэргэжлийн байгууллагыг байгуулан ажиллуулах шаардлагатай. Мөн татвар гааль мэргэжлийн хяналтын байцаагчийн акт зардлын баримт байгууллагын дансанд тусгагдсан үнэлгээ зэргийг эх сурвалж болгон эд хөрөнгийн хохирлын хэмжээг тооцож буй байдал нь хууль зүйн болон онолын хувьд оновчтой эсэхэд дүгнэлт хийж хохирлын тогтоох зүйлсийг хуульчлан тогтоох нь зүйтэй. Хохирогч нь гэмт хэргийн улмаас үүссэн эд хөрөнгийн хохирлыг нэхэмжлээд зогсохгүй мөн бие махбодийн болон сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх эрхтэй.

Эрх зүйн зөрчигч түүний төлөө хариуцлага хүлээж байгаа этгээдээс хор уршиг арилгуулах эрхийн эд хөрөнгийн агуулга нь:

- Эд хөрөнгөө буцаан авах эрх
- Үрэгдсэн эд хөрөнгөө нөхөн төлүүлэх эрх
- Гэмт хэрэгт хохирох явдалд учирсан зардлыг нөхөн төлүүлэх эрх
- Үйлчилгээ авах эрх /гэмт хэргийн улмаас гэмтсэн эрүүл мэнд эд хөрөнгийн байдлаа нөхөн сэргээх /
- Зөрчигдсэн эрхээ сэргээлгэх эрх
- Сэтгэл санааны хохирлоо арилгуулах эрх зэргээс бүрдэнэ.

ЭХХША дахь иргэний нэхэмжлэл нь иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө болон эд хөрөнгөтэй холбоотой үүссэн харилцаа буюу иргэний эрх зүйн зохицуулах зүйлд хамаарах учраас /иргэний болон хөдөлмөрийн маргаанаас үүссэн нэхэмжлэлийг хангах ажиллагааны журам адил учраас/ энэ асуудлыг Иргэний хууль Хөдөлмөрийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж зарим талаар Монгол Улсын олон улсын гэрээний журмыг баримтлах шаардлага гарна.

Хүний биеийн эрүүл мэндийн хохирлыг Хууль зүйн дотоод хэргийн асуудал болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайд нарын хамтарсан тушаалаар батлагдсан Гэмтлийн зэрэг тогтоох журмын дагуу үнэлж байгаа билээ. ШШҮХ-ийн тайлангийн мэдээлэлд дурдсан сүүлийн гурван жилийн дунджаар үзвэл нэг жилд 30100 орчим хүн гэмтлийн зэрэг тогтоолгох шинжилгээ хийлгэхээр ханддагаас 16400 хүн хөнгөн гэмтэл, 2300 хүн хүндэвтэр гэмтэл, 1260 хүн хүнд гэмтлийн зэрэг тогтоолгожээ. Гэтэл эрх зүйн шинэтгэлийн үйл явц шинээр батлагдсан хууль тогтоомжийн үзэл энэхүү журмыг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд цаашид хүний биеийн эд эрхтний нөхөн төлбөрийн үнэлгээг бий болгох шаардлагатай. ОХУ-ын одоогийн шүүхийн практикт А.М. Эрделевский-н зохиосон хүснэгтийг шүүхийн практикт хэрэглэж байна. Энэ нь цаашид гадаад нийтлэг жишиг тогтоох ач холбогдолтой болно⁸⁶.

Хууль эрх зүйн орчны хувьд Иргэний тухай хуульд хүний амь нас, эрүүл мэнд хохирлыг төлүүлэх тухай 23 заалт, Эрүүгийн холбогдох хууль тогтоомжуудад эрүүл⁸⁷ мэнд болон амь настай холбоотой харилцааг зохицуулсан нийт 65 заалт орсон байна. Тухайлбал, Иргэний тухай хуулинд сэтгэл санааны хохирол энэ хуулийн 21 дүгээр зүйл Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах; 511 дүгээр зүйл Эдийн бус гэм хорыг арилгах “хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг

⁸⁶ Хууль дээдлэх ёс. Цуврал 66 Дугаар 1

⁸⁷ Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016, 2017

харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох” тухай заалтууд байна. Дээрх хууль тогтоомжуудад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын үнэлгээ тогтоох харилцааг тодорхой түвшинд эрх зүйн зохицуулалтаар тусгасан байна. Харамсалтай нь бодит амьдрал дээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлын үнэлгээг тогтоох тогтолцоо учир дутагдалтай, эрх зүйн орчин бүрэн шийдэгдээгүй байна.

Одоогийн байдлаар Монгол Улсад энэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил төдийлөн хийгдээгүй, гадаадын зарим улс орнуудын туршлагыг судлах зэргээр л хязгаарлагдаж байгаа ба энэхүү салбарын хувьд харьцангуй шинээр судлагдаж нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн судлах зэрэг асуудлуудыг нэн яаралтай шийдвэрлэх хэрэгтэй болж байгаа билээ. Мөн түүнчлэн УИХ-аас 2010 онд Хөрөнгийн үнэлгээний тухай хууль батлагдан гарч, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хэдий ч хууль сахиулах байгууллагуудын үндсэн үйл ажиллагаанд нэвтрүүлээгүй байгаагийн улмаас гэмт хэргийн улмаас учирсан хохирлын дүгнэлтийг дээрх салбарын байгууллагууд харилцан адилгүй өөр өөрөөр гаргадаг жишиг байна.

Энэ чиглэлээр судалгааны шинжилгээний ажлыг түлхүү явуулахын зэрэгцээ Монголын криминалистикийн холбооноос хэрэгжүүлэх гэж буй “Гэмт хэргийн хохирлын үнэлгээний үндэсний тогтолцоо бүрдүүлж чадавжуулах” судалгааны үе шаттай төслийн ажилд судлаачийн зүгээс оролцож, гэмт хэргийн улмаас учирсан эдийн засгийн эд хөрөнгийн хохирлыг үнэлгээг тогтоох асуудлыг судлахаар төлөвлөж байна.

Хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээ, оршуулга, тээврийн зардлын баримт зэргийг харгалзан хохирлыг тогтоож байна. Эрүүгийн хэргийн хохирогчийн хувьд бодит хохирлыг шүүх шийдвэрлэж байгаа ч эдийн бус хохирлын хэмжээг хэрхэн тооцох нь тодорхойгүй байна. Уг нь хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуульд сэтгэл санааны хохирлыг барагдуулах заалт шигтгэсэн.

Зөвхөн хуульд холбогдох заалтыг тусгаснаар сэтгэл санааны хохирлыг тооцох, барагдуулах эрх зүйн орчин бүрдсэн гэвэл өрөөсгөл ойлголт.

Эрх зүй өндөр хөгжсөн зарим улс оронд гэм буруутай этгээдээс сэтгэл санааны хохирлыг нэхэмжилж барагдуулах, гэм буруутай этгээд тогтоогдоогүй бол эд хөрөнгө бие эрхтэнд учирсан хохирлоос гадна сэтгэл санаанд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлж барагдуулдаг тогтолцоо байдаг. Тухайлбал, Их Британи улс бага зэргийн сэтгэл санааны хохирлыг 1290- 4900 фунт стерлингээр үнэлдэг байна. Харин дунд зэргийнх бол 4.9-45 мянга, хүнд зэргийн сэтгэл санааны хохирол учирсан хэмээн үзвэл 45-96 мянга хүртэлх фунт стерлингээр үнэлж, тооцдог аж. Эдгээрийг төгрөгт хөрвүүлэн тооцож үзвэл сэтгэл санааны хохирлыг 4-300 сая хүртэлх төгрөгөөр үнэлдэг байна. Хойд хөршийн Иргэний хуульд “Сэтгэл санааны хохирол гэдэг нь иргэний хувийн эдийн бус эрх, эсхүл түүнд хамааралтай эдийн бус баялгийг зөрчсөн үйлдлийн улмаас учирсан болон бусад хуульд заасан тохиолдолд биеийн болон сэтгэл санааны зовлон шаналал байна” хэмээн томъёолжээ.

Сэтгэл санааны хохирол, амь нас болон эд хөрөнгийн хохирлыг үнэлж буй байдал

Сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр төлөх ба хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналалын шинж чанар, хохирол учруулсан нөхцөл байдал зэргийг харгалзан нөхөн төлбөрийн хэмжээг шүүх тогтоож байхаар хуульчилсан байна.

Харин урд хөршийн хувьд эдийн бус гэм хорыг тооцох аргачлалгүй ч тухайн хэргийн нөхцөл байдлыг харгалзан шүүхээс тогтоодог аж. Германы хувьд сэтгэл санааны гэм хорыг арилгахад тусгай аргачлал боловсруулсан бөгөөд үүнийг шүүх шийдвэр гаргахдаа мөрдлөг болгодог байна.

Хохирлын хэмжээг тодорхойлохдоо хариуцагчийн гэм буруу, хохирогчид бий болсон сөрөг үр дагавар, хариуцагчийн эд хөрөнгийн байдал зэргийг харгалзан үздэг. Өмнөд Солонгосын хувьд сэтгэл санааны хохирлын суурь төлбөрийг 80 сая вонноор үнэлдэг аж. /Монголоор 176.000.000/ сая төгрөг.

Хүний эрхийн хуульч М.Ичинноров нэгэн илтгэлдээ “Хүний алтан амийг мөнгөөр үнэлэх боломжгүй ч мөнгөн дүнгээр илэрхийлдэг систем байдаг. Хүний амь насны эдийн засгийн үнийг тооцохдоо дундаж наслалтаас насыг нь хасаж, дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хүнд ногдох тоогоор үржүүлж гаргадаг жишиг бий. Үүгээр бодоход монгол хүний эдийн

засгийн үнэ цэнэ 150-300 сая орчим төгрөг болохоор байна. Гадаадын зарим оронд 50, 125 мянган ам.доллараас эхлээд долоон сая ам.доллараар тооцож байна” хэмээн дурджээ.

Дээрх байдлаар Олон улсын судалгааны мэдээллүүд ихээхэн байгаа боловч Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос сэтгэл санааны хохирлын хэмжээг тооцох аргачлалыг 2016 онд боловсруулжээ.

Аргачлалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар товч харуулахад:

- Алдагдсан боломжийн үнэлгээ
- Сэтгэл санааны хохирлын үнэлгээ
- Шууд зардал буюу баримтаар нотлогдох хохирлуудыг багтаан эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол үнэлгээг тооцоолохоор тогтоосон.

Алдагдсан боломжийн хохирлын үнэлгээ (АБХУ):

Статистик мэдээнээс Монгол хүний дундаж наслалтын мэдээллийг авч, тэтгэвэрт гарах нас, ажил эрхлэх насны зөрүүгээр идэвхтэй ажиллах жилийг тооцоолно. Тухайн хохирсон хүний ажлаас гарсан өдрөөс тэтгэвэрт гарах өдрийг хүртэл тооцоолж нийт хэдэн өдөр ажиллах боломжоо алдсаныг сард (АБА) шилжүүлж сарын цалингаар (СЦ) үржүүлэн нийт цалингийн алдагдлыг гаргана.

$$\text{АБХУ}=\text{АБА сарын тоо}*\text{СЦ}$$

Шууд зардал буюу шууд хохирлын үнэлгээ (ШЗХУ):

Шууд зардлыг тухайн хохиролтой холбогдон гарсан баримтаар нотлогдох эмчилгээний зардал (ЭЗ) болон бусад баримтаар нотлогдох зардлуудын (ББНЗ) нийлбэрээр тооцоолно.

$$\text{ШЗХУ}=\text{ЭЗ}+\text{ББНЗ}$$

Сэтгэл санааны хохиролын үнэлгээ (ССХУ):

Сэтгэл санааны хохирол тооцооллыг мөнгөн дүнгээр илэрхийлэхэд дотоодын нийт бүтээгдэхүүнийг (ДНБ) хүн амын тоонд харьцуулан нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг (НХНДНБ) гаргаж үржүүлэгчээр (МХҮХ-ноос гаргасан 5.5) үржүүлэн хүний амь насны үнэлгээг гарна. Гарсан тоог хуанлийн хоногт (ХХ) харьцуулахад нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэлгээ(НӨССХСҮ) гарна.

Хохирлоос үүссэн үйлдэл байдал	Итгэлцүүр
Сэхээн амьдруулах	5.0
Мэс засал, хагалгаа	4.0
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн	2.0
Зовиуртай байсан	2.0
Энгийн зовиур	1.0
Хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар	0-1.0

Энэхүү үржүүлэгч болон итгэлцүүрийг МХҮХ-ноос боловсруулан гаргасан болно.

Сэтгэл санааны хохирлын нийт үнэлгээг гаргахад эмнэлэгт хэвтсэн хоногийг (ЭХХ) дээр тооцоолон гаргасан сэтгэл санааны хохирол тооцох нэг өдрийн суурь үнэлгээг холбогдох итгэлцүүрээр үржүүлэн гаргана. Бусад дээрх итгэлцүүрт хамаарах хохирол үүссэн байвал энэ аргачлалаар тооцоолон гаргах боломжтой байна.

$$\text{ССХУ}=(\text{НХНДНБ}*\text{Үржүүлэгч})/\text{ХХ}*\text{ЭХХ}*\text{итгэлцүүр}$$

Дээрх алдагдсан боломжийн хохирлын үнэлгээ, сэтгэл санааны хохирлын үнэлгээ, шууд зардлуудын хохирлын үнэлгээний нийлбэр нь эрүүл мэнд, сэтгэл санааны нийт хохирлыг (ЭМССХУ) тооцоолох үнэлгээ болж байна.

$$\text{ЭМССХУ}=\text{АБХУ}+\text{ШЗХУ}+\text{ССХУ}^{88}$$

Дүгнэлт

⁸⁸ Ослын улмаас учирсан хохирол үнэлгээ. 2015, С 125-131

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн хохирлын үнэлгээг бодитой тогтоох шийдвэрлэх, нөхөн төлүүлэх нь хууль зүйн болон нийгмийн тулгамдсан асуудлын нэг мөн бөгөөд эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн хохирогчийн үндсэн эрхийн нэг бол учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх юм. Хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны үндэс нь хохирлын төрөл, хэмжээ, түүнийг үнэлэх асуудал байдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирол төрөл, шинж чанар, хэмжээг тогтоох түүнийг зөв үнэлснээр хохирогчийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх эрх хангагдана.

Санал

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг барагдуулах талаар санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас эд хөрөнгөнд учирсан хохирлыг шинжээчээр тогтоолгох заалтыг хэрэгжүүлэх шинжээчийг гэмт хэргийн хохирлыг тогтоох, үнэлгээ хийх талаар ур чадварыг нэмэгдүүлэх;
2. Монгол Улсад гэмт хэргийн хохирол нөхөн барагдуулах үндэсний тогтолцоог бий болгох. Энэ нь хохирлын сангийн тухай хууль хэлбэртэй байх боломжтой бөгөөд өнөөгийн байдлаар гэмт хэрэг зөрчлийн торгууль хүүгийн орлого нь орон нутгийн төсвийн бус орлогод төвлөрч байгааг өөрчилж хохирлын сан бий болгох энэ сангаар дамжуулан гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох тухай зохицуулалт хийх;
3. Эрүүгийн хуулийн үзэл баримтлалыг анхаарч хүний бие махбодын эд эрхтний үнэлгээг МХҮХ-ноос гаргасан аргачлалыг суурь болгон хөгжүүлэн ашиглах түүнийг боловсронгуй болгоход мэргэжлийн холбооны судалгааны баг ажиллах;
4. Шүүх эмнэлгийг сэтгэц гэм судлалын шинжлэх ухаантай хослуулан хөгжүүлж хүний сэтгэл санааны хохирол тооцох дээрх аргачлалыг жишиг болгон, хэрэгжүүлэх шаардлагатай байна;

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном. 2016
2. Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном. 2017
3. Хууль дээдлэх ёс. Цуврал 66 дугаар 1
4. Ослын улмаас учирсан хохирол үнэлэгээ 2015 с 125-131

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ОЛОН ХҮНД НӨЛӨӨЛӨХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ АРГАЧЛАЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

*Ш.Чулуун
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Албаны тусгай бэлтгэлийн
тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд
хурандаа*

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед түүнийг албадан тараах болон хууль бусаар зохион байгуулж байгаа жагсаал цуглааныг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан тараах үедээ олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй байна.

Олныг хамарсан үймээн самуун, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх үйл ажиллагаа нөхцөл байдлыг нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэнэ.⁸⁹

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг Цагдаагийн албаны тухай хуулинд⁹⁰ дараах тохиолдолд хэрэглэнэ гэж заажээ. Үүнийг тодотгон авч үзвэл:

- Цагдаагийн алба хаагч болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар бүлэглэн довтолсон, эсэргүүцсэн;
- Төрийн тусгай хамгаалалтад байгаа, эсхүл бусад байгууллагын хамгаалалтад байгаа хүн, объектд бүлэглэн халдсан, халдахыг завдсан;
- Бусдын орон байр, эзэмшил газрыг бүлэглэн эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;
- Хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох гэмт хэргийг бүлэглэн үйлдэж байгааг таслан зогсоох, баривчлах;
- Галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн бүлэг зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;
- Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг, эсхүл нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хүч хэрэглэсэн жагсаал цуглааныг албадан тараах;
- Бүлэглэн оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах;
- Хорих анги, цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүссэн үед гэж тус тус заажээ.

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл гэх ба үүнд дараах хэрэгсэл хамаарна.

1/ Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч:

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх хамрын самсаа болон нулимсны булчирхайг цочроож нулимс ихээр гоожуулах хий, шингэн төлөв байдалтай бодисыг хэлнэ. /Гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно./

2/ Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх амьсгал боогдуулагч:

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх амьсгалын замын эрхтнээр дамжин уушгинд хүрч ханиалгах, амьсгал, хоолой боох үйлчлэл үзүүлэх зориулалт бүхий шингэн болон хийн төлөв байдалтай бодисыг хэлнэ.

3/ Усан хөөрөг:

Усыг өндөр даралтаар хүчтэй цацах төхөөрөмжийг хэлнэ.

4/ Утаан хөшиг үүсгэгч:

⁸⁹2018 оны 02-р сарын 25-ны өдөр шинэчлэн баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-504 “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам”-ын 2 дахь хэсэг

⁹⁰Цагдаагийн албаны тухай хуулийн 54-р зүйлийн 54.2 дахь заалт

Үзэгдэх орчныг хязгаарлах зорилгоор утаан хөшиг үүсгэх бодис /Гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно/ гэж тус тус тодорхойлжээ.⁹¹

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг цагдаагийн байгууллагын дарга, түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан⁹² гаргаж дараах журмаар хэрэгжүүлнэ.

- Шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хэрэглэх тусгай хэрэгслийн төрөл, тоо хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дараалал, эхлэх, дуусгах шийдвэрийг гаргах;
- Цагдаагийн алба хаагчийг хамгаалах тусгай хэрэгслээр хангах;
- Цаг хугацааны хувьд боломжтой бол прокурорт урьдчилан мэдэгдэх;
- Эмнэлгийн болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэх;
- Уг хэрэгслийн нөлөөлөх бүсэд байгаа жирэмсэн эмэгтэй, насанд хүрээгүй этгээдийг тухайн бүсээс холдох талаар тусгай хэрэгсэл хэрэглэхээс өмнө анхааруулах;
- Боломжтой бол тухайн тусгай хэрэгслийн үйлчлэх нөлөөллийн талаар анхааруулах;

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэр гаргадаг албан тушаалтан нь дараах үүргийг хүлээнэ.⁹³ Үүнд:

- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх хуульд заасан үндэслэл байгаа эсэхийг магадлан, тусгай хэрэгсэл хэрэглэх зорилгыг тодорхойлох
- Цаг агаарын байдал, салхины чиглэлийг харгалзан хэрэглэх тусгай хэрэгслийн төрөл, тоо хэмжээ, хүрээ, дэс дараа, тактикийг тогтоох
- Тухайн орчинд байгаа хүмүүст амьсгал боогдуулах, нулимс асгаруулагч, усан хөөрөг зэрэг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх гэж байгааг сануулж, тарж явахыг анхааруулах
- Алба хаагчдыг хамгаалах тусгай хэрэгслээр хангаж олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн бүсэд оруулах
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн тухай прокурорт мэдэгдэж, бичгээр танилцуулах
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн үйлчлэлээр нүд аргаж өвдөх, нулимс асгарах, амьсгаа давхцах шинж тэмдэг илэрч, амьсгалын замын багтраа өвчин, зүрхний эмгэг өвчтэй хүнд онцгой нөлөөлөх тул эмнэлгийн байгууллагын туслалцааг нэн даруй авах

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухай урьдчилан анхааруулахдаа тодорхой хугацаа зааж, чанга яригчаар зарлах зэрэг боломжтой аргыг хэрэглэнэ. Урьдчилан анхааруулснаас хойш заасан хугацаанд үйлдлээ зогсоогоогүй бол тусгай хэрэгсэл хэрэглэнэ.

Олон хүнд зэрэг нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа хэрэглэх шийдвэрийг гаргасан цагдаагийн байгууллагын дарга, эсвэл түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдсан албан тушаалтан нь холбогдох байгууллагатай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.⁹⁴ Үүнд:

- Хордсон хүн, амьтан, тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон аюултай бодис алдагдах, гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж, аюулгүй болгох;
- Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах;
- Орчныг ариутгах арга хэмжээ авах талаар холбогдох байгууллагад мэдэгдэх;
- Тусгай хэрэгслийн үйлчлэл дуусах, эсхүл үүссэн аюултай нөхцөл арилах хүртэл тухайн орчинд эргүүл, хамгаалалт гаргаж, зөвлөгөө, сануулга өгөх.

⁹¹Хууль зүйн сайдын 2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 2-р хавсралт "Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар"-ын 1.3 дахь хэсэг

⁹²Цагдаагийн албаны тухай хуулийн 54-р зүйлийн 54.1 дэх заалт

⁹³Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт

"Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар"-ын 4-р хэсгийн 4.2 дахь заалт

⁹⁴Цагдаагийн албаны тухай хуулийн 54-р зүйлийн 54.6 дахь заалт

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн үндэслэл, явц, үр дүн, хүний эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээ авсан тухай дэлгэрэнгүй илтгэх хуудсыг нэн даруй бичиж шууд захирах даргад, шууд захирах дарга нь дээд шатны байгууллагын даргад танилцуулна.

1. Усан хөөрөгт машин.

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг холбогдох албаны даргын тушаалаар томилогдсон дараах 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллуулна.⁹⁵

- Багийн ахлагч: Шуурхай удирдлагын штабын даргын шийдвэр, тусгай хэрэгсэл хэрэглэх бүлгийн даргын удирдлагад ажиллаж, багийн үйл ажиллагааг удирдана.
- Усан хөөрөгч: Усан хөөргийн төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцна.
- Оператор: Дуу, дүрс бичлэгийн төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцна.
- Техникч: Нулимс асгаруулагч, будагч бодис, усаар цэнэглэх, усны хоолойг холбох, салгах болон нөөц жолоочийн үүрэг гүйцэтгэнэ.
- Механик-жолооч: Машины техникийн аюулгүй ажиллагааг ханган ажиллана гэж тус тус заасан байна.

Багийн гишүүд бусад гишүүдийн үүргийг орлон гүйцэтгэх үр чадварыг эзэмшиж багаар ажиллах чадвартай байна. Багийн гишүүд болон нөөц хүчийг сард нэгээс доошгүй удаа сургалт, дадлага хийлгэнэ.

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийн бүхээгт багийн гишүүдээс өөр хүн оруулахыг хориглоно. Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг хамгаалалтын бүсийн дотор, гадна талд байрлуулж хэрэглэнэ. Усан хөөргийг жагсаал, цуглааны үед ашиглах тохиолдолд техникийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагааг хангах үүднээс хамгаалалтын тусгай бүлэг томилж ажиллуулна.

Усан хөөргийг +1°C хэмээс дээш дулаантай тохиолдолд ашиглана. Энэ нь усан хөөргөөр тоногдсон тээврийн хэрэгслийн бусад төхөөрөмжийг ашиглахад хамаарахгүй. Усан хөөрөгт тээврийн хэрэгслийн тасралтгүй ажиллагааг хангах ус тээвэрлэгч нөөц тээврийн хэрэгслийг цагдаагийн хамгаалалтад бэлэн байрлуулсан байна.

Усан хөөрөгт тээврийн хэрэгсэл ажиллаж байгаа газарт ойр байгаа усны эх үүсвэрийг ашиглаж болно. Усан хөөрөгт хуягласан тээврийн хэрэгслийн түрэх төхөөрөмжийг зам чөлөөлөх, учрах саадыг арилгах, гудам гаргах болон бусад зориулалтаар ашиглаж болно.

Усан хөөрөгт тээврийн хэрэгсэл, түүний бүлгийн ахлагч болон операторыг тус бүрд нь хэт богино долгионы радио станцаар хангасан байна. Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, будагчийг агаарын температур -10°C хэмээс дулаан үед хэрэглэнэ⁹⁶ гэж тусгайлан зааж өгчээ.

Усан хөөрөгт машины үзүүлэлт, хүчин чадал:

“Jinjin”-усан буу нь (JRS-6500) хөнөөлт бус өндөр үр дүнтэй нь батлагдсан нийтийн эмх замбараагүй байдал, хууль бус жагсаал, цуглааны үед ашиглах төхөөрөмж юм.

⁹⁵ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4.6 дахь хэсэг

⁹⁶ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4.17 дахь хэсэг



Энэ авто машин нь хамгаалалтын болон шийдвэрлэх үед тусламж үзүүлэх зориулалттай юм. Усан буу нь өндөр даралтат насосоор тоологдсон ба засвар үйлчилгээ хийх үед хялбар салгагдана.

Дээврийн буунууд нь хэвтээ чиглэлд 340 градусаар, босоо чиглэлд 80 градусаар дээд тал нь 60 м дотор хүчтэй буудна. Кабин дотор 5 хүний багтаамжтай ба бүх тоног төхөөрөмжийг тэд ажиллуулах бололцоотой.

Өндөр даралтад усан буу нь минутанд 2000 л/мин 14 бар-ын даралттайгаар шахах чадвартай. Уг машин нь дээрээ 6 ш, баруун талдаа 3ш, зүүн талдаа 3ш, доод талдаа 4 ш цорготой юм.

Кабин дээр байрлах буу нь автомат удирдлагаар дурын зүгт буудах чадвартай бөгөөд 6500 л багтаамжтай усны савыг түргэн хугацаанд дүүргэх ба юүлэх зориулалтаар тоноглогдсон юм.

Олон талын зориулалт бүхий уг автомашиныг бослого тараах, цэвэрлэгээ хийх, энгийн ард иргэдэд усны тусламж үзүүлэх зорилгоор хэрэглэж болох бөгөөд химийн /хөөс, нулимс асгаруулагч, будаг/ цацах боломжтой юм.

Бүрэн тоноглогдсон хяналтын самбараар хөдөлгүүрийн байдал, нэмэлт хөдөлгүүрийг хянахаас гадна бүх буу болон хавхлагуудыг хянах боломжтойгоос гадна түлхүүр багаж хийж болохуйц цоожтой хайрцагнуудтай.

Кабин дээрхи бууны хамт өндөр хүчин чадал бүхий гэрлээр давхар тоноглогдсон.

Ерөнхий тодорхойлолт

Тэнхлэг хоорондын зай	4650 мм
Нийт урт	7980 мм
Өргөн	2560 мм
Өндөр	3760 мм
Газраас хамгийн бага өргөгдсөн хэсэг	260 мм

Хүндийн жин

Цэвэр жин	9950 кг
Багийн гишүүд	325 /65*5/
Нэмэлт ачаа	6950 кг /ус, будаг, хөөс, хий/
Нийт жин	17225 кг

Өнгө

Чулуун саарал /stone gray/

Арал

Үйлдвэр	Tato Daewoo motor
Жолооны хүрд	Зөв талдаа
Хөдөлгүүр	DE 12TIS дизель, турботой, 6 цилиндртэй, усан хөргөлттэй
Дээд хүч	320hp/2100rpm
Дээд эргүүлэх хүч	135 кг. м/1260rpm
Хөдөлгүүрийн багтаамж	11051cc

Гүйцэтгэл

Дээд хурд	99 км/ц
Хамгийн бага эргэх радиус	8.5 м
Хүч дамжуулга	Механик /урагш 6 ухрах 1/
Урд тэнхлэг/даац/	6500 кг
Хойд тэнхлэг/даац/	11500 кг
Дугуй	6 ш /11.00-20-16 pr
Обуд	7,5v*20
Хүрдний механизм	Гидро
Тормоз	Хийн
Түлшний савны багтаамж	200 л, галаас хамгаалагдсан

Цахилгаан систем

Аккумулятор	12v-150amp/h*2
Динам	24v-60a
Стартер	24v-660kw

Кабин

Давхар кабинтай халдлагаас сэргийлж цонхыг торлосон хажуу болон дээд талыг хатуу гангаар хийсэн.

Камерын систем

Камер	Дижитал 220*22
Дэлгэц	7 инч өнгөт дэлгэц
DVR систем	500mb HD – тэй бичлэг хийх
	Арыг харах DSP 7 инч өнгөт дэлгэц
P.A систем	Чанга яригч болон дуут дохиотой
Кабины хөргөлт	A/C хөргөлт
Аюулгүйн гарц	Дээрээ 2 хаалгатай

Усны сав

Материал	Ган төмөр /sts304/ 4.0мм
Гагнуур	Аргон болон хийн
Багтаамж	6500 л усны цалгилтаас хамгаалагдсан тоноглолтой

Цэвэрлэх зориулалт бүхий нүхтэй

Зөөлөвч	Резин ба төмөр
Савны нүх	500мм
Усны түвшин хэмжигч	Датчик болон харж болохуйц
Ус дүүргэх холболт	Эрвээхэй хавхлага 2-1/2"
Сорох холболт	Эрвээхэй хавхлага 4"
Ус гаргах хоолой	Бөмбөгөн хаалт 2"
Усны сав дүүргэх	Гол цөөрөм нуур

Хөөсний сав

Багтаамж	150л
Материал	Ган төмөр /sts316/ 3 мм
Хөөс дүүргэлт	Савны амсар хүртэл
Хөөс юүлэх хавхлага	Бөмбөгөн хавхлага 3/4
Хөөсний түвшин үзэх	Датчик болон харж болохуйц

Нулимс асгаруулагчийн сав

Багтаамж	150 л
Материал	Ган төмөр /sts316/ 3 мм
Хөөс дүүргэлт	Савны амсар хүртэл
Хөөс юүлэх хавхлага	Бөмбөгөн хавхлага 3/4
Хөөсний түвшин үзэх	Датчик болон харж болохуйц

Будагны сав

Багтаамж	150 л
Материал	Ган төмөр /sts316/ 3 мм
Хөөс дүүргэлт	Савны амсар хүртэл
Хөөс юүлэх хавхлага	Бөмбөгөн хавхлага $\frac{3}{4}$
Хөөсний түвшин үзэх	Датчик болон харж болохуйц

Төвөөс зугтаах насосны тодорхойлолт /Centrifugal pump specification/

Төрөл	2 шаталбарт турбинтэй насос
Гүйцэтгэл	2650 л/мин8,5 bar 2000 л/мин 14 bar
Материал	Хайлш гантөмөр хүрэл
Эргэх чиглэл	Цагийн зүүний дагуу
Насосны систем	4 тасалгаа бүхий вакуум
Ажиллах нөхцөл	Араагаар /gear box/
Хяналт	Цахилгаан
Хүчдэл	24 v

Насосны хөдөлгүүр

Төрөл	4 циклийн турботой усан хөргөлттэй Дизель
Цилиндер	4
Багтаамж	3907 cc
Гарах хүч	125 hp/2600rpm
Дээд эргэлтийн хүч	40кг.м/1800rpm
Эргэх чиглэл	Цагийн зүүний эсрэг
Стартер	24v-5kw
Хэрэглээ	24v

Хөөс, нулимс аргаруулагч, будагны системийн хэсэг

Төрөл	Цорго хэсэг
Материал	Ni-Cr
Гүйцэтгэл	410-1050 л/мин 5 bar
Ашиглалтын систем	автомат

Бууны систем

Кабин дээрхи буу/баруун тал/	LP-2-1/2"/65A/
Цорго /диаметр/	29мм
Цацах хүрээ	40м-60м
Эргэх хүрээ	Хэвтээ 340 градус босоо - 45 аас +80 градус
Байрлал	Кабин дээр
Удирдлага	Хяналтын самбараас

Буфер дээрхи буу

Гүйцэтгэл	1000 л/мин 5 bar
Цацах хүрээ	30м-40м
Эргэх хүрээ	Хэвтээ 180% босоо 40-с +80%
Хяналт	Хяналтын самбараас

Хэвтээ буу

Гүйцэтгэл	400 л/мин 5bar
Цацах хүрээ	20 м
Эргэх хүрээ	45 градус
Бууны тоо	2 ш

Хамгаалалтын цорго

Цоргоны тоо

дээр 6 ш, доор 4 ш

Гүйцэтгэл

30 л/мин 5 bar

Материал

Хүрэл

Уг усан хөөрөгний автомашин нь хуяглагдсан, тусгай тоноглолтой, дээд хэсэгт үндсэн 2 ширхэг шүршигч буутайгаас гадна урд гуперийн хэсэгт шүршигч буугаар тоноглогдсон, 2 талын хажуу болон ар талдаа, мөн дээд доод хэсэгтээ 4-н усаар шүршигч клапантай.

Кабин дээр нь 150 литрийн багтаамжтай 3 ширхэг савтай бөгөөд тус савнуудад нулимс асгаруулагч, хөөс, будаг холигч элементийг хийхэд усанд өөрөө найруулагддаг, усны ёмкост нь зэвэрдэггүй гангаар хийгдсэн бөгөөд 6.5 тн усны багтаамжтай.

Хөдөлгүүр нь D6AV цуваа цилиндртэй, турбин дизель хөдөлгүүртэй. Шатахууны сав нь 200 литрийн багтаамжтай бөгөөд сайн түгжээ бүхий банк нь далд байрлахын зэрэгцээ галын аюулаас бүрэн хамгаалагдсан.

Кабин нь давхар кабинтайгаас гадна сайжруулсан төмрөөр хамгаалалт хийгдсэн, салхины болон хажуугийн шилнүүдийг торон хаалтаар хамгаалж тоноглогдсон байна.

Кабиндаа жолооч, хажуугийн туслах, ардаа 2 суудалтай, ТВ системтэй ба камер дүрс гаргах дэлгэц, дүрс бичлэг 24 цагийн турш хийгдэх боломжтой гэжээ.⁹⁷

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед усан хөөрөгт машин ашиглах арга зүй

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал идэвхижиж цагдаагийн байгууллага, алба хаагчийн тавьсан шаардлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих үр дүнгээ өгөөгүй, хяналтаас гарах нөхцөл бүрдсэн тохиолдолд үймээнд оролцогчдын үйлдлийг цаашид даамжируулахгүй, учирч болох хор уршгийг нэмэгдүүлэхгүй байлгах, тэдний хууль бус үйлдлийг таслан зогсооход усан хөөрөгт машин ихээхэн чухал үүрэг гүйцэтгэнэ.

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалд⁹⁸ заасны дагуу +1 хэмээс дээш дулаан үед ажиллуулах бөгөөд ЦЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан “Шуурхай удирдлагын штаб”-аас өгсөн үүрэг, чиглэл, захирамж, шийдвэрийн дагуу ажиллагаанд орно.

Уг усан хөөрөгт машиныг ажиллагаанд оруулах зорилго нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох ажиллагаанд оролцож буй алба хаагч, бүлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдалд оролцогч этгээдүүдийн хүчийг сарниан бутаргах, тарамдуулах, түүнчлэн Шуурхай удирдлагын штабын дэргэдэх түрэн гаргах, дайчлан баривчлах бүлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ.

Автомашиньг хэв журмын хамгаалалтанд зогсож байгаа цагдаагийн алба хаагчдын ар талд байрлуулж, жагсаал цуглаан болон эмх замбараагүй байдал үүсгэгчдийн бөөгнөрөл үүсч, нягтарсан хэсэг рүү дээврийн үндсэн бууг ашиглан 14-өөс дээш “bar”-ын даралтаар шүршиж, агшин зуур тараах ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

Түүнчлэн эмх замбараагүй байдал үүсгэж, цагдаагийн алба хаагчид руу дайрч, давшиж буй бүлэг этгээдүүдийн урд болон хажуу жигүүрээс нь усаар шүршиж, тэдний үйлдлийг сарниаж, хүчийг тарамдуулах арга хэмжээг тухайн нөхцөл байдлыг үнэлэн ажиллагааг удирдаж байгаа даргын шийдвэрээр түргэн шуурхай хийж гүйцэтгэнэ.

Гэхдээ ажиллагаанд оролцож байгаа бусад бүлгүүдийн үйл ажиллагаатай нарийн нягт харилцан уялдаатайгаар хэрэглэвэл үр дүнд хүрнэ.

Мөн эмх замбараагүй байдлын гол төв хэсэг рүү хүчтэй даралттай усаар шүршиж тараах бөгөөд сарнисан хэсгүүдийн хойноос дагаж шүрших байдлаар тэдний үйл ажиллагааг улам бүр тарамдуулах, улмаар дайчлан баривчлах, түрэн гарах бүлгүүдийн

⁹⁷ ЦЕГ-ын автобаазын инженер техникийн албаны 2009 онд JRC-6500B хуягт, усан хөөрөгний авто машин хүлээн авсан.

шалгасан тухай үзлэгийн тэмдэглэлээс хэсэгчлэн авав.

⁹⁸ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт

“Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”

үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана.

Гэхдээ усан хөөрөгт машин усаа хурдан хугацаанд шахдаг учир нөөц усны машинууд байнгын бэлэн байдалд байж, түргэн хугацаанд шуурхай цэнэглэж, дараагийн ажиллагаанд орох нөхцөл боломжийг бүрдүүлж өгөх хэрэгтэй.

Усан хөөрөгт машины дараагийн ажиллагаанд хэрхэн шилжих үүрэг даалгаврыг гагцхүү шуурхай удирдлагын штабаас өгөх учир бүлгийн дарга болон гишүүд үүрэг, чиглэл иртэл бие даан ямар нэг ажиллагаа явуулахыг хориглоно.

Түрэн гаргах бүлгийн үүрэг бол нийтийг хамарсан эмх замбараагүй байдалд оролцогсдыг голомтоос түрэн гаргах, тараах, үйл ажиллагааг нь тарамдуулах, тараах явдал юм.

Тухайн эмх замбараагүй байдал гарсан бүс, нутаг дэвсгэрийн байршил, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, тухайн үеийн цаг агаарын байдлаас хамаарч тусгай хэрэгсэл хэрэглэх бүлэгт шуурхай удирдлагын штабаас өгсөн шийдвэрийн дагуу усан хөөрөгт машиныг ашиглана.

Шуурхай удирдлагын штабаас шийдвэр гармагц тусгай хэрэгсэл хэрэглэх бүлгийн дарга усан хөөрөгт машиныг ашиглан эмх замбараагүй байдлын нягтарсан цөм хэсэг рүү шүршилт хийж, тэдний хүчийг тарамдуулах, үйл ажиллагааг нь сарниулсны дараа түрэн гаргах бүлэг эхэлж орон дараа нь татан гаргаж, салган тусгаарлах бүлэг ажиллагаанд орж тэднийг тараах ажиллагааг гардан гүйцэтгэнэ.

Усан хөөрөгт 2 машиныг эмх замбараагүй байдал үүсгэгчдийн 2 талаас нэгэн зэрэг, эсхүл нэг талаас нэгэн зэрэг шүршиж, хүчийг сарниулах, тарамдуулахыг уг ажиллагааг удирдаж байгаа шуурхай удирдлагын штабаас тандан судлах бүлгийн ирүүлсэн мэдээг үндэслэн шийдвэрлэнэ.

Нөгөө талаар усан хөөрөгт 2 машиныг нэгэн зэрэг ашиглах тохиолдолд жагсаал, цуглаанд оролцогчид болон эмх замбараагүй байдал үүсгэгчдийн 2 жигүүрээс эсвэл төв хэсгээс усаар шүршиж, дундуур нь зүсэлт хийн довтолж, хоёр хэсэгт хуваан хүчийг сарниулсаны дараа түрэн гаргах бүлэг хонгилоор довтолж, таслан хязгаарлах улмаар түрэн гаргах ажиллагааг явуулсны дараа татан гаргаж, салган тусгаарлах бүлэг, дайчлан баривчлах бүлгүүд ажиллагаанд орно.

2. Тусгай зориулалтын хуягт тээвэрлэгч.



Тусгай тоноглогдсон БТР /Байлдааны тагнуулын тээврийн хэрэгсэл/

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед утаан хөшиг үүсгэгч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар буудах үүссэн нөхцөл байдлыг сааруулах, тараах зориулалт бүхий тусгай тоноглогдсон БТР.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд цэрэг, цагдаагийн албанд зориулж үйлдвэрлэсэн нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар уснаа явагч зэрэг тээврийн хэрэгслийг ашиглаж болохыг өнөөгийн хууль тогтоомжоор зөвшөөрсөн байдаг.


Тусгай тоноглогдсон БТР хуягт тээвэрлэгчийг дараах зориулалтаар ашиглана гэж тусгайлан заасан байна.⁹⁹ Үүнд:

- Бүслэн хаах, таслан тусгаарлах, дайчлан баривчлах зэрэг бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Эвдэрсэн, гэмтсэн, хөдөлгөөнөө үргэлжлүүлэх боломжгүй тээврийн хэрэгслийг татан гаргах;
- Ажиллагаа явуулахад учрах саадыг арилгах;
- Тээврийн хэрэгсэл албадан зогсоох, замын хөдөлгөөний чиглэлд хязгаарлалт тогтоох, саад тавих;
- Үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай хүч хэрэгслийг тээвэрлэх, тусгай хэрэгсэл хэрэглэх;
- Тодорхой нутаг дэвсгэр, орон байранд орох, гарахад хяналт тогтоох;

Мөн нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар, уснаа явагч зэрэг тээврийн хэрэгслийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн нэмэлт тоног төхөөрөмжөөр тоноглож болдог байна.

Хуягт тээвэрлэгч нь багийн ахлагч, механик-жолооч гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Хуягт тээвэрлэгчийг ашиглахад хөдөлгөөний хурд нь бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахааргүй байхаар тооцоологдсон байна¹⁰⁰ гэж тусгажээ.

3. Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч бодисоор цэнэглэсэн гар гранат, буу

Зураг	Төрөл	Марк	Улс	Тайлбар
	Гар гранат	ДН-3М	БНСУ	Урт-110 мм Жин-160 гр Диаметр-53.5 мм Ашигтай тусгал-30-40 метр /2.0-0.5 секундэд/
	Гар гранат	-	БНХАУ	Жин –90 гр Газраар шидэж хэрэглэдэг. Улаан чинжүүны үнэр гаргадаг.
	Гар гранат	-	БНХАУ	Жин-90 гр Газраар шидэж хэрэглэдэг. Ойж тэсрэх байдлаар үйлчилдэг.

⁹⁹Хууль зүйн сайдын 2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 2-р хавсралт “Тусгай хэрэгсэл,биеийн хүч хэрэглэх заавар”-ын 4.1.1 дэх хэсэг

¹⁰⁰Хууль зүйн сайдын 2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 2-р хавсралт “Тусгай хэрэгсэл,биеийн хүч хэрэглэх заавар”-ын 4.1.4 дэх хэсэг

	Сум шидэгч	DHML-2	БНСУ	DHML-2 Launcher сум шидэгч цахилгаан буу /25 ⁰ налуугаар буудахад 70 м, 30 ⁰ налуугаар буудахад 80м, 35 ⁰ налуугаар буудахад 90м, 40 ⁰ налуугаар буудахад 100 м-ийн тусгалтай, 12 цаг цэнэглэж 24 цаг ашиглах/, DHML маркийн хийн сум /
	33 мм хийн сум	DHML-2M	БНСУ	Урт-152 мм Жин-102 гр Диаметр-53.5 мм Ашигтай тусгал-70-100 метр /3-5 секундэд үйлчилнэ./
	Өнгөт утаа гаргагч	DH-12	БНСУ	Жин-150 гр 30-60 метр тусах дохио өгөх боломжтой. Цэнхэр, ногоон, ягаан, шар өнгө гаргадаг.
	Хийн буу	DH 101A	БНСУ	Жин- 1.6 кг Эвхдэг мөрлөгчтэй. 3 төрлийн сумаар будна. Ашигтай тусгал 70-150 метр
	38 мм хийн сум	DH-38M	БНСУ	Урт-120 мм 2.7-0.5 секундэнд 80-100 метр тусах чадвартай. Агаараар буудаж хэрэглэнэ.
		DH-38S	БНСУ	Урт-123 мм 2.7-0.5 секундэнд 80-100 метр тусах чадвартай. Газраар буудаж хэрэглэнэ.

Дүгнэлт

Цагдаагийн албан хаагч нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлэх явцад хууль бус жагсаал цуглааныг албадан тараах, бүлэглэн танхайрах явдлыг таслан зогсоох, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх нөхцөл байдал бий болох, хориотой арга хэрэгсэл ашиглан төрийн төлөөлөгчийн тавьсан шаардлагыг зэвсэглэн эсэргүүцэх зэрэгт ердийн арга хэрэгсэл ашиглан тодорхой

үр дүнд хүрээгүй тохиолдолд хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг зохих журмын дагуу тухайн нөхцөл байдалд ялгамжтай байдлаар хэрэглэдэг байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлийн үед олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын үнэлгээ хийж бодит үндэслэл байгаа эсэхийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Түүнчлэн хүрээлэн байгаа орчин, эрсдэл бий болох нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлох, хэрэглэсний дараа гарч болох үр дагаварыг тооцоолон төлөвлөгөө гарган ажиллана.

Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр байгуулагдсан шуурхай удирдлагын штабын даргын зөвшөөрөлгүйгээр жагсаал цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын үед галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.

Эх сурвалжийн жагсаалт

- Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.02.09
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /шинэчлэн баталсан/ 2018.02.25. Код-504 “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам
- ХЗДХ-ийн сайд, УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
- Хууль зүйн сайдын 2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 2-р хавсралт “Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”
- ЦЕГ-ын автобаазын инженер техникийн албаны 2009 онд JRC-6500В хуягт, усан хөөрөгний авто машин хүлээн авсан, шалгасан тухай үзлэгийн тэмдэглэл

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Д.Энхбаяр

ДХИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас хийх ажлын удирдлага, зохион байгуулалтын талаар судалж, түүнийг сайжруулахад чиглэсэн дүгнэлт боловсруулж, санал дэвшүүлсэн.

Түлхүүр үг: цагдаагийн байгууллага, гэмт хэрэг, удирдлага, зохион байгуулалт

Монгол Улсын Засгийн газрын 1923 оны 18 дугаар хурлаар “Цагдан сэргийлэхийн эрх хэмжээний дүрэм”-ийг баталж, цагдаагийн үүргийг: “Гэмт хэрэгтэй тэмцэх, хууль, дүрмийн биелэлтэд хяналт тавих, хэв журам, ариун цэврийг сахиулах, гарсан хэрэг, зөрчилд арга хэмжээ авах, элчин, консулыг хамгаалах, эргүүл, манаа хийх, гал түймрийг сэргийлэх, сөнөөх явдал” гээд Засгийн газар, олон яамдаас зааж, тушаасан нэмэгдэл үүргийг биелүүлэхээр заасан байна.¹⁰¹

1940-1960 онд Цагдан сэргийлэх байгууллага шинэ Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор хүний амь, дээрэм, хулгай, өмч ашиглах, дамын наймаа хийгчид, танхайрагчид, хууль ёс зөрчигчидтэй тэмцэх, иргэдийг паспортжуулах, гэр бүлийн байдлыг бүртгэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албыг бэхжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ирсэн.

Мөн 1960-1990 онд Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт өргөжин төрөл мэргэжлийн албадтай болж, тэдгээрийг мэргэжлийн удирдлага, ажлын уялдаа холбоогоор хангаж, мэргэшүүлэх ажилд түлхүү анхаарч, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд техник хэрэгсэн, шинжлэх ухааны ололт, тэргүүн туршлагыг нэвтрүүлж, материаллаг бааз нь улам бэхжсэн гэж үздэг.

Улсын Их Хурлаар 1993 онд “Цагдаагийн байгууллагын тухай хууль” баталсан нь үйл ажиллагаагаа хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмаар явуулах эрх зүйн үндэс бүрдэж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны бие даасан байгууллага болсон юм.

Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, хуулийн хэрэгжүүлэлтийг сайжруулах зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2002 онд батлан гаргасан Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу цагдаагийн байгууллагад хэрэг бүртгэх ажиллагаа төвлөрч, эрүүгийн цагдаа, мөрдөн байцаах албадын ажлын чиг үүрэгт өөрчлөлт орсон төдийгүй албаны шуурхай бэлэн байдал дээшилж, техник, тусгай хэрэгслийн хангамж, хүрэлцээ, холбооны техник хэрэгслийн хүчин чадал нэмэгдсэн.¹⁰²

Монгол Улсын Үндсэн хуулинд “төр нь хүний эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх үүргийг иргэдийнхээ өмнө хариуцна¹⁰³”, мөн “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх¹⁰⁴” тухай тус тус заасан. Түүнчлэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, тал бүрийн арга хэмжээгээр дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажил хийгдэж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ гэдэг гэмт хэрэгтэй тэмцэх ажлын гол цөм нь байх учиртай. Аливаа өвчнийг туссан хойно нь эмчилж эдгэрүүлнэ гэдэг эрсдэл ихтэй, их цаг зардал, тэсвэр тэвчээр шаарддагтай адил гэмт хэрэг гарсан хойно нь түүнийг таслан зогсоож, олж илрүүлэхээс илүүтэй урьдчилан сэргийлэх, угтаж сэрэмжлэх нь юу юунаас чухал билээ.

¹⁰¹ <https://zasag.mn/news/view/1228>

¹⁰² Баярсайхан М. Эрүүгийн болон мөрдөн байцаах албадын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтын асуудал. УБ., 2017

¹⁰³ Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. 1992.№1. 19 дүгээр зүйл 19.1


¹⁰⁴ Мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.7

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил бол зөвхөн цагдаа, хууль сахиулагчдын ажил мэтээр ойлгох нь өрөөсгөл. Энэ ажилд өргөн олны оролцоог хангаж, тэдний дэмжлэг туслалцааг авч байж сая бүрэн үр дүнд хүрнэ. Мөн хоосон таамгаар, холыг харсан бодлого зорилтгүйгээр хол явахгүй.

Монгол Улсын Их Хурлаас Цагдаагийн албаны тухай /шинэчлэн найруулсан/ хууль, Засгийн газраас Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, зарим төрлийн гэмт хэргүүдтэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийг тус тус батлан гаргаж, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээг зохион байгуулж байна.

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг нэгтгэн зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгж нь Тэргүүн дэд даргын удирдлагад харьяалагдаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулан, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжилт үр дүнг тооцон цагдаагийн төв байгууллагын даргад тайлагнадаг бөгөөд Мэдээлэл нэгтгэн боловсруулах ажил хариуцсан нэгж нь гэмт хэрэг, зөрчилд судалгаа дүн шинжилгээ хийж Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгжийг мэдээллээр ханган ажилладаг.

Энэ ажлын үр дүн ч эхнээсээ гарч эхэлж байна. Урьдчилан сэргийлэх ажил гэмт хэрэгтэй тэмцэх үйлсэд ямар чухал ач холбогдолтой болох нь ч харагдаж байна. Ганцхан жишээ хэлэхэд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, хохирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 1993 хэргээр буюу 13,3 хувиар, нийслэлийн хэмжээнд 1761 хэргээр буюу 17,5 хувиар буурсан байна.
